**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 03 өдөр Дугаар 46 Есөнбулаг сум

Аймгийн Засаг даргын үйл
ажиллагааны хөтөлбөрт үнэлэлт, дүгнэлт
өгөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2025 оны хэрэгжилтийг 93.9 хувьтай үнэлж “*Үр дүнтэй* ” гэж дүгнэсүгэй.

2.Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, биелэлт хангалтгүй арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэн, шаардлагатай төсвийг тухайн жилийн төсөвтөө тусган ажиллахыг аймгийн Засаг дарга (Г.Чинбат)-д даалгасугай.

ДАРГА Д.НАСАНБУЯН

**ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ**

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТ**

2025.11.25 Есөнбулаг

| д/д | ЗДҮАХ-т тусгагдсан үйл ажиллагаа | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Суурь түвшин | Хэрэгжилт 2025 он: Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хэрэгжилт 2025 он: Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | |
| **1.1.Говь-Алтай аймгийн иргэдийг эрүүл, ая тухтай орчинд ажиллаж, амьдрах, сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлж, "Хүний хөгжлөөр улсдаа тэргүүлэх" зорилтыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | | |
| **1.1.1.Нийгмийн бүхий л орчинд хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллыг дэмжин, салбар дундын уялдааг хангана.** | | | | | | | | | | |
| 1 | 1.1.1.1.Хүүхдийн сайн сайхан байдлыг хангаж, гэр бүл төвтэй, салбар дундын хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхдийн эрхийг дээдлэн хөгжил, оролцоо, авьяас, ур чадварыг хөгжүүлж, эрсдэлгүй орчинд хүүхэд бүрийг тэгш | 1 | Хорт зуршил, дэлгэцийн донтолт электрон тамхины эсрэг аян хөдөлгөөн өрнүүлнэ. | 2025 | ХГБХХГ | УТ-6.3 Төсөл хөтөлбөр-8.2 | 50 | Хамрагдалтын хувь-70 | “Өсвөр үе-Эрүүл мэнд”, “Бяцхан алхам-том өөрчлөлт”, “Сургуулийн орчин дахь асуудал”, “Мэдлэгээ хэрэглээ болгоё”, “Үе тэнгийн сургагч багш бэлтгэх", “Youth power-Говь-Алтай” байгальд ээлтэй хүүхэд чуулган, "Хүүхэд-Хайр-Ирээдүй" зөвлөгөөн, "Хүүхэд, хүүхдэдээ ээрэгээр нөлөөлье" зэрэг 12 төрлийн сургалт, нөлөөллийн ажилд давхардсан тоогоор 4500 гаруй хүүхэд хамрагдлаа. Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлыг хангах, өсвөрийн 18 клубт 270 гаруй хүүхэд хамрагдан, бусаддаа цахим орчны зөв зохистой хэрэглээний талаар мэдлэг, мэдээллийг түгээн ажиллаж байна. Нийт 5000 хүүхэд хамруулахаас 4770 хүүхэд хамрагдаж, хамрагдалт 95.4 хувьтай байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжүүлж, төлөвшүүлэх нөхцөлийг бүрдүүлж, зүрх сэтгэлийн боловсрол олгоно. | 2 | Хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж кейс менежментийн үйлчилгээг үзүүлнэ. | 2025 | ХГБХХГ | | 50 | Хамрагдалтын хувь-70 | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 68 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 3470 хүнийг хамрууллаа. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээг 28 хүүхдэд үзүүлж, 6 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр томилогдон ажиллаж байна. Тус хороо нь нөхцөл байдлын үнэлгээ-5, аюулгүй байдлыг хангах-2, сэтгэл зүйн зөвлөгөө-19, хууль эрх зүйн зөвлөгөө-12, амьдрах ухааны болон эрүүл мэндийн сургалт-23, өмгөөллийн үйлчилгээ-3, шууд туслалцааг 8 хүүхдэд үзүүллээ. Эрүүл мэнд, амьдрах ухааны чадвар олгох, хууль эрх зүйн сургалтыг сургалт хүмүүжлийн ажлын төлөвлөгөөний дагуу хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 28 хүүхдэд Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Залуучуудын хөгжлийн төв, Хүүхэд, залуучуудын ордны дэргэдэх гэр бүлд зөвлөгөө өгөх төвийн сэтгэл зүйчтэй хамтран зөвлөгөө үйлчилгээнд хамруулж, сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг танхимын хэлбэрээр зохион байгуулан, асран хамгаалагч нараар нь дамжуулан хяналт тавин ажилллалаа. Хүүхэд хамгааллын зардлаас 989,4 мянган төгрөгийн хамгааллын хариу үйлчилгээг үзүүллээ. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд давхардсан тоогоор 26662 хүүхэд оролцсон бөгөөд кейс менежментийн үйлчилгээнд эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн 83 хувь нь хамрагдан хамгааллын үйлчилгээ аван ажиллаж байна. | 100 |
| | | 3 | Эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн тоог бууруулж, урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээ үзүүлнэ. | 2025 | ХГБХХГ | | 2126 | Эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн тоо-2060 | Эрсдэлийн программд 183 хүүхдийг шинээр бүртгэснээр программд нийт 921 хүүхэд бүртгэгдлээ. Хамгаалал шаардлагатай 2623 хүүхэд байгаагаас 280 хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийн анхан шатны багц олгож, 543 хүүхдэд хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлж, 56 хүүхдийг хамгааллын үйлчилгээнд холбон зуучилж, хамтарсан багаар ажиллалаа. Эрсдэлт нөхцөл дэх 66 хүүхдийг шинээр илрүүлэн бүртгэж хамгааллын үйлчилгээ үзүүлэн ажилласан байна. 566 хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийж шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэн кейсийг хаасназр эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн тоо 2057 байна. | 100 |
| | | | | | | | 4825 | Хамрагдсан хүүхдийн тоо 5126 | Хүүхдийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийг илрүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр 38 ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 11331 хүн, 24658 хүүхдийг хамрууллаа. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 4 | "Хамтын шийдэл-Хамгаалагдсан ирээдүй" арга хэмжээг боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллана. | 2025 | ХГБХХГ | | 0 | Хэрэгжилтийн хувь-10 | Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр төрөөс баримталж буй бодлого шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах, салбар дундын уялдаа холбоог сайжруулж, дэмжих зорилгоор "Хамтын шийдэл – Хамгаалагдсан ирээдүй" хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийг 4 зорилт, 26 үйл ажиллагаа, 27 шалгуур үзүүлэлттэйгээр аймгийн ИТХ-ын 2025 оны 37 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна. | 100 |
| | | 5 | Хүүхдийн төлөө зөвлөл, хамтарсан баг эцэг эхийн зөвлөл, хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагаанд мониторинг хийж арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | 2025 | ХГБХХГ | | 4 | Мониторинг хийх ажлын тоо-1 | Аймгийн 14 сум, 1 тосгонд хүүхдийн төлөө зөвлөл, хамтарсан баг, эцэг эхийн зөвлөл, хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагаанд хяналт тавьж зөвлөн тусалж ажилласан. Аймгийн хэмжээнд 138 "Эцэг эхийн зөвлөл" ажиллаж, хүүхэд хамгааллын бодлоготой 130 байгууллага, хүүхдийн өрөөтэй 18 байгууллага байна. Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан 19 нийгмийн ажилтан сум, багийн хамтарсан багийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулан чиглүүлж байна. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх үндэсний хэмжээний болон чадавхжуулах орон нутгийн 6 удаагийн сургалтад давхардсан тоогоор 168 нийгмийн ажилтан, "Эцэг эхийн зөвлөл"-ийн 204 гишүүн, гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтад 2877 хүн хамрагдлаа.<br>Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 10 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 10, гэр бүлийн хүчирхийллийн зөрчил 37 бүртгэгдсэн. Хамтарсан багууд 56 дуудлага мэдээллийн дагуу аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээг 13, эмнэлгийн тусламж үйлчилгээг 4, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг 21, нийгмийн халамжийн үйлчилгээг 5, хүүхэд хамгааллын үйлчилгээг 69, эрх зүйн туслалцаа үйлчилгээг 11, холбон зуучлах үйлчилгээг 12 хүнд, нийт 7 төрлийн үйлчилгээг 124 хүнд үзүүлэн ажилласан. Нийт 29 кейсийг шийдвэрлэж, 27 кейс дээр үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 6 | Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан гэр бүлд чиглэсэн нийгмийн ажил үйлчилгээний орон нутгийн зураглал гаргах, архинд донтох эмгэгтэй иргэд тэдний гэр бүлд чиглэсэн олон талт нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2025 | ХГБХХГ | | 10 | Хамрагдсан гэр бүлийн хувь-15 | “Гэр бүлд зөвлөгөө өгөх төв”-ийн нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хүүхэд 91, насанд хүрэгч 62 нийт 153 хүнийг хамрууллаа. Гэр бүлийн боловсрол олгох сургалтад 1240, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх 25 удаагийн албадан сургалтад 90, “Хоригдол суллахад бэлтгэх хөтөлбөр”-т тусгагдсан арга хэмжээний хүрээнд 33 удаагийн сургалт, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг 7 хоног бүр 4 хоригдолд үзүүлэн ажиллалаа. Гэр бүлийн боловсрол олгох сургалт нөлөөллийн арга хэмжээнд нийт өрхийн 15.2% буюу 2500 гэр бүлийг хамруулсан байна. | 100 |
| | | | 7 | Гэр бүлийн боловсрол олгох сургалт нөлөөллийн хөтөлбөрийг малчин залуу гэр бүлүүдэд зохион байгуулна. | 2025 | ХГБХХГ | | 320 | Хамрагдсан гэр бүлийн тоо-400 | Гэр бүлийн эерэг харилцааг бий болгох, эцэг эхийн хамтын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, өрх бүр угийн бичиг хөтлөх, гэр бүлийн боловсролоор дамжуулан гэр бүлийн хөгжил, хамгаалал, оролцоог бэхжүүлэх зорилгоор “Гэр бүл – Гэрэлт ирээдүй” сарын аянг аймгийн хэмжээнд зохион байгуулж, 17 төрлийн арга хэмжээнд 3260, гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 6532 хүнийг хамрууллаа. Гэр бүлийн боловсрол олгох сургалт нөлөөллийн хөтөлбөрт нийт 2500 гэр бүл хамрагдсанаас 500 малчин залуу гэр бүл байна. | 100 |
| | | | 8 | Түр хамгаалах байрыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг дэмжин ажиллана. | 2025 | ХГБХХГ | ОНТ 119,0 | 0 | Дэмжлэгийн тоо-1 | Япон Улсын Засгийн газрын “Өвсний үндэс” буцалтгүй тусламжаар баригдсан “Түр хамгаалах байр”-ыг 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авч, аймгийн Засаг даргын 2025 оны А/44 тоот захирамжаар бүтэц орон тоог 5-аар батлан, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний зардлыг орон нутгийн төсөвт тусган, үйл ажиллагааг хэвийн явуулж байна. Оны эхний 10 сарын байдлаар хүүхэд 25, насанд хүрэгч 5, нийт 30 хүнийг аюулгүй байдлын хамгаалалтад авч, үйлчилгээ үзүүлэн, хохирогчийг гэр бүлд нь эргэн нэгтгэж ажиллалаа. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | 1.1.1.3 Хүүхдийн эрхийг дээдлэн, аюулгүй, тэгш хүртээмжтэй, тав тухтай орчинд бие даан суралцах нөхцөлийг бүрдүүлэн, хөгжил, оролцоо, авьяас, ур чадварыг хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагуудыг дэмжиж, хамтран ажиллана. | 9 | Хүүхдийг аюулгүй, тав тухтай орчинд бие даан сурч, хөгжих нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр төр, төрийн бус байгууллагууды г дэмжиж, хамтран ажиллана. | 2025 | ХГБХХГ | ОНТ-60.1 | 5 | Дэмжиж ажилласан байгууллагын тоо-6 | Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр Дэлхийн зөн ОУБ, "Нар хүссэн яргүй" ТББ, хүүхдийг ивээх сан зэрэг байгууллагуудтай тогтмол хамтран ажиллаж байна. Бага насны хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх чиглэлээр “Цодгор хүү”, “Уран жиргээ” тэмцээнүүдийг зохион байгуулахад 3.4 сая, аймгийн Эмэгтэйчүүдийн холбоотой хамтран “Ээж ментор” сургалт нөлөөллийн үйл ажиллагааг 500 хүнийг хамруулан зохион байгуулахад 4.5 сая, "Ид шидийн орон" хүүхэд хөгжил, хамгааллын төвийн үйл ажиллагаанд 45.0 сая, скаутын холбоонд бүлгийн удирдагч бэлтгэх анхан шатны сургалтад оролцоход 3,4 сая, хүүхэд хөгжлийн “Майхант цугларалт” арга хэмжээнд оролцсон аймгийн хүүхдийн төлөө зөвлөлд 1,8 сая, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар комисст 2,0 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүллээ. | 100 |
| | | 10 | "Засагт ханы хот айл гэр зуслан”-г сумдад байгуулж, монгол ахуй, ёс заншил, амьдрах ухаанд сургах зуслангийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2025 | ХГБХХГ | | 200 | Хамрагдсан хүүхдийн тоо-250 | Засагт ханы хот айл зусланг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж, 390 хүүхэд хамрагдсанаас зорилтот бүлгийн 110, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 27 хүүхэд байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 11 | Хүүхдийн хөгжил оролцоо, авьяас ур чадварыг хөгжүүлэх дугуйлангийн тоог нэмэгдүүлж, үйл ажиллагааг сайжруулна. | 2025 | ХГБХХГ | УТ-34.5 ОНТ-268.0 ХХО-10.0 | 325 | Хамрагдсан хүүхдийн тоо-350 | "Цодгор хүү", модон барилдаан, уран жиргээ, "Өсвөрийн аврагч-2025", "Хүүхэд хамгаалал миний нүдээр" эссэ бичлэг, зургийн уралдаан гэх мэт 28 төрлийн тэмцээн, уралдааныг зохион байгуулж нийт 1403 хүүхэд оролцлоо. ХГБХХГ-ын дэргэдэх 11 төрлийн сургалт, дугуйланд 375 хүүхэд хамрагдаж байна. Хүүхдийн хөгжил оролцоог сайжруулах, дэмжих, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд аймгийн хэмжээнд урлаг, соёл, спорт, оюун ухааны чиглэлээр сургалт, дугуйлангийн үйл ажиллагаа явуулж буй багш, дасгалжуулагчидтай уулзалт зохион байгуулж, шинээр гарсан хууль тогтоомж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар санал солилцлоо. Сургалт, дугуйлангийн үйл ажиллагааг сурталчлан таниулах өдөрлөг зохион байгуулж, 500 гаруй хүнд мэдээлэл хүргэлээ. Ирээдүйн чадварлаг инженерүүдийг бэлтгэх зорилготой "Unitel STEAM HUB" сургалт нь төрлөө нэмж робот, олон улсын тэмцээнтэй дрон, кодчилол, цахилгаан хэлхээ, электроник, роботын чиглэлээр шинээр 5 төрлийн сургалт хичээллэж сургалтын хэрэглэгдэхүүнээр ханган ажиллалаа. | 100 |
| | | 12 | Аймгийн Хүүхдийн чуулганыг зохион байгуулна. | 2025 | ХГБХХГ | | 250 | Хамрагдсан хүүхдийн тоо-300 | Аймгийн хүүхдийн чуулганыг "Оролцонгоо хөгжье" уриан дор 2025 оны 04 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулж, 285 хүүхэд хамрагдлаа. Хүүхдүүд өөрсдийн санал бодол, орон нутагтаа хүүхдүүдийн өмнө тулгамдаж буй асуудлуудаа хэлэлцэн, шийдвэр гаргагч түвшний хүмүүст танилцууллаа. | 70 |
| 4 | 1.1.1.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бие даан амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх эерэг хандлагыг төлөвшүүлнэ. | 13 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бие даан амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлж, хариу үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. | 2025 | ХГБХХГ | | 40 | Үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо-50 | Аймгийн хэмжээнд анх удаа 18 сумын хөгжлийн бэрхшээлтэй, онцлогтой хүүхдүүдэд мэргэжлийн багийн үзлэг, оношилгоо хийж, эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө мэдээлэл хүргэлээ. Үзлэгээр хэл засалд 30, хөдөлгөөн засалд 24, сэргээн засахад 36, үнэлгээнд 42, сэтгэл зүйн засалд 41, нийт давхардсан тоогоор 180 хүүхэд үйлчилгээнд хамрагдлаа. Нийт 279 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас эрэгтэй 171, эмэгтэй 108, өвчний төрлөөр ангилбал сэтгэц, мэдрэл, оюун ухааны бэрхшээлтэй 105, хавсарсан бэрхшээлтэй 52, харааны бэрхшээлтэй 16, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй 13, хөдөлгөөний бэрхшээлтэй 22, бусад бэрхшээлтэй (мэс заслын дараах, дотрын өвчин) 71 хүүхэд, насны бүлгээр авч үзвэл 0-6 хүртэлх насны 68, 7-15 хүртэлх насны 153, 16-18 хүртэлх насны 58 хүүхэд байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 14 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхийн холбооны үйл ажиллагааг идэвхжүүлэн, санал санаачилгыг дэмжин хамтран ажиллана. | 2025 | ХГБХХГ | | 8 | Зохион байгуулсан ажлын тоо-10 | "Ээлтэй хүүхэд" холбоо ТББ-ын санаачилгаар "Гэр бүл- Гэрэлт ирээдүй" гэр бүлийн сарын аяны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын амьдралын чанарыг дээшлүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч, тэдэнтэй ажилладаг мэргэжилтэн албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлэх, хүүхдүүдийг нарийн мэргэжлийн үзлэг оношилгоо, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хамруулах, "Бэрхшээлийг боломж болгоё" нөлөөллийн үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн "Зөвлөх баг"-тай хамтран зохион байгуулж, 132 хүнийг хамруулллаа. ЕБС, СӨБ-ын нийгмийн ажилтан, багш нар, сэтгэл зүйч, нэгдсэн эмнэлгийн эмч, салбар комиссын гишүүд, эцэг эхчүүдэд "Хөгжлийн бэрхшээлийн талаарх ерөнхий ойлголт", "Тэгш хамралт, дэмжлэгийн баг ажиллах тухай", "Ганцаарчилсан болон бүлгийн төлөвлөгөө боловсруулах арга зүй", "Сэргээн засах эмчилгээ, хөдөлгөөн заслын үйлчилгээний ач холбогдол" сэдвүүдээр чадавхжуулах сургалтыг танхим болон бүлгийн хэлбэрээр зохион байгуулж 180 хүнийг хамрууллаа. 12 сард хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд 3 арга хэмжээ зохион байгуулна. | 70 |
| | | 15 | Хүүхэд хүүхдэдээ туслах хөдөлгөөнийг өрнүүлэн, эрсдэлт нөхцөл дэх хүүхдэд туслах үйл ажиллагааг дэмжинэ. | 2025 | ХГБХХГ | | 180 | Хамрагдсан хүүхдийн тоо-190 | Өсвөр үеийнхний сайн сайхныг дээшлүүлэхэд салбар хоорондын хамтын ажиллагааг өрнүүлж, өсвөр үе, залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох, сургагч хүүхдүүдээр дамжуулан өсвөр үеийн хүүхдүүдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн арга хэмжээг хүүхэд хүүхэддээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор "Үе тэнгийн сургагч" бэлтгэх сургалтыг 2025 оны 04 сарын 12-13-ны өдрүүдэд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Нар хүссэн яргуй НҮТББ, Дэлхийн Зөн Монгол ОУБ хамтран зохион байгуулж 34 үе тэнгийн сургагч сурагчийг бэлтгэсэн. Сургагч багшаар бэлтгэгдсэн сурагчид 193 хүүхдэд сургалт зохион байгуулсан. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 16 | Хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн хүүхдүүдийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулж, үйл ажиллагаанд оролцуулан, дэмжлэг тусламж үзүүлнэ. | 2025 | ХГБХХГ | | 100 | Хэрэгжилтийн хувь-100 | Аймгийн Засаг даргын захирамжаар бүтэн өнчин 29 хүүхдэд 16.5 сая төгрөгийн хичээлийн хэрэгсэл, дулаан хувцасны тусламж үзүүллээ. "Макс" группээс бүтэн өнчин 31 хүүхдэд хадгаламж гардууллаа. "Номтой нөхөрлөе" үйл ажиллагааг "Жангар" нийтийн номын сантай хамтран зохион байгуулж 62 хүүхдэд дархлаа дэмжих багц, 15 иргэнд гэрээр ном олгох үйлчилгээ үзүүллээ. "Найрамдал", "Даян-Очир", "Өвгөн жаргалант"зусланд бүтэн өнчин 8, хөгжлийн бэрхшээлтэй 8, амьжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой өрхийн 17, өрх толгойлсон өрхийн 2, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 2, архины хамааралтай өрхийн 3, нийт 40 хүүхэд хамруулж нийгмийн идэвх оролцоог дэмжлээ. | 100 |
| | | 17 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулагдсан дэд бүтэц, барилга байгууламжийн тоог нэмэгдүүлж, ээлтэй орчинг бүрдүүлнэ. | 2025 | ХГБХХГ | | 32 | ХБХ-д зориулагдсан дэд бүтэц, барилга, байгууламжийн тоо-40 | Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан стандандартад нийцсэн налуу шаттай 34, тусгайлан тоноглосон ариун цэврийн өрөөтэй 6 байгууллага байна. | 100 |
| **1.1.2.Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал, оролцоог сайжруулна.** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | 1.1.2.1.“Ахмадын холбоо, сувилал"-ын барилгыг ашиглалтад оруулж, ахмад настанд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хөгжил оролцоог дэмжин ажиллана. | 18 | Ахмад настанд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, ахмадуудтай хамтран хөгжил оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллана. | 2025 | ХХҮГ | ОНТ-196,44 | 20 | Ахмад настны хөгжил оролцоон ы хувь-25 | Ахмадын хороотой гэрээ байгуулан ахмад настнуудад мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгаа, хүндэтгэлийн болон нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж, тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллаж, орон нутгийн төсвөөс 150.1 сая төгрөгийн санхүүжилт олгон, үйл ажиллагааг байнга дэмжин ажиллаж байна.Засгийн 2024 оны 234 дүгээр тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд мэдээлэл сургалтыг төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтэд зохион байгуулж, 855 хүн хамрагдлаа. Олон улсын ахмадын баярыг тохиолдуулан "Ахмадаа хүндэлье" өдөрлөгт 92, аймгийн ахмадын спортын бага наадамд 5 төрлөөр 620, ахмад настны эрүүл идэвхтэй насжилтыг дэмжих цогц үйлчилгээнд 418, асаргаанд 1361, 7 хоног бүрийн 4 дэх өдөр нийтийн бүжиг зохион байгуулж давхардсан тоогоор 1002, Биеийн тамир спортын газарт өглөөний дасгал хөдөлгөөнд 10 сарын байдлаар давхардсан тоогоор 2840, "Говь-Алтай 80+" хөтөлбөрийн хүрээнд эрт илрүүлэг, явуулын эмнэлгийн үйлчилгээнд 458, нийт дээрх үйл ажиллагаанд давхардсан тоогоор 7646 ахмад настан хамрагдлаа. | 100 |
| | | 19 | “Ахмадын холбоо, сувилал"-ын барилгыг ашиглалтад оруулж шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоор хангана. | 2025 | ХХҮГ | - | | Барилгын ажлын гүйцэтгэл-100% | Улсын төсвийн 3,8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр “Ахмадын хөгжлийн ордон”-ы барилгын ажлыг “БГБС” ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд ажлын явц 50%-тай, 2026 оны улсын төсөвт 990.4 сая төгрөгийг тусгалаа. | 50 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | 1.1.2.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг бусдын адил бизнес эрхлэх, сурах, хөдөлмөрлөх боломжоор хангаж, тэдний хэрэгцээнд нийцсэн олон талт мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ. | 20 | "Говь-Алтай 80+" хөтөлбөрийн хүрээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээгээр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, зорилтот бүлгийн иргэдийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг үзүүлнэ. | 2025 | ХХҮГ | | 133 | Үйлчилгээнд хамрагдсан иргэний тоо-150 | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх үйлчилгээний гүйцэтгэгчээр “Даши асаагч” ХХК шалгарч, 81,6 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгууллаа. Төслөөр амьдрах ухаан, эрүүл мэнд, эрх зүй, санхүүгийн боловсрол олгох нөлөөллийн сургалтад 50 өрхийн иргэдийг хамруулж, 35 өрхөд тоног төхөөрөмжийн буцалтгүй дэмжлэг үзүүлэх төслийн сонгон шалгаруулалт хийгдэж байна. Төсөлд Есөнбулаг сумын 28, бусад сумын 22, нийт 50 өрхийн 151 гишүүн хамрагдлаа. Үүнээс: хөгжлийн бэрхшээлтэй иргэн-6, өрх толгойлсон эх -16, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх-4, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг-4 байна. Зорилтот бүлгийн 5000 иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээг үзүүллээ. | 100 |
| | | 21 | "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөл"-ийн үйл ажиллагааг дэмжин, уралдаан тэмцээн, олон нийтийн арга хэмжээнд хамруулна. | 2025 | ХХҮГ | ОНТ-11.6 | 5 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжил, оролцооны хувь-8 | Архангай аймагт зохиогдсон "Пара спорт-2025" үндэсний пара спортын 7 дахь удаагийн улсын аварга шалгаруулах 5 төрөлт тэмцээнд 14 тамирчин оролцож 2.0 сая төгрөгийн дэмжлэг, Баян-Өлгий аймагт зохиогдсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхжуулах бүсийн сургалтад 13 иргэн хамрагдаж 2.0 сая төгрөгийн дэмжлэг, "Монгол абилимп-2025" мэргэжлийн ур чадварын улсын 2 дугаар уралдаанд 9 иргэн хамрагдаж 1.4 сая төгрөгийн дэмжлэг, эрүүл мэндийн жилийн хүрээнд "Хүртээмжтэй тусламж, хүүхэд бүрт" арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй 104 хүүхдэд гэрээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэж 3.2 сая төгрөг, "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төвийн нарийн мэргэжлийн эмч нарын багийн сэргээн засах эмчилгээ үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд 180 хүүхэд хамруулж 3.0 сая төгрөгийг тус тус зарцууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн салбар комисс 16 удаа хуралдаж, 175 хүүхдийн хөгжлийн бэрхшээл болон байнгын асаргааны асуудлыг хэлэлцлээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдарыг хөгжүүлэх зорилгоор долоо хоног бүрийн 2 дахь өдөр спорт зааланд үнэгүй хичээллэх боломжоор хангалаа. Дээрх арга хэмжээнүүдэд давхардсан тоогоор 495 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдаж, хамрагдалт 22.2 хувь байна. | 100 |

| 1.1.3.Оюутан, залуучуудын хөгжил, оролцоог дэмжиж, орон нутагтаа ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | 1.1.3.1.Төрөөс залуучуудын талаар баримталж буй бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангах, сурталчлах олон талт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна. | 22 | Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжиж, хорт зуршил, дэлгэцийн хамаарлаас урьдчилан сэргийлж, соён гэгээрүүлнэ. | 2025 | СУАЖЗГ | | 1890 | Хамрагдсан залуучуудын тоо-2810 | Залуучуудын хөгжил оролцооны чиглэлээр 22 удаагийн нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 2850 гаруй өсвөр үеийн хүүхэд, залуучуудыг хамрууллаа. | 100 |
| | | 23 | “Жангар” залуучуудын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулна. | 2025 | СУАЖЗГ | ОНТ-100,0 | 1100 | Хамрагдсан залуучуудын тоо-1150 | Залуучуудын гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүй, эрүүл мэнд, цус ойртолт ба угийн бичиг хөтлөхийн ач холбогдол, үнэт зүйл амьдрах ухааны мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, тэдний нийгмийн идэвхтэй оролцоог дэмжиж, хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, зэргэлдээх аймгуудын залуусыг өөр хоорондоо танилцан, найзалж нөхөрлөх, харилцаа тогтоох боломжийг бүрдүүлэх зорилгоор "Жангар фестиваль-IV" залуучуудын нэгдсэн арга хэмжээг 2025 оны 07 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгууллаа. 2 өдрийн хөтөлбөрт арга хэмжээнд нийт 1200 залуу хамрагдлаа. | 100 |
| | | 24 | Шинээр гэр бүл болсон залуу малчин өрхийг малжуулах хөтөлбөрт хамруулж, өв уламжлал, ёс заншлаа эрхэмлэдэг аймгийн "Тэргүүний залуу малчин" өрхийг шалгаруулж урамшуулна. | 2025 | СУАЖЗГ | | 68 | Өрхийн тоо-20 | Шинээр гэр бүл болсон 43 залуу малчин өрхийг малжуулах хөтөлбөрт хамруулахаар материалыг хүлээн авч, 2025 оны 12 сард багтаан олгоно. Орон нутгийн төсөвт 150,0 сая төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийг баталсан. Үндэсний өв уламжлал, ёс заншлаа эрхэмлэдэг, түгээн дэлгэрүүлдэг, мал сүргээ удам дамжин өсгөн үржүүлж байгаа 15-34 насны 28 малчин залууг "Аймгийн аварга малчин" -аар шагналаа. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | 1.1.3.2.Орон нутагт эрэлттэй мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлж, орон нутагтаа ажиллахад дэмжлэг үзүүлж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ. | 25 | Орон нутагт ажиллаж амьдарч байгаа залуучуудын тоог нэмэгдүүлнэ. | 2025 | СУАЖЗ Г | | 318 | Шинээр ажлын байраар хангагдсан залуучууд ын тоо-350 | Тайлант хугацаанд 18-34 насны залуучуудын байнгын ажлын байр-390, улирлын чанартай ажлын байр-24, түр ажлын байр-21, цагийн ажил-32 бий болж нийт 467 залуу шинээр ажлын байраар хангагдсан байна. | 100 |
| | | 26 | Орон нутагт эрэлттэй мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудад төлбөрийн дэмжлэг үзүүлнэ. | 2025 | СУАЖЗ Г | ОНТ-316,0 | 20 | Дэмжлэгт хамрагдса н залуучууд ын тоо-20 | “Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн хүрээнд 2025 оны элсэлтийн шалгалтын дүнгээр 650-800 оноо авч, их дээд сургуульд элсэн орсон 107 оюутанд нийт 316,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. | 100 |
| **1.1.4.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийн түвшинг жилд дунджаар 0,5 хувиар бууруулна.** | | | | | | | | | | |
| 9 | 1.1.4.1.Аймгийн хэмжээнд 1000-аас доошгүй байнгын ажлын байрыг шинээр бий болгоно. | 27 | Хөдөө аж ахуй, газар тариалан, уул уурхай болон орон нутгийн бүтээн байгуулалтын хүрээнд 600-аас доошгүй байнгын ажлын байрыг бий болгоно. | 2025 | ХХҮГ | | 457 | Шинэ ажлын байрны тоо-150 | Шинээр бий болсон ажлын байрны бүртгэл, мэдээллийг 18 сум, 2 тосгоноос авч нэгтгэн тулгалт хийж, холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа. Шинээр 690 ажлын байр бий болсноос хөдөө аж ахуй, газар тариалан, уул уурхайн бүтээн байгуулалтын хүрээнд 425 ажлын бйр бий боллоо. Шинж чанараар нь авч үзвэл байнгын 515, улирлын 77, түр 98, ажлын байр байна. Жилийн эцсийн байдлаар 1380 шинэ ажлын байр бий болгохоор төлөвлөн ажиллаж байна. | 100 |
| | | 28 | Засгийн газрын тусгай сан болох ЖДҮДС, ХХС, ХЭДС-ийн хүрээнд ААН, иргэдэд эдийн засгийн дэмжлэг үзүүлэх замаар 400-аас доошгүй ажлын байрыг бий болгоно. | 2025 | ХХҮГ | | 150 | Шинэ ажлын байрны тоо-100 | Засгийн газрын тусгай сан болох ЖДҮДС, ХХС, ХЭДС-ийн хүрээнд ААН, иргэдэд эдийн засгийн дэмжлэг үзүүлэх замаар 265 ажлын байр бий боллоо. Шинээр бий болсон ажлын байрыг өмчийн хэлбэрээр нь авч үзвэл 17,6 хувь буюу 122 нь төрийн, 5 хувь буюу 35 нь орон нутгийн, 77,2 хувь буюу 533 нь хувийн байгууллагууд бий болсон байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | 1.1.4.2.Ажлын байр шинээр бий болгох хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжиж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлогыг үргэлжлүүлнэ. | 29 | Ажилгүйдлийн түвшинг бууруулна. | 2025 | ХХҮГ | | 5.8 | Ажилгүйдлийн түвшингийн хувь-5.3 | Ажилгүйдлийн түвшин 11 дүгээр сарын байдлаар 4.3 хувьтай байна. | 100 |
| | | 30 | Залуучуудад "Start-Up" арга хэмжээг зохион байгуулж дэмжлэг олгоно | 2025 | ХХҮГ | | 1 | Дэмжлэгт хамрагдсан хүний тоо -1 | Start-Up 2025 арга хэмжээнд 13 баг оролцож фитнесийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр "Мазаалай" баг, тавилга дагалдах хэрэгслийн үйлдвэрлэлийн чиглэлээр "Хөгжлийн соронз бүтээлч үйлдвэрлэл" багууд шалгарч, 50% нь эргэн төлөгдөх нөхцөлтэй тус бүр 15.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олголоо. Ховд аймагт зохион байгуулагдсан баруун бүсийн шилдэг старт ап шалгаруулах арга хэмжээнд 4 баг оролцож 4,5 дугаар байруудыг эзэлсэн. | 100 |
| | | 31 | Цөөн малтай болон малгүй иргэдийг малжуулах арга хэмжээнд хамруулж ажилтай, орлоготой болгоно. | 2025 | ХХҮГ | ХЭДС-288.0 | 74 | Хамрагдсан малчин өрхийн тоо-40 | Тус арга хэмжээнд 11 сарын байдлаар хонин толгойд шилжүүлснээр 200 хүртэл толгой малтай, 18-аас дээш насны 2-оос доошгүй гишүүнтэй, 19 сумын 36 өрхийг хамруулж, ХЭДСангаас 288,0 сая төгрөгийг зарцууллаа. Үүний үр дүнд 36 ажлын байр бий болсон байна. | 90 |
| | | 32 | Зорилтот бүлгийн хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар ажлын байр бий болгож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | 2025 | ХХҮГ | ХЭДС-960.5 | 90 | Хамрагдсан хүний тоо-90 | Хувиараа хөдөлмөр эрхлэгч 25 ба түүнээс дээш хөдөлмөрийн насны 50 иргэнд ХЭДСангаас 550,0 сая төгрөгийн зээлийг 36 сарын хугацаатай олголоо. Хувиараа хөдөлмөр эрхлэгч 45 ахмадад ХЭДСангаас 250,0 сая төгрөгийн зээлийг 24 сарын хугацаатай олголоо. Хөгжлийн бэрхшээлтэй 18, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ асарч байгаа 4, нийт 22 иргэнд ХЭДСангаас 162,0 сая төгрөгийн зээлийг 50 хувь нь буцаан төлөх нөхцөлтэй, 36 сарын хугацаатай олголоо. Дээрх 3 зорилтот бүлгийн нийт 117 иргэнд 960,5 сая төгрөгийн зээл олгож хөдөлмөр эрхлэлтийг дэмжлээ. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 33 | Нийтийг хамарсан ажилд ажилгүй иргэдийг хамруулах замаар түр ажлын байраар хангаж, орлогын дэмжлэг үзүүлнэ. | 2025 | ХХҮГ | ХЭДС-124.7 | 370 | Хамрагдсан хүний тоо-300 | “Мод тарих, ногоон байгууламжийн арчилгаа” арга хэмжээний хүрээнд 17 сум, 1 тосгонд 18 төсөл хэрэгжүүлж, зорилтот бүлгийн 134 иргэнийг хамруулж, ХЭДСангаас 62,1 сая төгрөгийг зарцуулав. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 15 сум 1 тосгоны 58 ахмадыг хамруулж, ХЭДСангаас 62640,0 мянган төгрөг зарцуулав. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүдийн аюулгүй байдлын хангах, хамгаалах зорилгоор "Хүүхэд хамгаалагч" арга хэмжээг хэрэгжүүлэн, 2 ахмадыг авто замын гарц, тоглоомын талбай болон бусад нийтийн эзэмшлийн гудамж талбайд ажиллуулав. Аймгийн хэмжээнд нийт түр ажлын байрыг хангах ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 194 иргэнийг хамруулж ХЭДСангаас 124,7 сая төгрөгийг зарцуулсан байна. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор нийтийг хамарсан ажлын хог цэвэрлэгээний арга хэмжээ хасагдаж зөвхөн мод тарих, ногоон байгууламжийн арчилгаа хийх арга хэмжээг хэрэгжүүлэхээр болж санхүүжилтийн эх үүсвэр хасагдсан. | 100 |
| | | 34 | Зорилтот бүлгийн иргэдийг байнгын ажлын байраар хангасан ажил олгогчийг дэмжинэ. | 2025 | ХХҮГ | ХЭДС-39.6 | 4 | Ажил олгогчийн тоо -4 | Зорилтот бүлгийн 9 иргэнийг байнгын ажлын байраар хангасан 7 аж ахуйн нэгжид 71.2 сая төгрөгийн ажил олгогчийн урамшуулал олгов. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | 1.1.4.3.Бага орлоготой өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг хөдөлмөрт бэлтгэх, ур чадвар эзэмшүүлэх хөтөлбөрт хамруулж, ажлын байранд зуучилна. | 35 | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн тоон судалгааг зохион байгуулна. | 2025 | ХХҮГ | | 0 | Судалгаан ы тоо-1 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.9.2, 29.9.3, 29.9.7, 29.9.9 дэх хэсэгт заасан чиг үүргийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, шинэчлэх судалгааны ажлыг зохион байгууллаа. Судалгаанд аж ахуйн нэгж, байгууллага, албан бус хөдөлмөр эрхлэгч, малчин /200 хүртэл малтай/, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажилгүй иргэд хамрагдлаа.<br>Аж ахуйн нэгж байгууллага, ажил олгогчийн судалгаа: Аймгийн хэмжээнд. 856 аж ахуйн нэгж байгууллагад 7657 ажилтан ажиллаж байна. Хариуцлагын хэлбэрээр нь авч үзвэл Төсөвт байгууллага- 183, ХХК – 547, Хоршоо – 60, Нөхөрлөл – 16, Төрийн бус байгууллага -33, Холбоо- 6, Хувьцаат компани- 3, ОНӨААТҮГ-3, ТӨААТҮГ-5 байна.<br>Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн судалгаа: Аймгийн хэмжээнд нийт 746 албан бус хөдөлмөр эрхлэгч байна. Үүний 49.2 хувь нь буюу 367 эмэгтэй, 50.8 хувь нь буюу 379 эрэгтэй байна.<br>Албан бус хөдөлмөр эрхлэгчийг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл 12 хувь буюу 87 нь авто засвар, 3 хувь буюу 21 нь гутал үйлдвэрлэл, 14 хувь буюу 101 нь оёдлын үйлдвэр, 16 хувь буюу 119 нь хүнс үйлдвэрлэл, 56 хувь буюу 418 нь бусад байна<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэний судалгаа: Хөгжлийн бэрхшээлтэй 2294 иргэн байна. Үүний 38.1 хувь буюу 876 нь эмэгтэй, 61.9 хувь буюу 1418 нь эрэгтэй байна. Нийт 2294 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагийн 56.3 хувь буюу 1293 нь нийгмийн даатгалын сангаас, 43.7 хувь буюу 1001 нь нийгмийн халамжийн сангаас тус тус тэтгэвэр авч байна.<br>Ажилгүй иргэдийн судалгаа: Аймгийн хэмжээнд 2348 ажилгүй иргэн, үүнээс 47.5 хувь буюу 1418 нь эмэгтэй байна. Бүртгэлтэй ажилгүй 837 иргэн, үүнээс 45.8 хувь буюу 384 эмэгтэй байна.<br>Мэргэжил олгох танхимийн сургалтын судалгаа Ажил олгогч, ажилгүй иргэдийн мэргэжил олгох түр сургалтын эрэлт хэрэгцээний судалгааг зохион байгууллаа. Судалгааны дүнг нэгтгэн авч үзвэл хүнд машин механизмын оператор, оёдол эсгүүр, хүлэмжийн аж ахуйн сургалтад хамрагдах хүсэлтэй иргэд 51,2 хувийг эзэлж байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 36 | Ажил олгогч, ажилгүй иргэдийн эрэлтэд үндэслэн мэргэжил олгох сургалтад хамруулж, ажилд зуучлах үйлчилгээг үзүүлнэ. | 2025 | ХХҮГ | ХЭДС-3.4 | 25 | Зуучлалаар ажилд орсон хүний тоо-30 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Дэлхийн зөн олон улсын байгууллагын Говь-Алтай орон нутгийн хөтөлбөрийн газар, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний дардан ирээдүй" ТББ-тай хамтран Үсчний мэргэжил олгох түр сургалтыг зохион байгуулсан. Сургалтад ХБИ, Хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ асарч буй 17 иргэн хамрагдаж ХЭДСангаас 3,4 сая төгрөгийг зарцуулсан. Барилгын бетон арматур, засал чимэглэл, талх нарийн боовны үйлдвэрлэлийн технологи, хүнд машин механизмын оператор, хүлэмжийн аж ахуйн фермер гэсэн 5 төрлөөр 35 иргэн мэргэжлийн боловсролын сургалтад хамрагдан, хувиараа ажил эрхэлж байна. | 100 |
| 12 | 1.1.4.4.Дэд бүтэц, уул уурхайн салбарт томоохон бүтээн байгуулалтад нийт ажилчдын 40-өөс доошгүй хувийг сум, орон нутгийн иргэдийг ажиллуулах бодлогыг хэрэгжүүлнэ. | 37 | Аймагт дэд бүтэц, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниуд болон томоохон бүтээн байгуулалтад нийт ажиллагсдын 40-өөс доошгүй хувийг сум, орон нутгийн иргэдийг ажиллуулах бодлогыг хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 2025 | АЗДТГ, НБХ | | 0 | Тухайн сумаас ажиллагсдын эзлэх хувь-10 | "Цэн газар" ХХК-ийн нийт 111 ажилтны 52 буюу 46.8 хувь, "Хан Алтай ресурс" ХХК -ийн нийт 1010 ажиллагсдын 370 буюу 36.7 хувь, "Мандал-Алтай" ХХК-ийн нийт 27 ажилтан 100 хувь, "Цэрдийн тал" ХХК-д 1, "Секэр ресурс" ХХК-д 3, аймгийн хэмжээнд нийт 453 орон нутгийн ажиллагсад эзэлж байна. Эдгээрээс 38 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. | 100 |
| **1.1.5.Нийтийн биеийн тамирыг эрүүл идэвхтэй амьдралын хэв маяг болгож, иргэдийн биеийн тамир спортын арга хэмжээнд хамрагдах хүрээг нэмэгдүүлэн, идэвхтэй хөдөлгөөн спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, тамирчдыг бүс, улс, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | |
| 13 | 1.1.5.1.Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшин тодорхойлох, хянах, эрүүл чийрэг дадал хэвшилтэй иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | 38 | Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилыг жилд 2 удаа зохион байгуулж ажиллана. | 2025 | БТСГ | | 6 | Сорилд хамрагдсан иргэдийн хувь-7 | Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорил" –д хамрагдвал зохих 49351 иргэнээс 3484 иргэнээс сорил авч, хамрагдалт 7.06 хувьтай байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 39 | Сорилд хамрагдсан нийт иргэдийн бие бялдрын хөгжлийн түвшин тодорхойлох, АВС үнэлгээтэй иргэдийн тоог өсгөнө. | 2025 | БТСГ | | 10 | АВС үнэлгээтэй иргэдийн хувь-12 | Сорилд хамрагдсан иргэдийн 1681 буюу 48,2 хувь нь А, В, С (А-12,9%, В-20,3%, С-17,8%) үнэлэгдлээ. | 100 |
| 14 | 1.1.5.2. " Говь-Алтай 80+" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийтийн биеийн тамирыг хөгжүүлж,хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг идэвхжүүлж, биеийн тамираар хичээллэх иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | 40 | Хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор өглөөний дасгал хөдөлгөөн, алхалт, нийтийн биеийн тамирын арга хэмжээ, тэмцээн уралдааныг тогтмол зохион байгуулж, хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ. | 2025 | БТСГ | УТ-16.4 | 13913 | Хамрагдсан иргэдийн тоо-14000 | Нийтийн биеийн тамирын чиглэлээр 14 арга хэмжээ зохион байгуулж (өвлийн спортын арга хэмжээ-1, волейбол-3, сагсан бөмбөг-2, үндэсний бөх-2, хүүхдэд чиглэсэн арга хэмжээ-3, бүх нийтийг хамарсан арга хэмжээ-3) 1875 иргэнийг хамрууллаа. “Говь-Алтай 80+” хөтөлбөрийн хүрээнд идэвхтэй дасгал хөдөлгөөнийг эрэлхийлж илүүдэл жингээ хасах, амьдралын хэв маягаа өөрчлөх хүсэлтэй иргэдэд өдөр бүр 06:00-8:30 цагийн хооронд Биеийн тамир спортын газрын спорт заалыг үнэгүй ашиглуулж, давхардсан тоогоор 14261 иргэн хамрагдаж байна. Төрийн болон төрийн бус 20 байгууллагын давхардсан тоогоор 2400 албан хаагч 7 хоногийн 4 өдрийн 18:00-22:00 цагт спортоор хичээллэж байна. Ахмадын биеийн тамир спортын үйл ажиллагааг идэвхжүүлэх, эрүүл мэндийг дэмжих хүрээнд 7 хоногт 2 удаа 8 цагаар заал үнэ төлбөргүй ашиглуулж, давхардсан тоогоор 2840 ахмад хамрагдаж байна. Ахмадын спортын тэмцээн үйл ажиллагааг дэмжиж спортын 4 төрөлт (софт волейбол, ширээний теннис, шатар, дартс) тэмцээнд 130 хүн хамрагдлаа.<br>Дээрх арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 21476 иргэн тогтмол хамрагдаж байна. | 100 |
| | | | | | | | 24 | Нийтийн биеийн тамираар хичээллэгсдийн хувь-26 | Хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор өглөөний дасгал хөдөлгөөн, алхалт, нийтийн биеийн тамирын арга хэмжээ. Тэмцээн уралдааныг тогтмол зохион байгуулж нийтийн биеийн тамир спортоор хийчээллэгсдийн тоог нэмэгдүүлэн нийт хүн амын 36.4 хувийг хамруулсан байна. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | 1.1.5.3 Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багуудыг дэмжин “Аваргыг аймагтаа” арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, тамирчдын залгамж халаа бэлтгэх, ур чадвар амжилтыг ахиулж улс, бүсийн тэмцээнд бэлтгэн оролцуулна. | 41 | Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 15 төрлөөр зохион байгуулна. | 2025 | БТСГ | | 6441 | Хамрагдсан тамирчдын тоо-1250 | Өсвөр үеийн шигшээ багийг спортын 10 төрлөөр 292 тамирчин хамрагдан бэлтгэгдэж байна. Монголын хүүхдийн спортын VIII их наадмын анхан шат өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн спортын 16 төрлөөр зохион байгууллаа. Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 17 сум Алтай хотын 5 сургуулийн нийт 2850 хүүхэд хамрагдлаа. | 100 |
| | | 42 | Улс, бүсийн тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулна. | 2025 | БТСГ | ОНТ-6.0 | 4 | Спортын төрлийн тоо -2 | Аймгийн Засаг даргын ивээл дор Урианхай сурын баруун бүсийн чуулга харвааг 2025 оны 05 сард багийн болон цуваа харвааны төрлөөр зохион байгуулж, 4 аймгийн 14 багийн 196 харваач оролцон, 9 тамирчин спортын мастер, 3 тамирчин спортын дэд мастерын болзол хангалаа. Өсвөр үеийн баруун бүсийн аварга шалгаруулах таеквондогийн тэмцээнд баруун 5 аймгийн 186 тамирчин оролцлоо."Хантайшир" бөхийн дэвжээтэй хамтран баруун бүсийн аварга шалгаруулах "Түмний манлай-2025" тэмцээнийг бөхийн 3 төрлөөр зохион байгуулж, 750 гаруй тамирчид өрсөлдлөө. | 100 |
| | | 43 | Өсвөрийн шигшээ багийг дэмжиж, амжилтыг ахиулна. | 2025 | БТСГ | УТ-40.0 | 129 | Медалийн тоо-131 | “Аваргыг аймагтаа” арга хэмжээний хүрээнд өсвөр үеийн шигшээ багийг спортын 10 төрлөөр (волейбол, сагсан бөмбөг, жүдо, чөлөөт бөх, шатар, хөл бөмбөг, хөнгөн атлетик, таеквондо, ширээний теннис, үндэсний бөх) нийт 292 тамирчин бэлтгэж байна. Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 16 төрлөөр зохион байгуулж 2850 хүүхэд хамрагдлаа.<br>Өсвөр үеийн баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнд спортын 2 төрлөөр (жүдо, таеквондо) 148 тамирчин оролцож, алт-26, мөнгө-16, хүрэл-24, Улсын аварга шалгаруулах өсвөр үеийн тэмцээнд спортын 8 төрлөөр 191 тамирчин оролцож, алт-7, мөнгө-8, хүрэл-24 Бүс, улс, олон улсын аварга шалгаруулах тэмцээнд спортын 12 төрлөөр 341 тамирчин оролцож алтан медаль-34, мөнгөн медаль-25, хүрэл медаль-48, нийт 156 медаль хүртлээ. | 100 |
| 16 | 1.1.5.4.Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор зохион байгуулагддаг спортын их наадмуудыг орон | 44 | Хүүхдийн спортын их наадмыг спортын 15 төрлөөр 2 үе шаттай зохион байгуулна. | 2025 | БТСГ | УТ-19.0 | 1809 | 2100 | Монголын хүүхдийн спортын VIII их наадмын анхан шат өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн спортын 15 төрлөөр зохион байгууллаа. Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 18 сумын нийт 2750 хүүхэд хамрагдлаа. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нутагтаа зохион байгуулж, тамирчдын хамрагдалтын тоог нэмэгдүүлэх, улс бүсийн аварга шалгаруулах шигшээ тэмцээнд тамирчдыг бэлтгэн оролцуулах өмнөх наадмуудын амжилтыг ахиулна. | 45 | Хүүхдийн спортын их наадмын бүс, улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг бэлтгэн оролцуулна. | 2025 | БТСГ | УТ-14.0 ОНТ-25.0 | 134 | 200 | “Мөрөөдлийнхөө төлөө шударгаар өрсөлдье” уриатай Монголын хүүхдийн спортын VIII их наадмын шигшээ тэмцээн 2025 оны 05 дугаар сарын 26-наас 06 дугаар сарын 06-ны өдрүүдэд Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулагдаж, аймгийн өсвөр үеийн шигшээ баг спортын 12 төрөлд 145 тамирчин, дасгалжуулагч 15, албаны 5 нийт 165 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо. | 90 |
| | | 46 | Спортын их наадмуудын хүрээнд зохион байгуулагдсан тэмцээн уралдаанд амжилттай оролцож, өмнөх амжилтаа ахиулна. | 2025 | БТСГ | - | 59 | Медалийн тоо-60 | Монголын бүх ард түмний спортын XVI их наадмын анхан шат аймгийн аварга шалгаруулах насанд хүрэгчдийн тэмцээнийг спортын 10 төрлөөр зохион байгуулж 18 сум, 35 байгууллагын 910 хүн оролцлоо. Наадмын шигшээ тэмцээн 2025 оны 09 дүгээр сард Баянхонгор аймагт зохион Монголын бүх ард түмний спортын их наадмын XVI их наадам 2025 оны 09 дүгээр сарын 15-21-ний өдрүүдэд Баянхонгор аймагт зохион байгуулагдлаа. Аймгийн баг тамирчид спортын 12 төрлөөр 75 тамирчин оролцож мөнгө-2, хүрэл-7 медаль хүртлээ. Монголын хүүхдийн спортын VIII их наадмын шигшээ тэмцээнд аймгийн өсвөр үеийн шигшээ баг спортын 12 төрлөөр өрсөлдөж, алтан медаль -2, мөнгөн медаль -4, хүрэл медаль -6 нийт 12 медаль хүртэж өмнөх наадмын амжилтаа ахиуллаа. Багийн дүнгээр 30 байгууллагаас 18 дугаар байр, аймгуудын хэмжээнд 12-р байрт шалгарлаа. Үндэсний сур, Буриад сум, Урианхай сурын төрөлд алтан медаль-4, мөнгөн медаль-1, хүрэл медаль-8 медаль хүртлээ. Спортын их наадмуудын хүрээнд зохион байгуулагдсан тэмцээн уралдаанаас нийт 34 медаль хүртлээ. Засгийн газрын тогтоолоор спортын их наадмуудын хүрээнд зохион байгуулагддаг бүсийн уралдаан тэмцээнүүдийг зогсоож шигшээ тэмцээнийг шууд зохион байгуулсан нь медалийн тоонд нөлөөлсөн байна. | 50 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | 1.1.5.5.Үндэсний спортыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, аймаг орон нутгаас төрөн гарсан үндэсний спортын тамирчдыг алдаршуулна. | 47 | Нүүдэлчин дэлхийн соёлын фестивальд аймаг орон нутгаас төрөн гарсан үндэсний спортын алдартан гавьяатуудыг танилцуулах үндэсний спортыг сурталчлах ажлыг зохион байгуулна. | 2025 | БТСГ | - | 5 | Алдаршуулсан тамирчны тоо-7 | Монгол Улсын дархан аварга Ш.Батсуурийг алдаршуулах ажлын хүрээнд Жаргалан сумын Засаг даргын Тамгын газар, "Дархан Батсуурь" үндэсний бөхийн холбоотой хамтран өсвөр үеийн үндэсний бөхийн аймгийн аварга шалгаруулах барилдааныг 3 насны ангиллаар зохион байгуулж 53 хүүхэд оролцлоо.  Чандмань сумын харьяат Монгол Улсын заан Р.Давааням агсныг алдаршуулах ажлын хүрээнд "АБААЗАН" сан, "Хантайшир" бөхийн дэвжээ хамтран баруун бүсийн аварга шалгаруулах "Түмний манлай-2025" тэмцээнийг бөхийн 3 төрлөөр зохион байгуулж, 750 гаруй тамирчид өрсөлдлөө. Нүүдэлчин дэлхийн соёлын фестивальд аймаг орон нутгаас төрөн гарсан үндэсний спортын 6 алдартан гавьяатны амжилтыг сурталчлан ажиллалаа. | 100 |
| **1.1.6.Соёлын боловсролтой,  зэрэг хандлагатай, эх оронч үзэлтэй иргэнийг төлөвшүүлнэ.** | | | | | | | | | | |
| 18 | 1.1.6.1.Ард иргэдэд хүргэх соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлнэ. | 48 | Иргэдэд соёлын боловсрол олгож,  ёс суртахуунтай, эрүүл, зөв дадлыг нийгэмд хэвшүүлэх "Соёлтой иргэн-Алтайн тренд" аяныг өрнүүлнэ. | 2025 | СУАЖЗГ | | 3250 | Хамрагдсан иргэдийн тоо-3300 | Иргэдэд соёлын боловсрол олгох 8 удаагийн сургалтад 510 иргэн хамрагдлаа. Соёлын орон зай, орчныг бүрдүүлэх соёлын үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх, соёлын харилцаа, урлагийн бүтээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгэмд эерэг нөлөө бүхий бүтээлч ажил, соёлыг олон нийтэд түгээн сурталчлах “Соёлын орон зай-Бидний орчин" бүтээлч аян уриатайгаар улсын хэмжээнд өрнөж 10 дугаар сарын 03-наас 11 дүгээр сарын 03-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд 1320 арга хэмжээ зохион байгуулж 12350 хүнийг хамрууллаа. Цахим орчинд нийтэлсэн контент 215, пост 875, “Соёл түгээе” аяны таалагдсан мэдээний тоо /лайк/ 11250, хуваалцсан мэдээний тоо /шэйр/ 12109, аяны хандалтын тоо /vзэлт/ 12109 байна. Тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 36424 иргэнийг соёлын боловсрол олгох арга хэмжээд хамрууллаа. Соёлын боловсролтой иргэдийн эзлэх хувь 31,9 байна. | 100 |
| | | | | | | | 20 | Соёлын боловсролтой иргэдийн эзлэх хувь-30 | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 49 | Үндэсний бичиг, өв соёл-Алтайн бахархал аяныг өрнүүлнэ. | 2025 | СУАЖЗГ | ОНТ-16,5 | - | Хамрагдсан иргэдийн тоо-500 | “Үндэсний бичиг соёлоо эрхэмлэн дээдэлье” уриатай 37 дахь удаагийн номын баяр “Үндэсний бичиг соёл-номын өдрүүд-2025” арга хэмжээ 2025 оны 05 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд Жангар нийтийн номын сангийн гадна талбайд зохион байгуулж 1100 иргэн хамрагдлаа. Үндэсний бичиг үсгийн баярын нэгдсэн хөтөлбөрийн дагуу сумдын салбар зөвлөлүүд “Үндэсний бичиг, уламжлалт соёл” уриатайгаар зохион байгуулж давхардсан тоогоор 1600 орчим сурагч, албан хаагч, иргэд оролцлоо. Төрийн байгууллагуудын дунд монгол бичгийн “Үндэсний бичгээ өвлөн бахархъя” уралдааныг Жангар номын сантай хамтран зохион байгуулж, 12 байгууллагын 36 албан хаагч оролцлоо. 3-р сургуулийн эх хэлний багш, Бигэр сумын сургуулийн багш нарыг “Үндэсний бичиг соёлоо түгээн дэлгэрүүлэгч” шагналаар шагнаж урамшууллаа. "Үндэсний бичиг, өв соёл-Алтайн бахархал" аяны хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнд 2700 иргэн хамрагдлаа. | 100 |
| | | 50 | "Угийн бичиг Удмын хэлхээ 2024-2028" хөдөлгөөнийг өрнүүлнэ. | 2025 | СУАЖЗГ | | 56.1 | Угийн бичиг хөтөлдөг өрхийн хувь-60 | Угийн бичиг хөтлөх арга зүйн 22 сургалт зохион байгуулж 1093 иргэн хамрагдаж, аймгийн 16413 өрхийн 60,5 хувь буюу 9924 өрх угийн бичгээ хөтөлж байна. | 100 |
| | | 51 | Ураг удмуудын "Ургийн баяр"-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. | 2025 | СУАЖЗГ | | - | Дэмжлэг үзүүлсэн ургийн баярын тоо-3 | Бигэр, Халиун, Төгрөг, Цогт сумдад зохион байгуулагдсан 4 ургийн баярт 3000 гаруй иргэн хамрагдлаа. Ургийн баярын арга хэмжээнүүдэд зөв аргачлалаар угийн бичиг хэрхэн хөтлөх талаар гарын авлага бэлтгэн арга зүйн зөвлөгөө өгч, мэргэжлийн урлагийн болон хэвлэл мэдээллийн байгууллагууд хамтран үйл ажиллагааг дэмжин ажиллалаа. | 100 |
| | | 52 | Ардын дуу бүжгийн Алтай чуулгын статуст өөрчлөлт оруулж, үйл ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2025 | СУАЖЗГ | ОНТ-180.0 | - | Хэрэгжилтийн хувь-100 | Ардын дуу бүжгийн Алтай чуулгыг “Үндэсний урлагийн их театр” болгох хүсэлтийг соёлын салбарынхан, үе үеийн уран бүтээлчид, уран бүтээлч хамт олны нийт 200 гаруй хүний саналыг нэгтгэн, байгууллагын танилцуулга, түүхэн товчоо, хүний нөөцийн мэдээлэл, одоо ажиллаж байгаа хүчин чадал, техник хэрэгслийн мэдээллийг нарийвчлан гаргаж СУАЖЗЯ-д хүргүүллээ. Орон нутгийн төсвийн 180.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар соёл, урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд дэмжлэг үзүүлэх, бүжгийн хувцас нийлүүлэх ажилд "Уламжлалт биелэгийн өв холбоо" ТББ шалгарлаа. | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 53 | Мэргэжлийн урлагийн байгууллагын урын санг нэмэгдүүлж, чанартай, шинэлэг уран бүтээлээр иргэдэд үйлчилж, үзэгчдийн тоог нэмэгдүүлнэ. | 2025 | СУАЖЗ Г | ОНТ-180.0 | 7249 | Үзэгчдийн тоо-7500 | Ардын дуу бүжгийн Алтай чуулгын уран бүтээлчид алтай ятга хөгжмийг цэнгүүлэх “Чөргөөлгөн цагаан аялгуу”, аймгийн баяр наадамд зориулсан “Алтан говийн сүмбэр Алтай мину-2” шинэ уран бүтээлийн тоглолт болон Улаанбаатар хотноо "Дурсамж дүүрэн он жилүүд", 17 сум, 2 тосгонд "Шилдэг уран бүтээл"-ийн тоглолтыг тус тус зохион байгуулж 7550 үзэгч үзэж сонирхлоо. Ардын дуу бүжгийн Алтай чуулгын 60 жилийн ойн тоглолтын ерөнхий найруулагчаар “Бий биелгээ өвлүүлэх холбоо” ТББ тэргүүн, Хөдөлмөрийн баатар, Төрийн соёрхолт, Урлагийн гавьяат зүтгэлтэн С.Сүхбаатар, хөгжмийн зохиолчоор Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт, СТА Б.Бямбабаяр, хөгжмийн зохиолч, Урлагийн гавьяат зүтгэлтэн, хормейстрээр алтан гадас одонт хөгжмийн зохиолч С.Тараа, бүжгийн багш найруулагчаар СТА Д.Дашдаваа нартай хамтран ажиллахаар 180.0 сая төгрөгийн гэрээ байгууллаа. | 100 |
| | | 54 | Соёл, урлагийн уралдаан, наадмуудыг зохион байгуулж, улс, олон улсад өрсөлдөх чадвартай, авьяаслаг, бүтээлч иргэнийг нээн илрүүлж, дэмжиж ажиллана. | 2025 | СУАЖЗ Г | ОНТ-30.0 | 19 | Дэмжлэгт хамрагдсан хүний тоо-15 | Соёл, урлагийн чиглэлээр, олон улсын болон бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан уралдаан тэмцээнд амжилт гаргасан 17 хүүхдэд 30.0 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олголоо. | 100 |
| | | 55 | Соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг нэмэгдүүлнэ. | 2025 | СУАЖЗ Г | | 0 | Өвийн тоо-2 | Аймгийн нутаг дэвсгэрт орших улсын хамгаалалттай 11, аймгийн хамгаалалттай 31, нийт 42 түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах гуравласан гэрээг 16 сумын Засаг дарга, Соёлын төвийн дарга, иргэнтэй 1 жилийн хугацаатай байгууллаа. Есөнбулаг сумын “Хадаасан”-ы эхэнд орших хоёр “Буган чулуун” хөшөө унаж, хөрсөнд даргадан устах эрсдэлд орсон тул “Жангар” музей болон “Хан Алтай ресурс” ХХК хамтран уг дурсгалыг сэргээж, хамгаалалтыг сайжрууллаа. Аймгийн хамгаалалтын зэрэглэлд бүртгэлтэй Эрдэнэ сумын Сангийн далай багийн нутагт байрлах түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох “Наран”-ийн хөшөөг Улсын хамгаалалтад бүртгүүлж зэрэглэл дэвшүүллээ. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 56 | Жангар музейн үзүүллэг, дэглэлтийг хийж AR, VR дижитал технологийг нэвтрүүлнэ. | 2025 | СУАЖЗГ | | 0 | Нэвтрүүлсэн дижитал үйлчилгээний тоо-1 | Орон нутгийн музейн соёлын өвийн тоног төхөөрөмжийг 4 багцаар нийлүүллээ. 1-р багц буюу музейн шилэн хорго буюу витрин, гэрэлтүүлгийг 1,565,6 сая төгрөгөөр "Синема оф саунд" ХХК, 2-р багц буюу музейн техник тоног төхөөрөмжийг 763,5 сая төгрөгөөр "Сод буян констракшн" ХХК, 3-р багц буюу музейн тавилга, сан хөмрөгийн тоног төхөөрөмжийг 369,5 сая төгрөгөөр "Зорь бүтээ" ХХК, 4-р багц буюу хуулбар үзмэр худалдан авах болон үзүүллэг дэглэлтийн туслах хэрэглэгдэхүүн нийлүүлэх ажлыг 368.2 сая төгрөгөөр “RTSchool art" ХХК-аар тус тус гүйцэтгүүллээ. Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн “Ирвэстэй нутгийн ирээдүй” төсөл болон Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хөрөнгө оруулалтаар 2025 оны 4 дүгээр сард “Жангар” музейд 13 ширхэг виртуал бодит байдлын (VR) төхөөрөмжийг хүлээлгэн өглөө. | 100 |
| | | 57 | Жангар нийтийн номын санд үйлчилгээний шинэлэг хэлбэр, технологийн шинэчлэлийг нэвтрүүлж, мэдээллийн сан, номын фондыг цахимжуулан, Чимээтэй номын сан төслийг хэрэгжүүлнэ. | 2025 | СУАЖЗГ | | 0 | Төслийн хэрэгжилтийн хувь-50 | Тав тухтай стандарт орчинд суралцах боломжоор хангах, төрөл бүрийн хөтөлбөр, арга хэмжээгээр дамжуулан сурагчдын амралт чөлөөт цагийг идэвхтэй, үр дүнтэй өнгөрүүлэхэд туслах зорилгоор “Чимээтэй номын сан” төслийг хэрэгжүүлэхэд засварын ажлыг "Сод энх констрашин" ХХК гүйцэтгэхээр гэрээ байгууллаа. Жангар нийтийн номын сан нь цахим номын сангийн lib4u программаас улс орон даяар номын сангуудын үйл ажиллагаанд шинээр нэвтэрч буй үүлэн технологид суурилсан koha цахим программд нийт 46291 номыг хөрвүүллээ. | 70 |
| | | | | | | | 0 | Цахимжсан номын тоо-12250 | | |
| | | 58 | Соёлын төвүүдийн үйл ажиллагаанд шинэчлэл хийж, соёл урлагийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | 2025 | СУАЖЗГ | | 112000 | Хамрагдсан иргэдийн тоо-130000 | 19 соёлын төв 6982 удаагийн үзвэр, үйлчилгээ зохион байгуулж, соёлын арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 130058 иргэн хамрагдсан байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | 1.1.6.2.Аймгийн хэмжээний соёлын бүтээлч үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дэмжиж, зах зээлд нэвтрүүлнэ. | 59 | Аймгийн хэмжээнд “Соёлын бүтээлч үйлдвэрлэл”-ийн судалгаа хийж, бүтээгдэхүүн, үйлчилгээний тоог нэмэгдүүлнэ. | 2025 | СУАЖЗГ | | - | Нэвтрүүлсэн бүтээгдэхүүний тоо-1 | Монголын уламжлалт сийлбэрийн нэгэн төрөл болох ясан сийлбэрийг бүтээлч үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлэх чиглэлээр ажиллаж буй залуу өвлөн уламжлагч Б.Энхмөнх "Сийлбэр" хувийн урлангаа шинээр нээж, жижиг цогцолбор хэлбэрээр хөгжүүлэх боломжийг бүрдүүллээ. | 100 |
| 20 | 1.1.6.3.Алтайчуудын өв уламжлал, түүх, уран зохиол, нүүдлийн ахуй соёлыг сэргээж, нутгийн онцлогийг илэрхийлсэн бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгоно. | 60 | Монгол Улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд багтсан Монгол тууль хайлах өвийг сэргээж, соёл, аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгоно. | 2025 | СУАЖЗГ | ХХО-4,0 | 0 | Брэнд бүтээгдэхүүн үйлчилгээний тоо-1 | Монгол Улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд багтсан “Монгол тууль хайлах” өвийг сэргээх, туульчдыг бэлтгэх, бүх нийтийг соён гэгээрүүлэх, өв соёлоо хадгалан үлдээх, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, ард иргэдэд хүргэх соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлж, соёлын биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалт, сурталчилгааг нэмэгдүүлж, нутгийн онцлогийг илэрхийлсэн соёл, урлаг, аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох зорилгоор "Туульсын хаан Жангар" баатрын "Идэр нас" болон "Балчир" насны А3 хэмжээтэй хөрөг зураг бүхий 500 ширхэг PUZZLE тоглоом, хувцас, медалийг худалдаанд нэвтрүүллээ. | 100 |
| | | 61 | “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд орон нутгийн соёлын ондоошил брэнд үйлчилгээг сурталчлан оролцоно. | 2025 | СУАЖЗГ | УТ-18,0 ОНТ-5,6 | 20 | Оролцогчдын тоо-20 | Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Тайж хайрхан”-ны бэлд 08 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд 40 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо. “Алтайн магтаал", "Жангар" туулийн удиртгал хэсэг болон “Агийн улаан хаан” туулийг тус тус хайлж, их тайзны 40 минутын тоглолт 1 удаа, отгийн 35 минутын тоглолтыг 27 удаа тоглож давхардсан тоогоор 1600 гаруй иргэд үзэж сонирхлоо. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | 1.1.6.4.Соёлын салбарын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ. | 62 | Шарга, Хөхморьт сумдад 200 хүний суудалтай, Гуулин, Баянтоорой тосгонд 150 хүний суудалтай соёлын төвийн шинэ барилга барьж ашиглалтад оруулна. | 2025 | СУАЖЗГ | | 0 | Ашиглалтад орсон барилгын тоо-1 | Хөхморьт сумын 200 суудалтай соёлын төвийн барилгын зураг төсвийг "Барилга байгууламж" ХХК боловсруулж байна. | 30 |
| | | 63 | АДБ-ийн Алтай чуулга, Төгрөг, Алтай, Тайшир, Дарив, Бигэр, Чандмань, Жаргалан, Эрдэнэ сумдын соёлын төвийн барилгыг ээлж дараатайгаар их засварт оруулна. | 2025 | СУАЖЗГ | ОНТ-10.0 | 7 | Их засвар хийгдсэн соёл урлагийн байгууллагын тоо-3 | Төгрөг сумын соёлын төвийн их засварын ажлын зураг төсөв хийж, орон нутгийн төсвийн 10.0 сая төгрөгөөр дээврийн засварын ажлыг хийлээ. Алтай сумын соёлын төвийн их засварын ажлын зураг төсвийг "Люкс товер" ХХК гүйцэтгэлээ. | 50 |
| | | 64 | Соёл урлагийн байгууллагуудын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчилнэ. | 2025 | СУАЖЗГ | УТ-78,7 | 5 | Шинэчлэл хийгдсэн соёл урлагийн байгууллагын тоо-3 | Улсын төсвийн 59,7 сая төгрөгөөр Дэлгэр, Тонхил, Цогт сум, Гуулин, Баянтоорой тосгоны соёлын төвийн 510 ширхэг үзэгчдийн сандлыг шинэчиллээ. | 100 |
| | | 65 | Соёлын салбарын үйлчилгээний стандартын хувийг нэмэгдүүлнэ. | 2025 | СУАЖЗГ | | 39 | Стандартын хувь-50 | Салбарын 86 объектод эрсдэлийг үнэлэх 4 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг хийлээ. Үнэлгээгээр салбарын үйлчилгээний стандарт 50 хувьтай байна. | 100 |
| **1.2.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, аймгийн хүн амын дундаж наслалтыг уртасгана.** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.2.1.Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, дундаж наслалтыг нэмэгдүүлэх “ГОВЬ-АЛТАЙ 80+” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | | |
| 22 | 1.2.1.1.“ГОВЬ-АЛТАЙ 80+” эрүүл мэндийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 66 | Говь-Алтай 80+ эрүүл мэндийн хөтөлбөрийн хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана. | 2025 | ЭМГ | УТ, ОНТ, Хандив-7,279.8 | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-90-ээс доошгүй | Аймгийн Засаг даргын захирамжаар 2025 оныг Эрүүл мэндийн жил болгон зарлалаа. 2025 онд эрүүл мэндийн салбарт нийт 7,279.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ. Явуулын амбулаторийн 2 автомашин нийлүүлж, эрчүүдийн үзлэгийг 9 сумд зохион байгуулж 765 хүн, явуулын эмнэлгийн эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд зорилтот бүлгийн 5000 хүний 4964 буюу 99.2 %-ийг хамруулж, 2025 онд 18 сумын 60 багийн эмч (автомашинаар хангасан 46, гардуулахаар хүлээгдэж байгаа 14) нийт 950.0 сая төгрөгийн Probox автомашинаар хангаж, 1,612.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүллээ. Хөтөлбөрийг 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын А/480 дугаар захирамжаар 44 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусган 90,0%-тай байна. | 100 |
| 23 | 1.2.1.2.Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчлөл болон нас баралтын тэргүүлэх шалтгааны эрсдэлт хүчин зүйлийг бууруулна. | 67 | Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйл хандлагыг өөрчлөх нөлөөллийн ажил зохион байгуулна. | 2025 | ЭМГ | - | 5<br>6<br>-<br>46 | Тамхинаас гарсан хүний тоо-20<br>Архинаас гарсан хүний тоо-20<br>Хамрагдалтын хувь-25-аас доошгүй хувь<br>Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо-49 | Эхний 10 сарын байдлаар давхардсан тоогоор сургалтад 35371 хүн, сурталчилгаанд 35959, нөлөөллийн ажилд 4154 хүн буюу эрүүл зан үйлийг төлөвшүүлэх нөлөөллийн ажилд аймгийн 18-аас дээш насны 37795 хүний дунджаар 17% нь хамрагдлаа. Эрүүл мэндийн газар цахим хуудсанд цаг үеийн болон эрүүл мэндийн 607 төрлийн мэдээлэл оруулж давхардсан тоогоор 1607523 хүнд, харьяа эрүүл мэндийн байгууллагууд 197 цахим хуудсанд 461 мэдээлэл байршуулан 15565 хандалт авлаа.<br>Тамхинаас 15, архинаас 14 иргэн татгалзаж эрүүл мэндийг дэмжигч байгууллага 3-аар нэмэгдлээ. | 70 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 68 | Эцэг, эх, асран хамгаалагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, 0-6 насны хүүхдэд бага наснаас нь эхлэн эрүүл зөв зан үйл төлөвшүүлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ. | 2025 | ЭМГ | - | - | Сургалт, сурталчил гааны тоо-8 | Хүүхдэд бага наснаас нь эхлэн эрүүл зөв зан үйл төлөвшүүлэх чиглэлээр сургуулийн өмнөх боловсролын 20 байгууллагын 3010 эцэг, эх асран хамгаалагчийг амны хөндийн эрүүл ахуй, зөв зохистой хооллолт, осол гэмтэл сэдвээр сургалтад хамруууллаа. Хүүхдийг багаас нь зөв дадалтай болгох зорилгоор 22 цэцэрлэгийн 1283 эцэг эх асран хамгаалагчдад өглөөний цайны ач холбогдолын талаар, 1096 хүнд гар угаах, амны хаалт зөв хэрэглэж халдвараас сэргийлэх талаар зөвлөгөө өглөө.<br>Хөхний сүүгээр дагнан хооллолтын ач холбогдлын талаар 428 ээжид ганцаарчилсан зөвлөгөө, 1-р ангийн хүүхдийн эрт илрүүлгийн үзлэгийн үеэр 1112 хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдад шүд угаалтын талаар, 896 хүнд хараа хамгаалах чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өглөө. Нийт 9 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээнд давхардсан тоогоор 7825 хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч хамрагдлаа. | 100 |
| | | | | | | | - | Аяны тоо-3 | “Шүдээ зөв угаах 24/3“, "Товлолын дархлаажуулалт-Таны хүүхдийн эрүүл ирээдүй", "Цэвэр гар" нийт 3 аянг зохион байгуулж, 46 байгууллага хамтран ажиллалаа. | |
| | | | | | | | - | Хамрагда лтын хувь-25-аас доошгүй хувь | Нийт 0-6 насны 6418 хүүхэдтэй эцэг, эх асран хамгаалагчдаас давхардсан тоогоор 3410 буюу 53.1% нь 36 удаагийн сургалт сурталчилгаанд хамрагдлаа. | |
| | | 69 | Алслагдсан болон газар зүйн саад бэрхшээлтэй сум багийн иргэдэд явуулын үзлэг, оношилгоо, шинжилгээ зохион байгуулна. | 2025 | ЭМГ | ОНТ 127,3 | - | Явуулын үзлэгт хамрагдса н зорилтот бүлгийн иргэдийн хамрагдал тын хувь-100 | Явуулын эмнэлгийн эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд зорилтот бүлгийн 5000 хүний 4964 буюу 99.2%-ийг хамруууллаа.<br>Хорт хавдрын урьдал, хавдрын сэжигтэй болон үүсгэвэртэй 61 хүнийг илрүүлж лавлагаа шатлалд онош тодруулахаар илгээснээс бөөрний хорт хавдар 3 батлагдаж мэс заслын эмчилгээнд, элэгний хорт хавдар 1 батлагдаж мэс засын эмчилгээнд, умайн хүзүүний хоргүй хавдар 1 оношлогдож аймгийн Нэгдсэн эмнэлэгт мэс заслын эмчилгээнд, шинжилгээний хариу хүлээж байгаа 1, 3-6 сарын дараа давтан үзлэгт хамрагдах 9 хүн байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 10 | Эрчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралтын хувь-20 | 18-аас дээш насны 18175 эрэгтэйгээс давхардсан тоогоор 3702 буюу 20% нь хамрагдлаа.<br>Үзлэгт хамрагдсан эрчүүдийн 521 буюу 68.1% малчин, 89 буюу 11.6% нь төрийн албан хаагч, 121 буюу 15.8% нь тэтгэвэрт, 18 буюу 2.4% нь ажилгүй, 16 буюу 2.1% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч байна. 16.3% нь зүрх судасны эрхтэн тогтолцооны, 57.9% нь хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэгтэй байгаагаас 35-55 насны эрчүүдэд хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг, 35-49 насныхны дунд зүрх судасны эрхтэн тогтолцооны эмгэг, 60-аас дээш насныханд даралт ихсэх өвчин хамгийн өндөр, урд бүсийн сумын эрчүүдийн 31.7%-д зүрх судасны эрхтэн тогтолцооны эмгэг, хойд бүсийн сумын эрчүүдийн 57.9% нь хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг давамгай бүртгэгдсэн байна. Үзлэгт хамрагдсан эрчүүдээс шинээр 204 өвчлөл илэрч, 74 хүнийг лавлагаа шатлалын эмнэлэгт илгээж, давхардсан тоогоор эмч нар 964 хүнд эмийн эмчилгээ, 1826 хүнд зөвлөгөө өгсөн байна. | |
| | | 70 | Нас баралтын тэргүүлэх шалтгаант өвчний эрт илрүүлэг, үзлэгт хамрагдалтын хувийг нэмэгдүүлнэ. | 2025 | ЭМГ | - | 61.2 | Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг, үзлэгт хамрагдалтын хувь-82 | Эхний 10 сарын байдлаар 34286 хүний 17959 буюу 52.4%-ийг хамруулж, шинээр оношлогдсон 172 хүнийг эмчилгээнд хамруулан хяналтад авлаа. Артерийн даралт ихсэх өвчний хамрагдалт зорилтот түвшнээс бага байгаа нь эрт илрүүлгийн зорилтот нас 18 болж өөрчлөгдсөнөөр хамрагдвал зохих хүн амын тоо нэмэгдсэн, эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой байна. | 90 |
| | | | | | | | 69.7 | Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь-71.6 | Эхний 10 сарын байдлаар 22846 хүний 14368 буюу 62.9% нь хамрагдаж, шинээр оношлогдсон 46 хүнийг эмчийн хяналтад авч эмчилгээнд хамрууллаа. Чихрийн шижингийн үзлэгийн хамрагдалт зорилтот түвшнээс бага байгаа нь эрт илрүүлгийн зорилтот нас 35 болж өөрчлөгдөж хамрагдвал зохих хүн амын тоо нэмэгдсэн, эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой байна. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 18.9 | Зүрх, судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын түвшин /10000 хүн амд, промилиор/-17.9 | Эхний 10 сарын байдлаар зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралт 88 тохиолдол бүртгэгдэж, зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин 10000 хүн амд 15.4 байна. | |
| | | | | | | | 15.9 | Хорт хавдрын өвчлөлийн шалтгаант нас баралтын түвшин /10000 хүн амд, промилиор/-14.9 | Аймагт анх удаа бай эмчилгээг нэвтрүүлж хавдрын хөнгөвчлөх тасагт 134 хүн 8 төрлийн бай эмчилгээ хийлгэлээ. Эхний 10 сарын байдлаар хорт хавдраас шалтгаалсан нас баралтын 56 тохиолдол бүртгэгдэж, хорт хавдрын өвчлөлийн шалтгаант нас баралтын түвшин 10000 хүн амд 9.8 байна. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 24 | 1.2.1.3.Эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийг багасгаж, эх, нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн сэргийлж болох эндэгдлийн түвшинг бууруулна. | 71 | Эх, нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн сэргийлж болох эндэгдлийн түвшинг бууруулна. | 2025 | ЭМГ | | 101.7 | Эхийн эндэгдлийн түвшин /промиль/-0 | Эхийн эндэгдэл гаргалгүй ажиллаж, дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.Үүнд:<br>-“Жирэмсний хяналтын чанарыг сайжруулах” тухай Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны А/88-р тушаал, “Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэл мэдээлэл шинэчлэх” тухай 2025 оны А/127 дугаар тушаалыг тус тус баталж, зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэн мэргэжил арга зүйгээр хангалаа.<br>-“Жирэмсний хяналт, эрсдэлтэй жирэмснийг илрүүлэх тухай” сэдэвт цахим хурлыг 2025 оны 5 дугаар сарын 2-ны өдөр зохион байгуулж, 17 эрүүл мэндийн төвийн 24 эмч, эх баригч нар оролцлоо.<br>-Монголын эх баригчдын нийгэмлэг, АШУҮИС-ийн Сувилахуйн сургуультай хамтран “Эх барихын яаралтай тусламж” сургалтыг зохион байгуулж Нэгдсэн эмнэлэг, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн 28 эх баригч, 6 эх барихын эмч хамрагдлаа.<br>-Улаанбаатар хотод 2025 оны 09 сарын 13-14-ны өдрүүдэд “Эх баригчийн төрөлтийн үед үзүүлэх тусламж, үйлчилгээний ур чадварыг сайжруулах” сэдэвт сургалтад 3 эх баригч оролцлоо.<br>-Өвөрхангай аймагт 2025 оны 11 сарын 01-ний өдөр “Төрөх замын халдвар ба урагдлаас сэргийлэх” сэдэвт сургалтад 3 эх баригч оролцлоо. | 70 |
| | | | | | | | 11.2 | Нялхсын эндэгдлийн түвшин /промиль/-10 | Өнгөрсөн оны мөн үед нялхсын эндэгдэл 12, энэ оны 10 сарын байдлаар 8 тохиолдол бүртгэгдэж, нялхсын эндэгдлийг 4 тохиолдлоор бууруулсан. Нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 11.7 промиль байна. Нялхсын эндэгдэл буурсан боловч түвшин өндөр гарч байгаа нь төрөлт буурсантай холбоотой. | |
| | | | | | | | 12.2 | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /промиль/-11 | Эхний 10 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 9 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 13.2 промиль болж өмнөх оны мөн үеэс 7.6 промилиор бууруулсан. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 72 | Цахим бүртгэлтэй уялдуулан "Нэрийн хяналт"-ыг хэрэгжүүлж, жирэмсний эрт үеийн хяналтын хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | 2025 | ЭМГ | | 94 | Жирэмсний эрт үеийн хяналтын хувь-94.5 | Эхний 10 сарын байдлаар шинээр 617 жирэмсэн эх хяналтад орж, жирэмсний эрт үеийн хяналт 94.7%-тай байна. | 100 |
| | | 73 | 0-1 насны хүүхдийн гэрийн эргэлтийн хувийг нэмэгдүүлнэ. | 2025 | ЭМГ | | 72.1 | Гэрийн эргэлтийн хувь-74.1 | Эхний 10 сарын байдлаар 897 хүүхдийн 657 буюу 73.2%-ийг гэрийн эргэлтэд хамрууллаа. | 90 |
| | | 74 | 6-15 насны хүүхдийн стрептококкийн шалтгаант хоолой залгиурын үрэвсэл, хэрх, хэрхийн шалтгаант зүрхний эмгэгийн эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулна. | 2025 | ЭМГ | | - | Хамрагдалтын хувь-50 | “Стрептококкийн ангина, фарингит, хэрэх өвчин, хэрэхийн шалтгаант зүрхний олдмол гажгийг эрт оношлох” эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, 1-12 дугаар ангийн 12613 хүүхдээс 10968 буюу 86.9%-ийг хамрууллаа. Стрептококкийн түргэвчилсэн оношлуур эерэг илэрсэн 883 хүүхдийн 283 буюу 32%-ийг Нэгдсэн эмнэлэгт үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулан өрх, сумын эрүүл мэндийн төвийн хяналтад товлолын дагуу “Бензатинпенициллин Ж” тариагаар эмчилгээ хийж байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 75 | Хүүхдийн шүдний үзлэг, оношилгоог тогтмол зохион байгуулж, шүд цоорлын хувийг бууруулна. | 2025 | ЭМГ | | 64.1 | Шүд цоорлын хувь-59.1 | 11 сумын 2-12 насны, аймгийн төвийн 3 сургуулийн 6-12 насны хүүхдийн дундах шүдний өвчлөлийн судалгаа хийхэд шүдний цоорол 78.4%-тай байсан. "Шүдээ зөв угаая" 24/3 аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж, 5098 хүүхэд, насанд хүрэгч сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамрагдаж, 7 сургууль шинээр шүд угаах цэг байгуулж, сурагчдын үдийн хоолны дараа "Шүд угаах цаг"-ийг 15 сумын 91 бага анги хэвшүүлж, 4471 хүүхэд шүдээ сургууль дээрээ угаах боломж бүрдлээ. 15 сумын сургуулийн өмнөх 105 бүлэг шүд угаах булан байгуулснаас 71 бүлгийн 1747 хүүхэд шүдээ тогтмол угаадаг болсон. Энэ онд 1-р ангийн нийт суралцагчдын шүдний эмгэгийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, аймгийн хэмжээнд хамрагдвал зохих 1145 хүүхдээс 1112 буюу 97.1%-ийг хамруулахад 636 буюу 57.2% нь шүд цооролтой байна<br>Хүүхэд бүрийн эрүүл шүдэнд фторт хамгаалах түрхлэг, байнгын 5, 6 дугаар араанд ховил битүүлэгч тавьж, шүдний өвчлөлтэй гарсан 656 хүүхдийн 5-6 шүдийг эмчиллээ. | 100 |
| 25 | 1.2.1.4.Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлнэ. | 76 | Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний өдрийн эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2025 | ЭМГ | | 15 | Амбулаториор үйлчлүүлсэн иргэдийн өдрийн эмчилгээнд хамрагдалтын хувь-20 | Өдрийн эмчилгээний өрөөг дотоод нөөцөө ашиглан 700,0 мянган төгрөгөөр тохижуулж, үйлчлүүлэгч нарыг эрэгтэй, эмэгтэй хүйсээр нь үйлчлэх боломжтой болгож, өдрийн эмчилгээний сувилагчийг томилон ажиллууллаа. Эхний 10 сарын байдлаар нийт амбулаторийн үзлэгт 1706 иргэн хамрагдсанаас 358 буюу 20.9% нь өдрийн эмчилгээнд хамрагдлаа. | 100 |
| | | 77 | Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ. | 2025 | ЭМГ | СОНТ 10,0 | 2 | Нэмэгдүүлсэн тусламж үйлчилгээний нэр төрлийн тоо-1 | Есөнбулаг сумын орон нутгийн 10,0 сая төгрөгийн санхүүжилтээр “Зүү эмчилгээний кабинет”-ийг байгуулж, 10 сарын байдлаар 799 хүн зүү эмчилгээнд хамрагдлаа. Эмчилгээний үр дүнд харвалтын дараах саажилтын эмчилгээний хугацаа 1 дахин богиносож, харвалтын дараах үлдэц хэлгүй болсон 1 үйлчлүүлэгч хэл орсон, зогисох эмгэгтэй эмчлүүлэгчийн зогисолт эмчилгээний 1 дэх хоногоос бүрэн намдсан байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 26 | 1.2.1.5.Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгад хяналт тавьж, цахим худалдан авалтын хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 78 | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгслийн цахим худалдан авалтын хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2025 | ЭМГ | УТ 347,0 | 80 | Эм, эмнэлгийн хэрэгслийн цахимаар худалдан авалтын хувь-81 | Ерөнхий гэрээгээр буюу цахим худалдан авалтаар сум, өрхийн эрүүл мэндийн төвтэй 108 нэрийн 347,0 сая төгрөгийн гэрээ байгуулж татан авч түгээлээ. Эм, эмнэлгийн хэрэгслийн цахимаар худалдан авалт 100%-тай байна. | 100 |
| | | 79 | Эм эмнэлгийн хэрэгслийн захиалгад тавих хяналт, бүртгэлийг сайжруулна. | 2025 | ЭМГ | | 90 | Цахим бүртгэл шивэлтийн хувь -92 | Сум өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн цахим тендерийн захиалгыг нэгтгэн Төрийн худалдан авах ажиллагааны онлайн дэлгүүрт шивэлтийг цаг тухайд нь 100% бүртгэж байна. | 100 |
| | | | | | | | 22 | Хяналт тавих байгууллагын тоо-22 | Анхан шатны 22 эрүүл мэндийн төвийн захиасыг хянан баталгаажуулж, төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт шивэлтийг хийлээ. Ерөнхий гэрээний захиалгад хяналт хийж нийлүүлэх эмүүдийг ширхэгээр биш савлагаагаар нь ирүүлсэн үнийн зөрүү 10 нэрийн 2,1 сая төгрөгийн зөрчлийг арилгалаа | |
| 27 | 1.2.1.6.Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ. | 80 | Гадаад, дотоодын богино болон урт хугацааны сургалт, төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад эрүүл мэндийн ажилтныг хамруулж, мэдлэг, мэргэшил ур | 2025 | ЭМГ | | 8 | Гадаадад сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо-8 | Солонгос улсад Нэгдсэн эмнэлгийн захирал, зүрхний эмч, лабораторийн эмч, БНХАУ-ын ӨМӨЗО-д ЭМГ-ын хүний нөөцийн мэргэжилтэн, Нэгдсэн эмнэлгийн сэргээн засал судлалын эмч, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн эмчлэгч эмч, сэргээн засахын сувилагч нийт 7 мэргэжилтэн сургалтад хамрагдлаа. | 90 |
| | | | | | | УТ-20,2 | 43 | Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо-45 | Эрүүл мэндийн хөгжлийн төвд 2025-2026 оны хичээлийн жилд үндсэн мэргэшил судлал сургалтад 8 их эмч, төрөлжсөн мэргэшил олгох сургалтад 12 их эмч, 17 сувилагч, мэргэжил дээшлүүлэх сургалтад 2 их эмч, 2 эмнэлгийн тусгай мэргэжилтэн нийт 41 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | чадварыг дэээшлүүлнэ. | | | | 862 | Богино хугацааны сургалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо-862 | Эрүүл мэндийн салбарын 3 удаагийн зөвлөгөөнд 72, богино хугацааны танхимын 34 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1096, цахимаар 10 удаагийн сургалтад 238 нийт 1408 эрүүл мэндийн ажилтан хамрагдлаа. | |
| | | | | | | Төсөл хөтөлбөр 10,0 | 12 | Гадаадын болон улсын эмнэлгүүдэд туршлага судлуулсан албан хаагчдын тоо-19 | Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 9 эрүүл мэндийн ажилтан Орос улсад 7 хоногийн хугацаатай туршлага судаллаа. | |
| | | | | | | | 2 | "Яаралтай тусламж судлал" мэргэшил олгох сургалтад хамруулсан багийн эмчийн тоо-5 | "Яаралтай тусламж судлал" мэргэшил олгох сургалтад Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг, Цээл, Чандмань, Эрдэнэ сумдын эрүүл мэндийн төвийн нийт 5 сувилагч суралцаж байна. | |
| | | 81 | Сумдын бүсийн ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулна. | 2025 | ЭМГ | | - | Зохион байгуулсан уралдааны тоо-2 | Эрүүл мэндийн салбарын бүсийн зөвлөлдөх уулзалтыг "Туршлагаа хуваалцъя- Харилцан суралцъя" уриан дор Дэлгэр, Цогт сумдад зохион байгууллаа.<br>Нэгдүгээр бүсийн уулзалтад Тайшир, Гуулин, Чандмань, Бигэр, Халиун, Дарив, Хөхморьт, Баян-Уул, Дэлгэр сумдын эрүүл мэндийн төвийн 150, хоёрдугаар бүсийн уулзалтад Алтай, Баянтоорой, Бугат, Жаргалан, Төгрөг, Цогт, Цээл, Шарга, Эрдэнэ сумдын эрүүл мэндийн төвийн 130 нийт 280 эрүүл мэндийн ажилтан оролцож, 11 төрлийн ажил мэргэжлийн уралдаан, спорт, урлагийн уралдаан зохион байгууллаа. Нийлбэр дүнгээр 1-р бүсэд Баян-Уул, 2-р бүсэд Төгрөг сумын эрүүл мэндийн төвүүд тэргүүн байр эзэлж Монософарм ХХК-ийн нэрэмжит шилжин явах цомын эзэн боллоо. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 82 | Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах хөтөлбөрт эрүүл мэндийн салбарын албан хаагчдыг хамруулна. | 2025 | ЭМГ | | 80 | Дэмжлэг үзүүлсэн эрүүл мэндийн ажилтны тоо-80 | Төрийн албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх журмыг шинэчлэн боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар тогтоолоор батлуулсан. Төрийн байгууллагуудаас орон сууцны дэмжлэгт хамрагдах хүсэлтэй, шаардлага хангасан төрийн албан хаагчдын материалыг журмын дагуу хүлээн авч, 12 сард дэмжлэгийг олгохоор ажиллаж байна. | 100 |
| 28 | 1.2.1.7.Иргэдэд үзүүлэх яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэн цахим эрүүл мэндийн дэвшилтэт алсын зайн технологийг нэвтрүүлж, эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санд их өгөгдөл үүсгэнэ. | 83 | Дэлгэр, Шарга сумдын эрүүл мэндийн төвүүдэд ослын үеийн яаралтай түргэн тусламж үзүүлэх нэгж байгуулна. | 2025 | ЭМГ | | 0 | Байгуулсан яаралтай тусламжийн нэгжийн тоо-1 | Дэлгэр сумын эрүүл мэндийн төвд нэгж байгуулж, тусламж үйлчилгээ үзүүлэх 3 багийг томилон тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган ажиллаж байна. | 100 |
| | | 84 | Дүрс дамжуулах, хадгалах PACS системийг нэвтрүүлнэ. | 2025 | ЭМГ | | 0 | Системийг нэвтрүүлсэн байгууллагын тоо-1 | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт PACS системийг нэвтрүүлж, дүрс, бичлэгийн 3000 мэдээлэл дамжуулагдаж хадгалагдсан байна. | 100 |
| | | 85 | Явуулын эмнэлгийн бүрэн тоноглогдсон автомашинаар хангана. | 2025 | ЭМГ | Төсөл хөтөлбөр 3.100,0 | - | Бүрэн тоноглогдсон автомашины тоо-2 | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Эрүүл мэндийн яамны хэрэгжүүлж буй "Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхыг бэхжүүлэх" MOH-9218 төсөл, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/93 дугаар тушаалаар нийлүүлэгдсэн 3,1 тэрбум төгрөгийн үнэ бүхий иж бүрэн тоноглогдсон явуулын 2 автомашиныг Нэгдсэн эмнэлэгт нийлүүллээ. | 100 |
| | | 86 | Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг, Баянтоорой, Гуулин тосгон, Тонхил, Шарга, Төгрөг, Дэлгэр, Алтай сумын эрүүл мэндийн | 2025 | ЭМГ | Төсөл хөтөлбөр 417,3 | 11 | Парк шинэчлэлт хийгдсэн автомашины тоо-3 | Дэлхийн банкны санхүүжилтээр Гуулин тосгон, Шарга сумын Эрүүл мэндийн төвүүдийг 417,3 сая төгрөгийн LandCruiser J78 маркийн түргэн тусламжийн автомашинаар хангалаа. Дэлгэр сумын эрүүл мэндийн төвд Халиун сумын эрүүл мэндийн төвийн УАЗ469 маркийн автомашиныг шилжүүллээ. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төвүүд, Есөнбулаг сумын өрхийн эрүүл мэндийн төвүүдэд автомашины парк шинэчлэлтийг ээлж дараатайгаар хийнэ. | | | | | | | |
| | | 87 | Багийн эмчийн унааг ээлж дараатайгаар шинэчилнэ. | 2025 | ЭМГ | ОНХС 200,0<br><br>Хандив тусламж-750,0 | 0 | Унаажуулсан багийн эмчийн тоо-16 | Нийт 60 багийн эмчийг унаажуууллаа. Үүнээс 18 сумын 46 багийн эмчийг Probox автомашинаар хангаж, 14 багийн эмчид автомашин гардуулахаар хүлээгдэж байна.<br>-Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 200 сая төгрөгийн санхүүжилтээр 8 багийн эмчийг унаажуулах автомашины тендерт шалгарсан “Тэргүүн Хийц” ХХК нь Хөхморьт сумын Хүйсийн говь, Сангийн далай, Баян-Уул сумын  Алтангадас, Баянговь, Тонхил сумын Алтансоёмбо, Дарив сумын Хужирт, Дэлгэр сумын Баянхонгор, Жаргалан сумын Тээл баг<br>-Нийгмийн хариуцлагын хүрээнд 750,0 сая төгрөгийн санхүүжилтээр “Хан-Алтай ресурс” ХХК, “Цэн Газар” ХХК, “Хос Кварц” ХХК, “Цэрдийн тал” ХХК гэрээ байгуулан Тонхил сумын Зүйл, Бүс , Цогт сумын Баян-Өндөр, Далан, Рашаант, Гэгээт, Баян-Уул сумын Чандмань хайрхан, Баян хайрхан, Шарга сумын Сондуулт, Хамтын хүч, Улаан туг, Тайшир сумын Хуримт, Далан, Галуут, Дэлгэр сумын Баян-Өндөр, Алтай сумын Баянцагаан, Халиун сумын Чацран, Эрдэнэ сумын Сангийн далай, Цээл сумын Дэрстэй, Төгрөг сумын Төгрөгийн эх, Бигэр сумын Мянгай, Хүрэмт, Их булаг, Бугат сумын Ферм, Сүж, Чандмань сумын  Өлзийбулаг, Эрдэнэ-Уул, Есөнбулаг сумын Наран, Жаргалан сумын Завхан гол, Дарив сумын Жавхлант багийн 30 эмчид олголоо. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 88 | Эрүүл мэндийн байгууллагын оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлнэ. | 2025 | ЭМГ | Улсын төсөв 54,7 Хандив 8,2 Төсөл хөтөлбөр 149,6 | 12 | Тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо-6 | Эхний 10 сарын байдлаар 24 эрүүл мэндийн байгууллагад 9 нэр төрлийн 91 ширхэг 212,5 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдлээ. Үүнд:<br>-“Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд 76,9 сая төгрөгийн Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат 17 сум, 2 тосгон, 3 өрхийн эрүүл мэндийн төвд, Люксембургийн Их Гүнт улсын буцалтгүй тусламжаар “Монгол Улс дахь зүрх судлал, зүрхний мэс засал ба телемедицин” МОН/007 төслийн хүрээнд Нэгдсэн эмнэлэгт нийт 22,6 сая төгрөгийн 5 нэр төрлийн 10 ширхэг тоног төхөөрөмж, Бүгд найрамдах Австрали улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр “Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээ байгуулах” төслийн хүрээнд Нэгдсэн эмнэлэгт 50,1 сая төгрөгийн ходоодны дуран, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/234, 269 дүгээр тушаалаар Алтай, Жаргалан сумын эрүүл мэндийн төвд 54,7 сая төгрөгийн зөөврийн ЭХО аппарат, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд 2,7 сая төгрөгийн үнэ бүхий 54 ширхэг пульсоксиметрийг 19 эрүүл мэндийн байгууллагад, Зоонозын өвчин судлалын төвд улсын төсвийн 5,5 сая төгрөгөөр 2 нэр төрлийн 2 ширхэг лабораторийн хэргэгч тус тус нийлүүллээ. | 100 |
| | | 89 | Эрүүл мэндийн газрын компьютер, техник хэрэгслийг шинэчилнэ. | 2025 | ЭМГ | | 0 | Шинэчилсэн компьютерийн тоо-13 | Эрүүл мэндийн газарт шаардлагатай 28 компьютерийн 109,1 сая төгрөгийн санхүүжилттэй төслийг “Хан-Алтай” ресурс компанид хүргүүллээ. 9 компьютерийг хандиваар шинэчиллээ. | 70 |
| | | 90 | Нэгдсэн эмнэлгийн мэс заслын вакум өрөөг засварлаж, тоног төхөөрөмжөөр хангана. | 2025 | ЭМГ | УТ 1.400,0 | - | Хэрэгжилтийн хувь-100 | Улсын төсвийн 1.400,0 сая төгрөгөөр Нэгдсэн эмнэлэгт “Мэс заслын вакум өрөөний засвар, тоног төхөөрөмж худалдан авах” ажлыг “Жи Гоулд” ХХК-аар гүйцэтгүүлэн хүлээн авч, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. | 100 |
| | | 91 | Иргэдэд үзүүлэх яаралтай тусламжийн бэлэн байдлын хувийг нэмэгдүүлнэ. | 2025 | ЭМГ | | 80.4 | Бэлэн байдлын хувь-83 | 23 эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн бэлэн байдал 88%, тоног төхөөрөмжийн хангалт 85%, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц 90%-тай байна.<br>Яаралтай тусламжийн 3 удаагийн сургалтад давхардсан тоогоор 180 эмч, 134 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 30 | 1.2.1.9 Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлж, даатгалын хамралтыг нэмэгдүүлэн, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын болон санхүүгийн шалгуур үзүүлэлтийн дагуу хяналтыг хэрэгжүүлнэ. | 92 | Малчин, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд, оюутнуудыг эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулна. | 2025 | ЭМДХ | | 88 | Хамрагдсан иргэдийн хувь-90 | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын А/12 дугаар тушаалаар баталсан хамралтын төлөвлөгөөний хүрээнд нийт 2904 иргэн хамруулахаас 989 малчин, 727 оюутан, ажил хөдөлмөр эрхлээгүй  577 иргэн, нийт 2293 иргэн хамрагдлаа. Хамрагдалтын хувь 78.9 хувьтай байна. | 70 |
| | | 93 | Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт  эрүүл мэндийн байгууллагууд нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ. | 2025 | ЭМДХ | | 54 | Хяналт хийгдсэн эрүүл мэндийн байгууллагын тоо-56 | 2025 онд тус аймгийн хэмжээнд эрүүл мэндийн даатгалын гэрээтэй Нэгдсэн эмнэлэг, уламжлалт анагаах ухааны төв, өрхийн болон сумдын эрүүл мэндийн төв, эмийн сан зэрэг нийт  56 байгууллага  нийт 165,108 даатгуулагч иргэнд 15.1 тэрбум төгрөгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Дээрх байгууллагуудын нэхэмжлэлийн хяналтаар 555 даатгуулагч иргэний 488.8 сая төгрөг хасагдсан байна. Мөн улсын хэмжээнд эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн тусламж, үйлчилгээний санхүүжилтэд хяналт, үнэлгээ хийж,  565 эрүүл мэндийн байгууллагын  19.5 тэрбум төгрөгийн нэхэмжлэл бүхий 15,475 өвчний түүхэнд эмнэл зүйн удирдамжид нийцсэн эсэхийг шалгуур үзүүлэлтээр үнэлэн нэхэмжлэлийн нарийчилсан хяналт хийсэн.<br>Хяналтын үр дүнд: 1,022 өвчний түүхийн  441.3 сая төгрөгийн санхүүжилтийг  чанар, төлбөрийн шаардлага хангаагүй гэж үзэн хасагдсан байна. | 100 |

**1.3.Хүн бүр чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролд хамрагдалтын түвшинг нэмэгдүүлнэ.**

**1.3.1.Боловсролын чанарыг сайжруулж, эрдэм мэдлэгтэй чадварлаг иргэдийг бэлтгэнэ.**

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 31 | 1.3.1.1.“Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 94 | Чанартай боловсролыг тэгш хүртээмжтэй олгож сургалтын чанарыг сайжруулан, элсэлтийн шалгалт, гүйцэтгэлийн үнэлгээнд ахиц гаргана. | 2025 | БГ | ОНТ 48.3 | 510.5 | Элсэлтийн шалгалтын хэмжээст онооны дундаж-512 | Элсэлтийн шалгалтын хэмжээст оноогоор 9-р байранд эрэмбэлэгдэж өмнөх оноос 2 байраар урагшиллаа. Амжилт гаргасан багш, сурагч, байгууллагыг 310.0 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа.<br>Элсэлтийн шалгалтад бэлтгэх зорилгоор "Алтайн ЭШ-2025" 5 сарын аяныг зохион байгуулж 12 чиглэлийн ажил төлөвлөн 100% хэрэгжүүллээ. ЭШ-ын сорилгод цахимаар 11138, цаасан суурьтай сорилгод 1604 сурагч хамруулж, цахим болон танхимын 1558 цагийн давтлагад давхардсан тоогоор 20692 сурагч хамрагдлаа.<br>2025 оны элсэлтийн шалгалтад давхардсан тоогоор 2141 шалгуулагч 10 судлагдахуунаар хамрагдаж, элсэлтийн шалгалтын хэмжээст оноо 510.1 болж улсын дунджаас 10.1-ээр өндөр үзүүлэлттэй байна. Элсэлтийн шалгалтын даалгавар, агуулга хүндэрсэнтэй холбоотойгоор хэмжээст онооны дундаж улсын хэмжээнд буурсан байна. | 90 |
| | | 95 | Гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан сургууль, цэцэрлэгийн менежментийг сайжруулна. | 2025 | БГ | УТ-28.4 | сургууль-13, цэцэрлэг-1 | Менежментийг хэрэгжүүлж буй сургууль-28, цэцэрлэг-3 | Сургууль, цэцэрлэгийн менежментийг сайжруулах зорилгоор Баян-Уул, Дэлгэр, Баянтоорой, Хөхморьт, Тайшир, Алтай, Бугат, Цээл, Халиун, Жаргалан сумдын сургуулийн менежментийн зураглалд дүн шинжилгээ хийж, зөвлөн туслан 600 гаруй багш, ажилтанд “Байгууллагын менежмент” сургалтыг зохион байгуулж ажиллалаа.<br>Ерөнхий боловсролын сургуулиудад сургуулийн менежментийг сайжруулах чиглэлээр цахим сургалтыг 1 удаа зохион байгуулж Баянхонгор аймгийн менежментийг хэрэгжүүлж байгаа туршлагыг түгээж ажиллалаа. Ерөнхий боловсролын 28 сургууль “Хамтдаа хөгжье” аянаар 5 баг болон сургуулийн менежментийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллаж байна.<br>"Алтайн боловсролын хөгжил, менежмент" удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж 28 сургуулийн захирал, 31 цэцэрлэгийн эрхлэгч, Боловсролын газрын дарга, мэргэжилтнүүд оролцлоо. Менежментийг 28 сургууль, 5 цэцэрлэгт хэрэгжүүлж байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 80.3 | Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь-81 | Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 31 цэцэрлэг, бүлгийн 141, хөгжмийн 10, биеийн тамирын 5, нийт 156 багш хамрагдаж багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж 91.1%-д хүрсэн нь өмнөх оноос 7.7 хувиар ахисан, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний дундаж 90.3%-тай үнэлгдсэн нь өмнөх оноос 6.9 хувиар ахисан байна.<br>Ерөнхий боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд 28 сургууль, 732 багш, 16006 сурагч үнэлгээнд хамрагдаж багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж 79.4%-д хүрч өмнөх оноос 2.4 хувиар ахисан, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний дундаж 83.9%-тай үнэлэгдэж өмнөх оноос 6.8 хувиар ахисан байна. | |
| | | 96 | Сурлагын чанарыг үнэлэх, нэмэгдүүлэх аймгийн Засаг даргын нэрэмжит анги нийтийн сорилго зохион байгуулна. | 2025 | БГ | | 55.6 | Үнэлгээний дундаж хувь-58.6 | Аймгийн Засаг даргын нэрэмжит анги нийтийн сорилгод 59 төрлийн хичээлээр 755 багшийн давхардсан тоогоор 28000 хүүхдийг хамруулан зохион байгуулсан. Шалгалтын үр дүнд англи хэл 66.4%, биологи 68.5%, Газар зүй 71.3%, Дизайн зураг зүй 58.8%, иргэний ёс зүй 51.7%, математик 62%, монгол хэл 64.7%, монголын түүх 67.3%, мэдээллийн технологи 42.9%, нийгэм судлал 58.2%, орос хэл 63%, түүх 57.2%, физик 48.4%, хими 58.8%, эрүүл мэнд 56.4%, бага боловсрол 55.4%, хөгжим 61.8%-тай шалгагдаж ерөнхий дундаж гүйцэтгэл 60.7% байна. Үүнээс 330 багш 65%-с дээш үнэлгээтэй шалгагдсан. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 97 | Ахиц амжилт гаргасан шилдэг багш, ажилтан, удирдлага, хамт олныг шагнаж урамшуулна. | 2025 | БГ | ОНТ 601.5 | 100 | Хэрэгжилтийн хувь-100 | Улсын төрөлжсөн олимпиадын 94 төрөл, нэрэмжит 6 олимпиадад амжилттай оролцсон багш, сурагчдыг 197,9 сая төгрөгөөр, олон улс, улс, бүс, элсэлтийн шалгалтад амжилт гаргасан багш сурагчдыг 443.6 сая төгрөгөөр тус тус шагнаж урамшууллаа. Үүнд: улсын төрөлжсөн олимпиадын 3-ын давaанд тэргүүн байр 2, 2-р байр 3, 3-р байр 6, тусгай байр 2 эзэлсэн. Монгол бичгийн анги нийтийн олимпиадад 3-р байр, улсын тэргүүний уншигч шалгаруулах уралдаанд 1-р байр, "Миний монгол бичиг" олон улсын уралдаанд тэргүүн байр 1, 3-р байр 1, техник технологийн 26-р олимпиадын багийн төрөлд 2-р байр, нийт улсын олимпиадад 16 байр эзэлсэн. Аймгийн Засаг даргын нэрэмжит улсын төрөлжсөн олимпиадын 2-ын давaанд амжилт гаргасан багш сурагчдын урамшуулалд 38.9 сая төгрөг, улсын төрөлжсөн олимпиадын 3-н давaанд амжилт гаргасан багш сурагчдыг 129.0 сая төгрөгөөр тус тус урамшуулсан. Элсэлтийн шалгалтад 650 дээш оноо авсан сурагчид, 700-аас дээш оноотой шавь бэлтгэсэн багш нар, аймагт тэргүүлсэн сургууль хамт олныг нийт 316.0 сая төгрөгөөр шагнасан. Олон улс, улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнд 1-3 дугаар байр эзэлсэн багш нарыг 117.6 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа. | 100 |
| | | 98 | Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний олон хувилбарт загварыг хөгжүүлнэ. | 2025 | БГ | | 86 | Хамран сургалтын хувь-87 | Аймгийн хэмжээнд 31 цэцэрлэгийн 172 бүлэгт нийт 4112 хүүхэд суралцаж хамран сургалт 89,1%-тай байна. 2024-2025 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлж буй 31 цэцэрлэгийн 172 бүлэгт нийт 4300 хүүхэд хамрагдаж байна. Үүнээс 3900 нь үндсэн бүлэгт, 400 нь хувилбарт сургалтад хамрагдсан. Цэцэрлэгийн байгууллагын дэргэдэх салбар бүлэгт 25, Бугат, Баян-Уул, Тонхил, Халиун сумдын салбар бүлэгт тус бүр 14-28 хүүхдийг хамруулан гэрт ойр цэцэрлэгт сурч хөгжих боломжийг олгон ажиллалаа.<br>2025 оны 5-8 дугаар сарууд 18 цэцэрлэг нүүдлийн бүлэг ажиллуулж 420 гаруй хүүхдийг хамрууллаа.<br>2025-2026 оны хичээлийн жилд 31 цэцэрлэгийн 172 бүлэгт 4112 хүүхэд хамрагдаж байгаагаас үндсэн сургалтад 3761, хувилбартад 351 хүүхэд суралцаж байна. СӨБ-д шинээр элсэн орсон 1401, хөгжлийн бэрхшээлтэй 21, малчдын 1119, хагас өнчин 39, бүтэн өнчин 1 хүүхэд суралцаж байна. | 100 |
| | | 99 | Бага насны хүүхдийн цогц хөгжлийн | 2025 | БГ | | 90 | Хэрэгжилтийн хувь-95 | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих аймгийн салбар дундын төлөвлөгөөг 4 зорилт, 33 арга хэмжээний хүрээнд 97.4 хувьтай хэрэгжүүллээ. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | | | | | | |
| | | 100 | Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах хөтөлбөрт боловсролын салбарын албан хаагчдыг хамруулна. | 2025 | БГ | | 160 | Хамрагдсан хүний тоо-100 | Төрийн албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх журмыг шинэчлэн боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар тогтоолоор батлуулсан. Төрийн байгууллагуудаас орон сууцны дэмжлэгт хамрагдах хүсэлтэй, шаардлага хангасан төрийн албан хаагчдын материалыг журмын дагуу хүлээн авч, 12 сард дэмжлэгийг олгохоор ажиллаж байна. | 100 |
| | | 101 | "Монгол бичигтэн аймаг" арга хэмжээг зохион байгуулна. | 2025 | БГ | | 9000 | Хамрагдсан хүний тоо-9100 | "Монгол бичигтэн аймаг" арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаануудад давхардсан тоогоор нийт 9949 хүн хамрагдлаа.  Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 25 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Төрийн албан хаагчдын монгол бичгийн чадварыг нэмэгдүүлэх зорилготой “Алтан хонх” уралдаан зохион байгуулж 13 байгууллага, “Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх тухай” сургалтад 163 төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан, бичиг хэргийн эрхлэгч, “Цахим монгол бичгийн уралдаан”-д 21 байгууллага оролцлоо. Үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд зохион байгуулсан 12 арга хэмжээнд давхардсан тоогоор 4000 орчим хүн оролцлоо. Монгол бичгийн улсын XIX олимпиадын II давaанд нийт 2653 сурагч, 19 багш хамрагдаж 3-р шатнаас 1 анги хүрэл медаль, 1 сурагч тэргүүний уншигч, 1 багш 3-р байр, 1 сурагч тэргүүн байр, 1 багш тусгай байрын шагнал хүртлээ. Монгол хэл бичгийн 3 удаагийн нэрэмжит олимпиад зохион байгуулж, 280 багш, сурагч хамруулан ивээн тэтгэгчдийн зүгээс нийт 12.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мэргэжлийн багш нарт арга зүй, ур чадвар олгох сургалтад 30 багш хамрагдсан. Монгол хэлний 80 багшийг мэргэжил арга зүйгээр хангаж 8 удаагийн цахим уулзалт сургалт зохион байгуулж, цахим хэрэглэгдэхүүн, сорил даалгаврын 1 бүлгэм ажиллуулж тогтмол шинэчлэн ажиллаж байна. Монгол хэл бичгийн судлагдахууны нийт багшийн заадаг ангиас чанарын үнэлгээний сорилго авахад 1730 сурагч хамрагдаж 64,7%-ийн дундаж үнэлгээтэй байна. Монгол бичгийн сургалт, судалгааны "Ертөнц" төвтэй хамтран Монгол бичгийн сургалтыг 947 сурагч, монгол хэлний багшийг хамруулан зохион байгуулсан. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 102 | Ерөнхий боловсролын сургуульд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжилтэй боловсон хүчин сургаж бэлтгэх үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | 2025 | БГ | | 2 | Арга хэмжээний тоо-3 | “Мэргэжил бүхэн сайхан” ажлын байрны танилцах аялалд 12 дугаар ангийн 45 суралцагчийг МБС-ийн хүнд машин механизмын операторч, үсчин гоо сайханч, талх нарийн боовчин мэргэжлийн ангиудын онцлог болон ажлын орчинтой танилцуулсан. Уул уурхайн мэргэжлийн чиглэлээр “Хан-Алтай” ресурс компанийн үйл ажиллагаатай танилцуулах аяллыг зохион байгуулж 91 суралцагч хамрагдлаа. Байгалийн ухаан, инженерчлэлийн чиглэлээр "MY CAREER DAY" ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, уулзалтыг зохион байгуулж, дунд ахлах ангийн 400 орчим суралцагч хамрагдлаа. "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох" үйл ажиллагааны хүрээнд 9-р ангийн 472 хүүхдийг Мэргэжлийн боловсролын сургуультай, 11-р ангийн 415 хүүхдийг АШУҮИС-ийн үйл ажиллагаатай танилцуулах аяллыг зохион байгууллаа. "Ирээдүйн иргэний хөгжил" ТББ-тай хамтран зохион байгуулсан "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох" сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд 1-р сургуулийн 12-р ангийн 198 суралцагч хамрагдлаа. | 100 |
| | | 103 | Насан туршдаа суралцахуйг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулна. | 2025 | БГ | | 1 | Арга хэмжээний тоо-2 | Багшийн хувь хүний хөгжлийг дэмжих ажлын хүрээнд Мэргэжлийн боловсролын сургуулийн 40 багшид "Судалгааны арга зүй", "Хүний эрхийн тухай ойлголт", "Хөдөлмөрлөх эрхийн зарим асуудлууд" сэдвээр зорилтот сургалтыг зохион байгууллаа. "Суралцагч багш, ажилтан" арга хэмжээг Мэргэжлийн боловсролын сургуультай хамтран зохион байгуулж, цахилгаанчин, сантехникч, оёдолчин мэргэжлээр сертификат олгох богино хугацааны зорилтот түр сургалтад боловсролын салбарын 60 гаруй албан хаагч хамрагдаж, гэрчилгээ гардан авлаа. | 100 |
| | | 104 | IQ, EQ чадварыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулна. | 2025 | БГ | | 1 | Арга хэмжээний тоо-2 | 2025-2026 оны хичээлийн жилд Оюуны хөгжлийн IQ төвтэй хамтран 115 багшийг сэтгэх чадварын сургагч багшаар бэлтгэж, сурагчдын сэтгэх чадварыг сайжруулах дугуйлан хичээллүүлэх боломжийг бүрдүүллээ. Сэтгэх чадварын дугуйланд 1500 орчим хүүхэд суралцаж байгаа бөгөөд сэтгэх чадварын уралдааныг 2 үе шаттай зохион байгуулж, шалгарсан сурагчид олон улсын уралдаанд амжилттай оролцлоо. Сурагчдын EQ чадварыг хөгжүүлэх чиглэлээр “Үе тэнгийн дээрэлхэлт”, “Мэргэжил сонголт” сэдвүүдээр Баянтоорой, Алтай, Цээл, Бугат, Халиун, Жаргалан сумдын 8-12-р ангийн 350 орчим сурагчдад хувь хүний хөгжилтэй уялдуулан сургалт үйл ажиллагааг зохион байгууллаа. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 32 | 1.3.1.2."Дэлхийн боловсролыг Алтайдаа" эзэмших нөхцөл боломжийг бүрдүүлнэ. | 105 | Албан хаагчдыг дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад туршлага судлуулна. | 2025 | БГ | | 0.14 | Хамрагдалтын хувь-10 | Монгол хэлний 3 багш Япон улсын Шинжикү хотын дунд сургуультай танилцах, туршлага судлах, Есөнбулаг, Хөхморьт, Дэлгэр, Шарга сумын орос хэлний 5 багш ОХУ-ын Горно Алтай улсын их сургуульд мэргэжил дээшлүүлэх сургалтад тус тус хамрагдлаа. "Хил орчмын бүс нутагт орос хэлийг судлах, хамгаалах асуудал" сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний III бага хуралд Есөнбулаг, Дарив сумын орос хэлний 2 багш оролцож илтгэл тавьж, туршлага судаллаа. Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан ахлах арга зүйч Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөх хотод "Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийн арга зүй" 14 хоногийн сургалтад, монгол хэл, уран зохиолын боловсрол хариуцсан ахлах арга зүйч Өвөр Монголын Их сургуульд "Боловсрол 7" хөтөлбөрт хамрагдаж туршлага судлан, 10 хоногийн сургалтад тус тус хамрагдлаа. On happy сургалтын байгууллагатай хамтран БНСУ-д их дээд болон дунд сургуулиудын сургалтын үйл ажиллагаатай танилцах, сургалтын шинэ хөтөлбөрүүдийг турших чиглэлээр 30 багш, БНСУ-ын New robot компанитай хамтран сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах чиглэлээр СӨБ-ын 30 багш, дунд сургуулийн үйл ажиллагаа, дрон кодчилол, хиймэл оюун ухааны чиглэлээр ЕБС-ийн 30 багш хамрууллаа. | 100 |
| | | 106 | Олон улсын хөтөлбөртэй анги байгуулж, сургалтын төвүүдийн үйл ажиллагааг дэмжинэ. | 2025 | БГ | | 0.5 | Хамрагдсан хүүхдийн эзлэх хувь-10 | Pearson олон улсын англи хэлний хөтөлбөрийг 2025-2026 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд төрийн өмчийн ерөнхий боловсролын 27 сургуулийн 3, 4-р ангид амжилттай хэрэгжиж байна. Pilot-38 туршилтын хөтөлбөр нь улсын хэмжээнд 38 сургуульд хэрэгжиж байгаагаас Цээл сумын ерөнхий боловсролын сургууль сонгогдон тухайн хөтөлбөр хэрэгжиж байна. Эдгээр хөтөлбөрт аймгийн хэмжээнд 3-12 ангийн 6452 суралцагчид хамрагдаж байна. Мөн англи хэлний сургалтын төвүүд үйл ажиллагаа явуулж байна. "Bookbridge" сургалтын төвд 96, "Sunrise center" сургалтын төвд 42 нийт 138 суралцагч хамрагдсан. | 100 |
| 33 | 1.3.1.3.“Боловсролын салбарын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт чанарын шаардлага хангасан хүүхдэд ээлтэй | 107 | Цээл, Тайшир сумдад Сургуулийн дотуур байрны барилга шинээр барина. | 2025 | БГ | | - | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь - 30 | 2026 оны улсын төсөвт Цээл сумд 100 ортой дотуур байр 4,573.3 сая төгрөг, Дэлгэр сумд 100 ортой дотуур байр 1,020.7 сая төгрөг, Халиун сумд 100 ортой дотуур байр 304.1 сая төгрөг, Баян-Уул сумд 160 ортой дотуур байр 1,127.9 сая төгрөгөөр санхүүжигдэхээр тус тус тусгагдлаа. Тайшир сумын дотуур байрны зураг төсөв хийгдэж байна. | 70 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалтын орчинг бүрдүүлнэ. | 108 | Жаргалан, Эрдэнэ, Шарга сумдад 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилга шинээр барина. | 2025 | БГ | | - | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь - 30 | Жаргалан, Эрдэнэ, Шарга сумдад 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажлыг улсын төсөвт тусгуулахаар саналыг хүргүүлсэн. 2026 оны улсын төсөвт Тонхил сумд 320 хүүхдийн сургууль 2,280.5 сая төгрөг, Цээл сумд 320 хүүхдийн сургууль 183.1 сая төгрөг, Эрдэнэ сумд 320 хүүхдийн сургууль 1,000.0 сая төгрөг, Есөнбулаг сумд 640 хүүхдийн Хантайшир-Эрдэм цогцолбор сургууль 3,641.0 сая төгрөг тус тус тусгагдлаа. | 30 |
| | | 109 | Есөнбулаг сумын 1, 4, 10 дугаар цэцэрлэгүүдийн барилгыг засварлана. | 2025 | БГ | СОНХС-13.8 | 0 | Засвар хийгдсэн барилгын тоо -1 | Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 6.3 сая төгрөгөөр 10-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын халаалтын шугамын шинэчлэл, 2.5 сая төгрөгөөр 1-р цэцэрлэгт, 5.0 сая төгрөгөөр 4-р цэцэрлэгт урсгал засвар тус тус хийлээ. | 100 |
| | | 110 | Есөнбулаг сумын 2, 3-р цэцэрлэгийн барилгыг буулгаж шинээр барих, 11 дүгээр цэцэрлэгийн спорт заалны барилга шинээр барина. | 2025 | БГ | - | - | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь-30 | 6-р цэцэрлэгийн барилгыг 12 дугаар сард ашиглалтад хүлээж авна. 3-р цэцэрлэгийн барилгын зураг төсөв хийгдсэн. 2-р цэцэрлэгийн байршил нь цэвдэгтэй тул байршлыг өөрчлөх шаардлагатай байна. 11-р цэцэрлэгийн спорт заалны барилгыг Хан-Алтай ресурс ХХК-ийн хөрөнгө оруулалтаар барихаар төлөвлөж байна. | 100 |
| | | 111 | Сургалтын орчны үнэлгээний хувийг дээшлүүлнэ. | 2025 | БГ | | 82.2 | Сургалтын орчны үнэлгээний хувь-84 | Ерөнхий боловсролын 27 сургууль, 21 дотуур байрны гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээ хийлээ. Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын стандартад нийцсэн байдлыг үнэлэх хуудсаар 27 сургуулийн эрсдэл үүсэх магадлал 31.5 буюу дунд, дотуур байрын орчны үйлчилгээний стандартын шалгуур үзүүлэлтэд нийцсэн байдлыг үнэлэх хуудсаар 20.1 буюу бага эрсдэлтэй үнэлэгдсэн байна. 2025 оны ерөнхий боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний сургалтын орчин бүрдүүлэлт өмнөх оноос 9.7%-иар ахиж 89.7%, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний орчин 3.7%-иар ахиж 90%-тай үнэлэгдсэн байна. Боловсролын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний сургалтын орчны үнэлгээний дундаж 89.9% болж 7.7%-иар ахисан байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 34 | 1.3.1.4.Сургууль, цэцэрлэгийг шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангаж, хүүхэд хөгжих сургалтын орчинг бүрдүүлнэ. | 112 | Сургуулиудад туршлагын талбай байгуулна. | 2025 | БГ | | 0 | Туршлагын талбайтай болсон сургуулийн тоо-5 | Дэлгэр, Халиун, Тайшир, Баян-Уул, Бигэр, Гуулин, Дарив сумдын нийт 7 сургуульд туршлагын талбай байгуулан намрын ургац хураалтын үеэр сурагчдыг туршлагын талбайтай танилцуулан, туршилт, судалгааны ажил болон хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгууллаа. | 100 |
| | | 113 | Есөнбулаг сумын 3, 4, 5, 6, 8, 10 дугаар цэцэрлэг, Бигэр, Тонхил сумын цэцэрлэгт стандартын шаардлагад нийцсэн биеийн тамир, тоглоомын талбай байгуулна. | 2025 | БГ | УТ-7.6 ОНТ-15.0 ХХО-4.5 | 0 | Биеийн тамир, тоглоомын талбай байгуулсан цэцэрлэгийн тоо-2 | Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд 15.0 сая төгрөгөөр Есөнбулаг сумын 7-р цэцэрлэгт гадна тоглоомын талбай байгууллаа. Баянтоорой тосгоны цэцэрлэгийн багш, ажилчид, эцэг эх хамтран 4.5 сая төгрөгөөр гадна тоглоомын талбай тохижуулсан. Боловсролын яам, Боловсролын ерөнхий газраас Есөнбулаг сумын 7-р цэцэрлэг, Чандмань сумын цэцэрлэгүүдэд 7.6 сая төгрөгийн биеийн тамирын хэрэглэгдэхүүн нийлүүллээ. | 100 |
| | | 114 | Хими, физик, биологиийн хичээлийн кабинетуудыг тоног төхөөрөмж, урвалж бодисоор хангана. | 2025 | БГ | ОНТ-49.8 | 0 | Кабинет, тоног төхөөрөмжөөр хангагдсан сургуулийн тоо-2 | Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр, "Эко сургууль" олон улсын жишиг хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвийн 49.8 сая төгрөгөөр Цогт, Чандмань, Эрдэнэ, Баянтоорой тосгоны ерөнхий боловсролын сургуулиудийг байгалийн ухааны тоног төхөөрөмжөөр хангалаа. | 100 |
| | | 115 | Ерөнхий боловсролын сургуулиудад дижитал анги байгуулна. | 2025 | БГ | ХХО-41.5 | 1 | Байгууллагдсан ангийн тоо-1 | Гуулин тосгоны ерөнхий боловсролын сургуульд цахим кабинет байгууллаа. Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн сургалтад ашиглагдаж буй компьютер 119 ширхэгээр нэмэгдэж 1716, ухаалаг самбар 22 ширхэгээр нэмэгдэж 85, телевиз 6 ширхэгээр нэмэгдэж 363 боллоо. Сургуулийн дотоод сүлжээнд зохион байгуулалт хийснээр интернэт орчин бүрдсэн хичээлийн байр 5-аар нэмэгдэж 30 боллоо. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 116 | Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудыг хатуу зөөлөн эдлэл, тоглоом наадгайгаар хангана. | 2025 | БГ | УТ-54,8 ОНТ-10,0 ОУБ-87.7 | 14 | Хатуу, зөөлөн эдлэл, тоглоомоор хангагдсан цэцэрлэгийн тоо-4 | Боловсролын яамны хөрөнгө оруулалтаар сургуулийн өмнөх боловсролын сургалтын шинэчлэгдсэн хөтөлбөрийг туршин хэрэгжүүлж буй Бигэр сум, Есөнбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгт нийт 35.4 сая төгрөгийн СТЕАМ сургалтын хэрэглэгдэхүүн, Есөнбулаг сумын 7 дугаар цэцэрлэгт 3.3 сая төгрөгийн тоглоом тус тус нийлүүллээ. Нөхөн хангалтын зардлын 5.0 сая төгрөгөөр Есөнбулаг сумын 4 дүгээр цэцэрлэг, Тайшир, Цээл, Тонхил сумын цэцэрлэгт тоглоом, 8.0 сая төгрөгөөр Есөнбулаг сумын 1, 5, 6, 7, 10, 11 дүгээр цэцэрлэг, Цогт, Бигэр сумын цэцэрлэгт хөгжмийн зэмсэг худалдан авч, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүллээ.<br>Тайшир сумын цэцэрлэг өөрийн төсвийн 1,3 сая төгрөгөөр хувилбарт сургалтад зориулсан СТЕАМ хэрэглэгдэхүүн худалдан авч, сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна.<br>Багш хөгжлийн орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн 10.0 сая төгрөгөөр Гуулин тосгоны цэцэрлэгт ухаалаг дэлгэц нийлүүллээ. Улсын төсвийн 1.3 сая төгрөгөөр Хантайшир-Өргөө цэцэрлэгт ширээ, сандал, дэвсгэр, Есөнбулаг сумын 11 дүгээр цэцэрлэг дотоод нөөцөөр 15 ширхэг сандал, Дэлгэр сумын цэцэрлэг 5 ширхэг сандал, Бигэр сумын цэцэрлэг 75 инчийн зурагтыг хандив хэлбэрээр тус тус авч багш хөгжлийн орчинг бүрдүүллээ. Эдгээр ажлын хүрээнд нийт 34.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.<br>НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Халиун, Тайшир сумын цэцэрлэгийн хувилбарт сургалтын багш болон Есөнбулаг сумын 7, 10 дугаар цэцэрлэгийн тусгай хэрэгцээт бүлгийн багш нарыг “Таблеттэй багш” хөтөлбөрт хамруулж, таблет, цахим ном, гарын авлагын багц олголоо. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 117 | Есөнбулаг сумын 1, 5, 6, 9 дүгээр цэцэрлэг, Хантайшир-Өргөө цэцэрлэг, Хөхморьт, Халиун, Жаргалан, Чандмань сум, Баянтоорой тосгоны цэцэрлэг, Алтай, Хөхморьт, Баян-Уул, Тайшир, Төгрөг, Чандмань, Дэлгэр сум, Баянтоорой тосгоны сургуулиудыг гал тогооны тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслээр хангана. | 2025 | БГ | УТ-5,7 ОНТ-0,8 ААН-24,2 | 0 | Тоног төхөөрөмж өөр хангагдсан сургууль, цэцэрлэгийн тоо-3 | Хан-Алтай ресурс ХХК-ийн хөрөнгө оруулалтаар Есөнбулаг сумын 7-р цэцэрлэгт 17.2 сая төгрөгийн 13 нэр төрлийн 204 ширхэг гал тогооны тоног төхөөрөмж, хэрэгсэл, 9-р цэцэрлэгт 7.0 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж, хэрэгсэл, Есөнбулаг сумын орон нутгийн хөгжлийн сангаас Хантайшир-Өргөө цэцэрлэгт 800.0 мянган төгрөгийн 2-р хоолны тогоо, Боловсролын Ерөнхий газраас 1 дүгээр цэцэрлэгт 3.5 сая төгрөгийн 1-р хоолны тогоо тус тус нийлүүллээ. Дарив сумын цэцэрлэг нөхөн хангалтын зардлаар 1.2 сая төгрөгийн уур сорогч, 950.0 мянган төгрөгийн 3 дамжлагат угаалтуур худалдан авсан. Боловсролын яамнаас 43.0 сая төгрөгийн үнэ бүхий аяга, таваг угаах, ариутгах төхөөрөмжийг Есөнбулаг сумын 5 сургуульд нийлүүлсэн. Боловсролын яам, Equal ТББ-ын зүгээс Хантайшир-Эрдэм цогцолбор сургууль, Цээл, Дарив, Цогт, Дэлгэр, Хөхморьт сумдын ерөнхий боловсролын сургуулиудад нийт 133,2 сая төгрөгийн тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн. Тайлант хугацаанд 16 байгууллагад 206.7 сая төгрөгийн  гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлсэн байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 35 | 1.3.1.5 Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд "Сүү" хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлнэ. | 118 | Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд "Сүү" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2025 | БГ | | 0 | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь-10 | Эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэгээр Есөнбулаг сумын 4, Бигэр, Шарга, Халиун, Тайшир сумдын сургууль, Тахийн тал, Алтансоёмбо багийн сургуулийн бага, дунд, ахлах ангийн сурагчдад сүү, үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. 7 хоногт 2 удаа сүү, сүүн бүтээгдэхүүн өгч, сүүнээс авах эрдэс, амин дэмийг нөхөж байна. Уг хөтөлбөрт 2024-2025 оны хичээлийн жилд 1764 сурагч буюу нийт сурагчдын 10 хувь хамрагдлаа. Сүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сүүний үйлдвэрийг дэмжих хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн 50.0 сая төгрөгөөр Алатау үүлдрийн туглалтай 7 үнээ, мал хамгаалах сангийн 48.0 сая төгрөгийн зээлээр сүүний чиглэлийн 8 үнээ тус тус нийлүүллээ. Сүүний сав баглаа боодол, стандартын шаардлага хангуулах чиглэлээр “Энх таян” ХХК-д 4 нэр төрлийн 19,9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүллээ. | 100 |
| **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | |
| **2.1.Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлнэ.** | | | | | | | | | | |
| **2.1.1.Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | |
| 36 | 2.1.1.1.Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, аж ахуйн нэгж, иргэдийн сайн дурын даатгалын хамрах хүрээг өргөтгөх, малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангана. | 119 | Сайн дурын даатгалд хамрагдсан иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | 2025 | НДГ | | 3500 | Сайн дурын даатгалд хамрагдсан иргэний тоо-3550 | Сайн дурын даатгалын талаарх 58 төрлийн богино хэмжээний рийл, контент, шторк танилцуулга бэлтгэн цахим хэлбэрээр түгээж, 7 сумд хууль сурталчлах, нийгмийн даатгалын явуулын үйлчилгээг зохион байгууллаа. 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр сайн дурын даатгалд малчин 2594, хувиараа хөдөлмөр эрхлэгч 575 иргэн, 0-3 насны хүүхдээ асарч буй эх 227, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг/эх 56, нийт 3452 иргэн тус тус хамрагдлаа. | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 37 | 2.1.1.2.Татварт бүртгэлтэй үйл ажиллагаа идэвхтэй явуулж буй аж ахуйн нэгжийн нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлнэ. | 120 | Нийгмийн даатгал төлөгч аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлнэ. | 2025 | НДГ | | 750 | Хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо-760 | Татварын газартай мэдээлэл солилцон ажилласан бөгөөд тайлант хугацаанд шинээр 40 аж ахуйн нэгж байгууллагыг шимтгэл төлөгчөөр бүртгэж, нийт 768 төсөвт болон аж ахуйн нэгж байгууллага шимтгэлийн тайлан гаргаж, идэвхтэй үйл ажиллагаагаа явуулан ажиллаж байна. | 100 |
| **2.1.2.Аймгийн татварын орлогыг нэмэгдүүлэх бааз суурийг өргөтгөж, өөрөө орлогоо бүрдүүлэх нөхцөлийг бий болгоно.** | | | | | | | | | | |
| 38 | 2.1.2.1. Татварын бааз суурийг өргөтгөж, татварт хамрагдалтын хувь хэмжээг нэмэгдүүлнэ. | 121 | Татварт хамрагдалтын хувийг нэмэгдүүлнэ. | 2025 | ТХ | | 77 | 78 | 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 78% байна. | 100 |
| | | 122 | Төсвийн орлогын орон нутгийн бүрдүүлэх хувийг нэмэгдүүлнэ. | 2025 | АЗДТГ, СТСХ | | 32.8 | Төсвийн орлогын орон нутгийн бүрдүүлэх хувь-39.8 | 2025.10.31-ний өдрийн байдлаар төсвийн орлогын орон нутгийн бүрдүүлэлтийн хувь 48.1 байна. | 100 |
| **2.1.3.Эрдэс баялаг, уул уурхайн салбарт ногоон технологийг хэрэгжүүлж, ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ.** | | | | | | | | | | |
| 39 | 2.1.3.1. Ашигт малтмал олборлох, баяжуулах үйлдвэрлэлд хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй, дэвшилтэт техник, хаягдалгүй технологийг дэмжиж ажиллана. | 123 | Эрдэс, түүхий эдийн нөөцөд тулгуурлан дэвшилтэт технологи, шохойн үйлдвэр бүхий бүс нутгийг байгуулна. | 2025 | АЗДТГ, БОНХОБТХ | | 60 | Үйлдвэрийн бүтээн байгуулалтын хувь-70 | Тайшир сумын нутагт 34.6 сая тонн батлагдсан нөөцтэй, хоногт 400 тонн, жилд 120.0 мянган тонн шохой үйлдвэрлэх хүчин чадалтай Дөрвөлжингийн шохойн үйлдвэрийг 100 гаруй тэрбум төгрөгийн дотоодын хөрөнгө оруулалтаар 2025 онд барьж дуусган, ашиглалтад оруууллаа. Тус үйлдвэр үйлдвэрт 2025 оны эхний 10 сарын байдлаар 111, үүнээс орон нутгаас 52 хүнийг байнгын ажлын байраар ханган ажиллаж байна. | 100 |
| **2.1.4.Боомтын шинэ сэргэлтийн бодлогыг орон нутагт дэмжиж, хэрэгжүүлэн ажиллана.** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 43 | 2.1.4.2.Бургастайн боомтын дэд бүтцийн ажлыг эрчимжүүлнэ. | 124 | Зорчигч тээврийн нэвтрэх хүчин чадал, хилийн хөдөлгөөний экспорт, импортын бараа бүтээгдэхүүний эргэлтийг нэмэгдүүлнэ. | 2025 | АЗДТГ, ТЗУХ | | 600.0 | Экспорт, импортын бараа бүтээгдэхүүний эргэлтийн хэмжээ /мян.тн/-700 | Тайлант хугацааны экспорт, импортын бараа бүтээгдэхүүний эргэлтийн хэмжээ 675.763.23 тн /2025.11.13/ | 50 |
| | | | | | | | 33570 | Зорчигч тээврийн нэвтэрсэн зорчигчийн тоо-40000 | Хоёр орны нийт 21.172 зорчигч хилээр нэвтэрсэн. /2025.11.13/ | |
| | | | | | | | 25400 | Тээврийн тоо-30000 | Хоёр орны нийт 10810 тээврийн хэрэгсэл хилээр нэвтэрсэн. /2025.11.13/ | |
| | | 125 | Боомтуудад хийгдэх бүтээн байгуулалтын ажлыг нэмэгдүүлнэ. | 2025 | АЗДТГ, ТЗУХ | | 1 | Хийгдсэн бүтээн байгуулалтын тоо-1 | Бургастай боомтын цогцолборын 32.1 тэрбум төсөвт өртөгтэй зураг төсөв, Алтай хотоос Бургастай боомт хүртэлх хатуу хучилттай замын зураг төсөв бүрэн хийгдсэн. БНХАУ-аас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, Шинжан Уйгарын өөртөө засах орны Хами аймгийн даргыг айлчлах үеэр замын хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх талаар санал тавьсан. БНХАУ-ын талаас Бургастайн боомт, Алтай сумыг 35квт-ын агаарын шугам, дэд станцтай холбох ажил хийгдэж байна. 2025 оны 12 дугаар сарын 10-ны дотор бүрэн дуусна. | 100 |
| **2.1.5. Хатуу хучилттай авто замын хэмжээг нэмэгдүүлж авто тээврийн үйлчилгээг сайжруулна.** | | | | | | | | | | |
| 44 | 2.1.5.1.Алтай хотод 26,3 км хатуу хучилттай авто зам барьж ашиглалтад оруулна. | 126 | Алтай хотод 26,3 км хатуу хучилттай авто зам барьж ашиглалтад оруулна. | 2025 | АЗДТГ, БОНХОБТХ | | 25 | Авто замын урт /км/-12 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ентүм зочид буудлаас 3, 4 дүгээр байрны хойд талын уулзвар хүртэлх зам, Хийдийн 60 автомашины зогсоол, Жинст баг, Хөгжил хорооллын доод талаас 3, 4 дүгээр гудамжны хатуу хучилттай авто зам тавих ажлыг "Сакот импорт" ХХК гүйцэтгэж 600м, аймгийн төвийн 15,6 км хатуу хучилттай авто замын ажлыг "Бумбат даваа" ХХК гүйцэтгэж 10 км замын далангийн ажил, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Батсуурийн гудамжны тохижилт шинэчлэлтийн ажлын хүрээнд "Гранд мөнх буурал" ХХК 575м авто замын хучилтыг гэрээнд заасны дагуу тайлант онд хийж гүйцэтгэлээ. Солонго хороолold 4,3 км автозамыг ашиглалтад хүлээж авлаа. | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 45 | 2.1.5.2.“Зорчигч тээврийн авто үйлчилгээний төв”-ийн барилгыг ашиглалтад оруулна. | 127 | “Зорчигч тээврийн авто үйлчилгээний төв”-ийн барилгыг ашиглалтад оруулна. | 2025 | АЗДТГ, БОНХО БТХ | УТ-850,7 | - | Гүйцэтгэлийн хувь-30 | Зорчигч тээврийн авто үйлчилгээний төвийн барилгын ажлыг “Мөрөн-Алтай” ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд барилгын суурь төмөр бетон карказын ажил, агааржуулалтын хоолой угсрах ажил хийгдэж ажлын явц 51.0 хувьтай байна. 2025 онд батлагдсан санхүүжилтээс 850.7 сая төгрөгийн санхүүжилтийг Зам тээврийн яамнаас хянан баталгаажуулж олголоо. | 100 |
| 46 | 2.1.5.3.Алтай-Улиастай чиглэлийн 194 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ. | 128 | Алтай-Улиастай чиглэлийн 194 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ. | 2025 | АЗДТГ, БОНХО БТХ | | 0 | Авто замын урт /км/-40 | Алтай-Улиастай чиглэлийн хатуу хучилттай авто зам /Улиастай-Цагаанхайрхан чиглэлийн 40км авто зам/ тавих ажлын гүйцэтгэгчээр “China Jiangsu international and technical cooperation group” ХХК шалгарч гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. | 100 |
| **2.1.6.Дулаан, цахилгааны эрчим хүчний тогтворжилтыг ханган, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | |
| 47 | 2.1.6.1.Сэргээгдэх эрчим хүчний бие даасан эх үүсвэрийг нэмэгдүүлэн дотоодын хэрэгцээг бүрэн хангах боломжийг бүрдүүлнэ. | 129 | Сэргээгдэх эрчим хүчний бие даасан эх үүсвэрийг нэмэгдүүлэн дотоодын хэрэгцээг бүрэн хангах боломжийг бүрдүүлнэ. | 2025 | АЗДТГ, БОНХО БТХ | | 119.5 | Үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний хэмжээ /сая.кВт.цаг/-130 | Үйлдвэр технологийн парк барихаар төлөвлөсөн 20,000 га талбайд салхи, нар, цэнэг хураагуурын сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр барихаар төлөвлөн ажиллаж байна. 2025 оны 10 дугаар сарын байдлаар 132 сая.кВт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэсэн бөгөөд үүнээс 42 сая.кВт.цаг эрчим хүчийг "Тайширын УЦС", "Сэрвэн" НЦС тус тус үйлдвэрлэсэн байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 48 | 2.1.6.2.Алтай хотод баригдах 25 мВт-ын хүчин чадалтай дулааны станц, 1-р хэлхээний шугам сүлжээний ажлыг үргэлжлүүлж, 2-р хэлхээний шугам сүлжээний ажлыг эхлүүлнэ. | 130 | Алтай хотод баригдах 25 мВт-ын хүчин чадалтай дулааны станц, 1-р хэлхээний шугам сүлжээний ажлыг үргэлжлүүлж, 2-р хэлхээний шугам сүлжээний ажлыг гүйцэтгэнэ. | 2025 | АЗДТГ, БОНХО БТХ | | - | Гүйцэтгэлийн хувь-30 | 25 мВт хүчин чадалтай дулааны станц барих ажлыг БНСУ-ын Экспорт-Импорт банкны санхүүжилтээр “Бьюксан инженеринг” ХХК ажлын явц 30 хувьтай гүйцэтгэсэн, хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй барилгын ажил эхлээгүй, 2 орны Засгийн газар хооронд хэлэлцээр хийгдэж байна.<br>Дулааны станц, дулаан дамжуулах төвүүдийн цахилгаан хангамжийн ажлыг улсын төсвийн 841.5 сая төгрөгөөр “Би Эм Жи Эл” ХХК, ус хангамж, ариутгах татуурга, холбоо мэдээллийн шугам сүлжээний ажлыг улсын төсвийн 2,254.3 сая төгрөгөөр “Моденс” ХХК тус тус гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>Улсын төсвийн 24.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтцийн угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Одкон холдинг” ХХК шалгарч, ЭХЯамтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. 2025 онд Хөгжил хороолол болон УДДТ 1-н ус, дулаан хангамжийн шугамын ажлыг 20 хувьтай гүйцэтгэж байна. | 90 |
| 49 | 2.1.6.3.Алтай хотын дулааны эх үүсвэрийн дутагдлыг нөхөх ажлыг  төр хувийн хэвшлийн оролцоотой хамтран хэрэгжүүлнэ. | 131 | Алтай хотын дулааны эх үүсвэрийн дутагдлыг нөхөх ажлыг төр хувийн хэвшлийн оролцоотой хамтран хэрэгжүүлнэ. | 2025 | АЗДТГ, БОНХО БТХ | | - | Гүйцэтгэлийн хувь-30 | Хөгжил хороололд шинээр дулааны эх үүсвэр барихаар “Санни сэрвис” ХХК-аар хүчин чадлын тооцоолол хийлгүүлж, дулааны эх үүсвэрийн дутагдлыг нөхөх ажлыг төр хувийн хэвшлийн хамтын оролцоотой хэрэгжүүлж байна. Есөнбулаг сумын  Хөгжил хорооллын дулааны эх үүсвэрийг төр хувийн хэвшлийн түншлэлээр шинэчлэх ажлыг "Говийн гал голомт" ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд ажлын явц 50 хувьтай байна. | 100 |
| 50 | 2.1.6.4. Сумдыг нэгдсэн халаалтын системд бүрэн холбоно. | 132 | Алтай, Бигэр, Цээл, Дэлгэр сумын Гуулин тосгоны нэгдсэн халаалтын системд холбоно. | 2025 | АЗДТГ, БОНХО БТХ | | 14 | Халаалтад холбогдсон сумдын тоо-2 | "Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамжийн төсөл"-ийн хүрээнд  улсын төсвийн 10,192.7 сая төгрөгийн хөрөнгөөр Алтай сумын инженерийн дэд бүтцийн ажлыг "Тунгалаг говь транс" ХХК, "Билгүүн од констракшн" ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өглөө. Бигэр сумын төвийн инженерийн шугам сүлжээний холболт, уурын зуухны барилгын ажлыг улсын төсвийн 2493,8 сая төгрөгийн хөрөнгөөр “Сити агро эх” ХХК гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өглөө. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 51 | 2.1.6.5. Аж ахуйн нэгж, байгууллагуудыг тоолууржуулж, эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ. | 133 | Аж ахуйн нэгж, байгууллагууды г тоолууржуулж, эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ. | 2025 | АЗДТГ, БОНХО БТХ | | 3 | Тоолууржу улсан байгууллa гын тоо-2 | Хас банкны салбар, Шүүх, Прокурорын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн салбар, Жангар музей болон аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн архивын хэлтэс, Тайшир сумын иргэдэд үйлчлэх нэгдсэн төвд дулааны тоолуур суурилууллаа. Есөнбулаг сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төсвийн болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад дулааны тоолуур суурилуулах ажлыг зохион байгуулахаар холбогдох байгууллагуудад чиглэл хүргүүлж, бэлтгэл ханган ажиллаж байна. | 100 |
| 52 | 2.1.6.6.Төв суурин газарт шинээр олгогдсон болон цаашид олгохоор төлөвлөгдсөн гэр бүлийн хэрэгцээний зориулалттай нэгж талбарыг эрчим хүчний эх үүсвэрт холбоно. | 134 | Төв суурин газарт шинээр олгогдсон болон цаашид олгохоор төлөвлөгдсөн гэр бүлийн хэрэгцээний зориулалттай нэгж талбарыг эрчим хүчний эх үүсвэрт холбоно. | 2025 | АЗДТГ, БОНХО БТХ | ОНХС-1,300.0 | - | Гүйцэтгэл ийн хувь-30 | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 1,300.0 сая төгрөгийн хөрөнгөөр Баянхайрхан, Баяншанд, Индэрт багуудын шинэ суурьшлын бүсийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлын гүйцэтгэгчээр “Жи Би Юу И си” ХХК шалгаран Баянхайрхан багийн ажлыг эхлүүлсэн. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 53 | 2.1.6.7.Аймгийн төвийн 10/04 кВт-ын шугамыг шинэчлэх, сумдын 04 кВт-ын ЦДАШ, дэд өртөөг шинэчлэн сайжруулна. | 135 | Аймгийн төвийн 10/04 кВт-ын шугамыг шинэчлэх, сумдын 04 кВт-ын ЦДАШ, дэд өртөөг шинэчлэн сайжруулна. | 2025 | АЗДТГ, БОНХО БТХ | | - | Гүйцэтгэлийн хувь-30 | Бүс нутгийн найдвартай цахилгаан хангамж төслийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Бигэр сумын АТП-01, 02, 03 дэд станцаас гарч байгаа 0.4 кВ-ын агаарын шугамын АС утастай хэсгийг бүрээстэй дамжуулагч бүхий агаарын шугамаар шинэчлэх, Эрдэнэ сумын суурьшлын бүсийн айл өрхийн гадна цахилгаан хангамж болон АТП-1 дэд станцыг өргөтгөх, Бугат сумын АТП-1.2 дэд станцын төмөр хийцийг шинэчлэх, одоо байгаа 0.4 кВ-ын агаарын шугамын АС утастай хэсгийг бүрээстэй агаарын шугамаар солих, Тонхил сумын АТП-01, 02 дэд станцын төмөр хийцийг шинэчлэх, одоо байгаа 0.4кВ-ын агаарын шугамын АС утастай хэсгийг бүрээстэй агаарын шугамаар солих, Дарив сум шинэ суурьшлын бүсийн гэрэл цахилгаангүй айл өрхүүдийн гадна цахилгаан хангамж 250/10 кВа дэд өртөөний ажил, Дарив сум 100 кВа чадалтай дэд станцын 0.4 кВ-ын ЦДАШ хэсэгчлэн шинэчлэх ажил, Дэлгэр сумын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийг ЦЭХ-ээр хангах ажлууд хийгдэхээр худалдан авах ажиллагааг зарласан. Мөн аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 1,300.0 сая төгрөгийн хөрөнгөөр Баянхайрхан, Баяншанд, Индэрт багуудын шинэ суурьшлын бүсийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлын гүйцэтгэгчээр “Жи Би Юу И си” ХХК шалгаран Баянхайрхан багийн ажлыг эхэлсэн. | 100 |
| 54 | 2.1.6.8.Гэр хорооллын монгол гэр, жижиг сууцны дулаан алдагдлыг бууруулах ЧИП, хабрид, нарны толь зэрэг дулаан зохицуулалтын шинэлэг шийдлүүдийг үргэлжлүүлэн нэвтрүүлнэ. | 136 | Гэр хорооллын монгол гэр, жижиг сууцны дулаан алдагдлыг бууруулах ЧИП, хабрид, нарны толь зэрэг дулаан зохицуулалтын шинэлэг шийдлүүдийг үргэлжлүүлэн нэвтрүүлнэ. | 2025 | АЗДТГ, БОНХО БТХ | ХХО 30.0 сая | 50 | Хамрагдсан өрхийн тоо-50 | Дэлгэр сумын Баян-Өндөр багийн зоогийн газарт Нарны толь дулаан зохицуулалтын шинэлэг санааг туршилтаар хэрэгжүүлж байна. Алтай сумд 8 өрх чип дулаалгын багцад хамрагдахаар гэрээ байгуулах ажил хийгдэж байна. Хабрид, нарны толь зэрэг дулаан зохицуулалтын шинэлэг шийдлүүдийг нэвтрүүлэхээр судалж байна. | 30 |
| **2.1.7.Орон нутгийн онцлогийг илэрхийлсэн тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 55 | 2.1.7.1.Аялал жуулчлалын бодлогын баримт бичигт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлж, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хүрээлэн буй орчны менежмент, стандартад нийцүүлэн хөгжүүлнэ. | 137 | Байгалийн нөөцөд тулгуурлан, нутгийн иргэдэд түшиглэсэн, зорилтот аяллыг сурталчилж, бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлнэ. | 2025 | СУАЖЗГ | | 0 | Шинээр нэвтрүүлсэн бүтээгдэхүүн үйлчилгээний тоо-1 | “Үлэмжийн тансаг хөглөгөр их Алтай” зорилтот танилцах аяллыг УБ-Бигэрийн Улаан Явар-Ээж хайрхан-Баянтоорой, Хавтгай харах-Хар азаргын нуруу, Элгэн хад-Сутай хайрхан-Дөргөн нуур-Нисдэг эрэг-Их Монгол элс, Эрээн нуур, Завхан гол-Хасагт Хайрхан, Хүнхэр-Тайшир, Гэгээн нуур, Харандаа хад гэсэн маршрутаар зохион байгууллаа. | 100 |
| | | 138 | Орон нутгийг зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлнэ. | 2025 | СУАЖЗГ | | 1165 | Жуулчдын тоо-1500 | Орон нутгийг зорин ирэх жуулчдын тоо жил ирэх тусам нэмэгдэж, энэ онд давхардсан тоогоор дотоодын 27681, гадаадын 891 жуулчид ирсэн байна. | 100 |
| | | 139 | Аялал жуулчлалын чиглэлээр үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжүүдтэй хамтын ажиллагааг бэхжүүлж, боловсон хүчний чадамж, үйлчилгээний чанар стандартад хяналт тавин, дэмжиж ажиллана. | 2025 | СУАЖЗГ | | - | Стандартын хэрэгжилтийн хувиар -50 | Хүнс, хөдөө аж ахуйн газар, Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар, Стандарт, хэмжилзүйн хэлтэстэй хамтран Есөнбулаг сумын төвд үйлчилгээ явуулж буй 8 зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа, үйлчилгээний ерөнхий шаардлагад тохирлын үнэлгээ, магадлан хийж, чанарын түвшинг тодорхойлон, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, дүгнэлт гарган цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, мэдээ судалгаа гарган мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч зочлох үйлчилгээний сургалт зохион байгуулахаар боллоо. Хяналт шалгалтаар байгууллагуудын үйлчилгээний чанар стандартын хэрэгжилт 70 хувьтай байлаа. | 100 |
| 56 | 2.1.7.2. Хилийн бүс, хил орчмын аялал жуулчлал хөгжүүлнэ. | 140 | Аялал жуулчлалын мэдээллийн нэгдсэн төв байгуулж, иргэд, аялагч, жуулчид, аж ахуйн нэгжүүдийг | 2025 | СУАЖЗГ | | 800 | Хил орчмын жуулчдын тоо-840 | Монгол төдийгүй дэлхийд ховордсон нэн ховор, ховор амьтдыг түшиглэсэн тусгай сонирхлын чиглэлээр Олон улсын тахь групптэй хамтран "Говийн их дархан цаазат газрын Б" хэсэгт 5 удаагийн аялал зохион байгууллаа. Говийн их дархан цаазат газрын "А", "Б", хэсэгт зорилтот аялал жуулчлалаар нийт 1500 орчим жуулчин ирсэн үзүүлэлттэй байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нэгдсэн мэдээллээр хангана. | | | | | | | |
| **2.2. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэ ханшийг нэмэгдүүлж малчид тариаланчдын орлогыг өсгөнө.** | | | | | | | | | | |
| **2.2.1.Малын эзэн-үйлдвэрийн эзэн хөтөлбөрийг хэрэгжүүлж, эхэлнэ.** | | | | | | | | | | |
| 57 | 2.2.1.1.Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг байгуулах, хувьцаа эзэмших, хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлж, “Малын эзэн-Үйлдвэрийн эзэн” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 141 | "Цагаан алт" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлж, малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулна. | 2025 | ХХААГ | | - | Үйлдвэрийн ажлын гүйцэтгэлийн хувь-10 | Цагаан алт үндэсний хөдөлгөөний хүрээнд тус аймагт улсын төсвийн санхүүжилт хуваарилагдаж ирээгүй боловч малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрийг дэмжих зорилгоор ЖДҮХСангаас арьс шир боловсруулах чиглэлээр Есөнбулаг сумд “Базгайн хөх эрчис” ХХК-д 100.0 сая төгрөгийн зээлийг олгосон бөгөөд тус аж ахуйн нэгж нь үйлдвэрийн байрыг барьж ашиглалтад оруулсан. Тус үйлдвэр нь жилд 5000 ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоодын болон БНХАУ-ын зах зээлд нийлүүлж байна. Мөн Турк улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн ТИКА төслөөс “Артис алтай” хоршоонд 58.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. Дэмжлэгийн үр дүнд тус хоршоо нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ 20 хувиар нэмэгдүүлсэн. | 100 |
| | | 142 | “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг үргэлжлүүлж, “Чинээлэг малчин” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | 2025 | ХХААГ | - | 407 | Зээлд хамрагдсан хоршооны тоо-20 | "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд нийт 2025 онд 143 хоршоонд 4,394,380 төгрөгийн зээл олгосон байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 58 | 2.2.1.2.Төр хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох “Алтайн малчдын түншлэл” төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 143 | Төр хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох “Алтайн малчдын түншлэл” төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2025 | ХХААГ | | - | Хэрэгжилт ийн хувь-30 | Орон нутагт малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулах, хөдөөгийн хүн амын амьжиргааг сайжруулж, хүнсний аюулгүй байдлыг ханган тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлж, иргэдийн орлогыг бодитойгоор дээшлүүлэх зорилгоор “Малын эзэн-үйлдвэрийн эзэн” төслийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусган, ТЭЗҮ-г улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгөөр гүйцэтгүүлэхээр төрийн худалдан авах ажиллагааны газарт тендер зарлагдсан боловч маргааны улмаас хойшлогдсон тул хэрэгжүүлэх боломжгүй байна. | 30 |
| 59 | 2.2.1.3.Мах, сүүний болон бусад чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийг хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжинэ. | 144 | Махны чиглэлийн хонины загвар аж ахуйг байгуулна | 2025 | ХХААГ | ОНХС-40.0 | 0 | Загвар аж ахуйн тоо-1 | Махны чиглэлийн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр Керей үүлдрийн хонины цөм сүрэг бүхий өсвөр хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулан Эдельбай үүлдрийн хээлтүүлэгчийг сайжруулагчаар ашиглаж байна. Дээрх цөм сүргийн хонийг 1 малчинд гэрээгээр эзэмшүүлээд байна. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн 40.0 сая төгрөгийн санхүүжилтээр Баяд үүлдрийн 40 толгой хээлтүүлэгчийг худалдан авч сайжруулагчаар ашиглаж байна. | 100 |
| 60 | 2.2.1.4.Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг зохион байгуулна. | 145 | Газрын доорх уст цэгийн хайгуул хийнэ. | 2025 | ХХААГ | УТ-45.0 ОНТ 198.0 | 90 | Хайгуул хийх уст цэгийн тоо -35 | Улсын төсвийн 45.0 сая төгрөгийн санхүүжилтээр Баян-Уул, Бугат, Дарив, Тонхил, Хөхморьт, Шарга сумдад нийт 33 цэг байршилд газрын доорх уст цэгийн хайгуул хийх ажлыг “Ус-Амьдрал” ХХК-аар гүйцэтгүүллээ. Орон нутгийн төсвийн 198.0 сая төгрөгийн санхүүжилтээр 18 сумд нийт 72 цэг байршилд уст цэг тогтоох ажлыг “Гранд холдинг” ХХК-аар гүйцэтгүүллээ. | 100 |
| | | 146 | Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ. | 2025 | ХХААГ | УТ-72.0 СОНХС-303.0 ХХО-40.0 | 26 | Шинээр гаргасан инженерийн хийцтэй гүн өрмийн худгийн тоо-5 | Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд улсын төсвийн 67.9 сая төгрөгийн санхүүжилтээр Шарга, Есөнбулаг сумд инженерийн хийцтэй 2 худаг шинээр гаргах ажлыг "Гранд холдинг" ХХК-аар гүйцэтгүүллээ. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 303.0 сая төгрөгийн санхүүжилтээр Баян-Уул, Тонхил, Эрдэнэ сумдад тус бүр 3, Чандмань, Есөнбулаг сумдад тус бүр 1, нийт 11 инженерийн хийцтэй худгийг шинээр гаргаж хүлээн авлаа. Хан-Алтай ресурс ХХК-ийн 40,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Наран багийн Үхэр чулуутад бэлчээрийн зориулалттай инженерийн хийцтэй худгийг гаргаж малчдад хариуцуулан өглөө. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 147 | Бэлчээрийн хөнөөлт хортон шавьж, мэрэгчидтэй тэмцэх ажлыг зохион байгуулна. | 2025 | ХХААГ | - | 15 | Тодотгох судалгаа хийгдсэн байна. | Бэлчээрийн хөнөөлт царцааны тодотгох судалгааг Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран Жаргалан, Дэлгэр сумдад хийж гүйцэтгэлээ. Судалгаагаар нийт нутгийн 70 хувьд царцаа тархсан нь тогтоогдсон. | 100 |
| 61 | 2.2.1.5.“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд стратегийн хүнсний хангамж нөөцийн тогтвортой байдлыг бэхжүүлнэ. | 148 | Стратегийн хүнсний хангамж, нөөцийг бүрдүүлнэ. | 2025 | ХХААГ | | 0 | Гол нэрийн бүтээгдэхүүний бүрдүүлэх хувь-2 | Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэхээр “Буудайн хөх уулс” ХХК-тай гэрээ байгуулсан. Гол нэрийн 10 төрлийн хүнсний бүтээгдэхүүнээс дотоодын үйлдвэрлэлээр махыг 100 хувь, сүүн бүтээгдэхүүний 48 хувь, гурилын 9 хувь, гурилан бүтээгдэхүүний 59 хувь, төмсний 11.4 хувь, хүнсний ногооны 17.5 хувь, жимс, жимсгэний 14 хувийг хангаж байна. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөцийн судалгааг foodsupply.mofa.gov.mn программаар хянадаг бөгөөд 11 сарын байдлаар мах 40.2 тн, гурил 171.6 тн, гурилан бүтээгдэхүүн 17.1 тн, төрөл бүрийн будаа 86.9 тн, ургамлын тос 11.3 тн, хуурай сүү 8.3 тн, өндөг 1.6 тн, төмс 59.3 тн, хүнсний ногоо 55.2 тн, элсэн чихэр 58.5 тн, давс 12.1 тн, цэвэр ус 35.1 тн-ийн нөөцтэй байна. | 100 |
| 62 | 2.2.1.6.Жижиг дунд үйлдвэрлэл, ахуй үйлчилгээ эрхлэгчдийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 149 | Жижиг, дунд үйлдвэрлэл, ахуй үйлчилгээ эрхлэгчдийн ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 2025 | ХХААГ | Арилжааны банк-500.0, ХХС-446.0 | 20 | Нэмэгдсэн ажлын байрны тоо-10 | “Атрын IV” тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд 2 аж ахуй нэгжид зоорийн үйл ажиллагаа эрхлэх, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 500.0 сая төгрөгийн, 9 хоршоонд 326.0 сая төгрөгийн, ахуйн үйлчилгээний чиглэлээр 1 хоршоонд 140.0 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон байна. Дээрх ажлын үр дүнд 12 ажлын байр шинээр бий болсон байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 150 | Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлчилгээг үндэсний томоохон бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөр, төрийн худалдан авалтаар дэмжих, орон нутгийн уул уурхайн байгууллагад нийлүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | 2025 | ХХААГ | | 1 | Арга хэмжээний тоо-1 | Жижиг, дунд бизнес эрхлэгчид, ханган нийлүүлэгчдэд тулгамдсан асуудал, гарц шийдлийг тодорхойлж, хамтын ажиллагааны боломж, бизнес эрхлэлтийн талаарх ур чадвар олгох зорилгоор “BIZAltai” өдөрлөг, "Жижиг дунд бизнес ба тогтвортой хөгжил" хэлэлцүүлгийг Хан-Алтай ресурс ХХК-ийн дэмжлэгээр Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамтран зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд 200 гаруй жижиг, дунд бизнес эрхлэгчид оролцон ханган нийлүүлэгчдэд тулгардаг асуудлууд, худалдан авалт, хамтын ажиллагааны боломжуудын талаар хэлэлцэж, ханган нийлүүлэгчдийн мэдээллийн санг бүрдүүллээ. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй “Зайвар-Алтай”, “Соёмбо эмбройдери”, “Хасагт хүрэн хайрхан”, “Морьт баян” ХХК-ууд “Хан Алтай ресурс”, “Цэн газар” “Мандал Алтай” зэрэг уул, уурхайн компаниудад мах, төмс, хүнсний ногоо, ажлын хувцас зэрэг бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг байгуулан ажиллаж байна. | 100 |
| | | 151 | Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх, зах зээлийг өргөтгөх зорилгоор үзэсгэлэн худалдаа, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулна. | 2025 | ХХААГ | | 2 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо-2 | Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн борлуулалтын орлогыг дэмжих зорилгоор “Цагаан сар-2025” үзэсгэлэн худалдааг 2 дугаар сард зохион байгуулж 70 гаруй хүнсний болон хөнгөн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж оролцож 80.0 сая төгрөгийн борлуулалт хийлээ. "Алтайн алтан намар", “Хантайшир экспо-2025” үзэсгэлэн худалдааг 9 дүгээр сард зохион байгуулж 18 сум, Завхан аймгийн нийт 150 гаруй үйлдвэрлэл эрхлэгчид оролцож 95.5 сая төгрөгийн борлуулалт хийлээ. Мөн УБ хотод зохион байгуулагдсан "Амар байна уу", “Нүүдэлчин”, "Олон улсын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа", “Намрын ногоон өдрүүд-2025” үзэсгэлэн худалдаанд давхардсан тоогоор 24 иргэн, аж ахуй нэгжийг оролцууллаа. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 63 | 2.2.1.7.Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн, хоршооны загвар төслүүдийг бэлтгэж, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэн, сургалт зохион байгуулна. | 152 | Хоршоод, хоршооны гишүүд, салбарын мэргэжилтэн, төрийн бус байгууллагын төлөөллийг чадавхжуулах сургалт, арга хэмжээг зохион байгуулна. | 2025 | ХХААГ | - | 500 | Сургалтад хамрагдагсдын тоо-510 | "Төсөл боловсруулах", "Компаний засаглал", "Гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих", "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн төсөл хүлээн авах, бүрдүүлэх бичиг баримтын талаар зөвлөгөө мэдээлэл өгөх", "Зээлийн батлан даалтын сангийн танилцуулга", “Малын гаралтай ширхэгтийн стандартыг танилцуулах, хоршооны хөгжлийг дэмжих, чадавхжуулах”, “Арьс ширэн түүхий эдийг стандартын дагуу бэлтгэх” чиглэлээр нийт 7 удаагийн чадавхжуулах сургалтад хоршооны гишүүд, салбарын мэргэжилтэн, төрийн бус байгууллагын төлөөлөл 530 хүнийг хамрууллаа. | 100 |
| | | 153 | Чадавхжсан загвар хоршоодын тоог нэмэгдүүлнэ. | 2025 | ХХААГ | - | 360 | Зээл олгосон хоршооны тоо-10 | Хоршоо хөгжүүлэх сангаас ахуйн үйлчилгээ, зоорь, мал аж ахуй, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр нийт 5 сумын 10 хоршоонд 466.0 сая төгрөгийн зээл олгогдсон байна. | 100 |
| 64 | 2.2.1.8.Мал, амьтны гоц халдварт өвчингүй эрүүл бүс нутгийг хадгалж, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 154 | Мал амьтны халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулна. | 2025 | МЭГ | УТ-124.7, ОНТ-496.3 | 2.2 сая | Хамрагдсан малын тоо-2.0 сая-аас доошгүй | Тайлант онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 92140 мал, амьтныг галзуугийн, 141897 малыг боомын, 310738 малыг дотрын халдварт хордлого-энтеробактериозын, 88291 малыг цусан халдварын, 4499 малыг дуут хавдрын, 19950 малыг сохор доголын, 179800 малыг шөвөг ярын вакцинд хамрууллаа. Биокомбинат ТӨХКК-тай байгуулсан гэрээний дагуу 210.3 сая төгрөгий вакцины үнэ, мал эмнэлгийн үйлчилгээний хөлс 286.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүллээ. Аймгийн хэмжээнд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 837317 малыг, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 1352000 мал, нийт-2189315 мал, амьтан хамрууллаа. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 155 | Халдварт болон гоц халдварт өвчний эрт илрүүлгийн үзлэг тандалт, шинжилгээг тогтмол зохион байгуулж, өвчлөлийг бууруулна. | 2025 | МЭГ | УТ-10.0, СОНХС-7.9 | 1420 | Өвчилсөн малын тоо-1320 | Сумдын мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нар мал эмнэлгийн нэгдсэн системийн эрт илрүүлэг, хариу арга хэмжээний модулыг ашиглан гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хонь ямааны цэцэг, үхрийн арьс товруутах өвчнийг эрт илрүүлэх, өвчний тархалтын хүрээг тогтоох зорилгоор 18 сумын, 4037 малчин өрхийн 418 адуу, 49 тэмээ, 2501 үхэр, 7995 хонь, 8872 ямаа нийт-19835 малд үзлэг хийж, эрсдэлийн үнэлгээ хийн баталгаажууллаа. Дарив сумын Ихэс баг, Бигэр сумын Их булаг, Буудай баг, Баян-Уул сумын Алтангадас баг, Халиун сумын Олонбулаг баг, Дэлгэр сумын Баян-Өндөр багуудад галзуу өвчний 9 тохиолдол, Жаргалан сумын Бүрэн багт боом өвчний 1 тохиолдол, Дарив сумын Хужирт баг, Бигэр сумын Мянгай багт дотрын халдварт хордлого өвчний 2 тохиолдол, Баян-Уул сумын Алтангадас баг, Бугат сумын Биж багт колибактериоз өвчний 2 тохиолдол бүртгэгдэж, нийт-26 мал өвчилж, хариу арга хэмжээ авч ажиллалаа. | 100 |
| | | 156 | Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр сумдын шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | 2025 | МЭГ | СОНХС - 252.6 | 4 | Тоног төхөөрөмжөөр хангагдсан сумын тоо-4 | Халиун сум ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар "Цас хан хөхий" ХХК-тай гэрээ хийн 60.0 сая төгрөгөөр, Цогт сум ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар "ОТТО-МИР" ХХК-тай гэрээ хийн 58.8 төгрөгөөр, Хөхморьт сум ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар "Арби Элваторс" ХХК-тай гэрээ хийн 55.8 төгрөгөөр,Тайшир сум ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар "АЗХҮҮ" ХХК-тай гэрээ хийн 78.0 сая төгрөгөөр тус тус мал угаалгын Дук машиныг хүлээн авсан | 100 |
| 65 | 2.2.1.9.Орон нутагт үржүүлэгдэж байгаа үүлдэр омгийн мал сүргийн генетик нөөцийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | 157 | Бугат сумд үржүүлэгддэг “Хөвчийн улаан“ нутгийн шилмэл ямааны биологийн онцлог ашиг шимийн судалгаанд тулгуурлан үржлийн дунд хугацааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ. | 2025 | ХХААГ | | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-30 | Бугат сумд үржүүлэгдэж байгаа “Хөвчийн улаан ямааны аж ахуй, биологийн онцлог, ашиг шимийн үндсэн үзүүлэлтийг тогтоох” ажлыг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран зохион байгуулж байна. Монгол Улсын Төрийн Соёрхолт зөвлөх малзүйч Б.Мандахтай хамтран ажиллах зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан, Хөвчийн улаан ямааны тодорхойлолтыг хянан засварлах, сайжруулах, үржлийн ажлын дунд хугацааны төлөвлөгөө боловсрууллаа. Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Их эрдмийн зөвлөлийн хурал, ямааны аж ахуйн биологи ашиг шимийн хурал, Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөлийн хурлуудаар тус тус хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна. | 50 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 158 | Тэмээ өсгөх хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана. | 2025 | ХХААГ | | - | Хэрэгжилтийн хувь-30 | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 09 дүгээр тогтоолоор “Тэмээ өсгөж ашиг шимийг нэмэгдүүлэх” хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 3 бүлэг 25 заалттайгаар боловсруулан аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталж, хэрэгжилт 2026 оноос эхэлнэ. | 100 |
| 66 | 2.2.1.10.Малчдын шинэ залуу халааг бэлтгэх, малчдын нийгмийн асуудалд анхаарах, малжуулах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 159 | Малжуулах ажлыг зохион байгуулна. | 2025 | ХХААГ | | 110 | Малжуулсан өрхийн тоо-140 | Мал хамгаалах эргэлтийн сангаас 5 өрхийг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 34 өрхийг 256.0 сая төгрөг буюу 3695 (хонин толгойд шилжүүлснээр) толгой малаар малжуулсан байна. Залуу малчин 40 өрхийн холбогдох баримт материалыг нэгтгэн хүлээн авч, малжуулах ажлыг энэ онд багтаан хийхээр төлөвлөж байна. Сумдад 55 өрхийг 2512 толгой малаар малжуулсан байна. | 90 |
| **2.2.2.“Газар тариалан жимс, жимсгэнэ” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | | |
| 67 | 2.2.2.1.Хүнсний хувьсгал аяны хүрээнд хүнсний ногооны орон нутгийн хэрэгцээг хангаж, дөрвөн улирлын хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ. | 160 | "Газар тариалан, жимс жимсгэнэ" төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллана. | 2025 | ХХААГ | | 1328.6 | Тариалсан талбайн хэмжээ /га/-1350 | Энэ онд 1954.3 га талбайд тариалалт хийж, 3615.75 тн ургац хураан авлаа. | 100 |
| | | 161 | Жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлнэ. | 2025 | ХХААГ | | 130 | Тариалалт хийсэн талбайн хэмжээ /га/-140 | “Монголын унаган байгаль хүлцэл тогтворжилтыг хангах нь” төслийн хамтарсан 100.0 сая төгрөгийн санхүүжилтээр шинээр 16 га талбайд Жимс жимсгэний аж ахуй байгуулахаар бэлтгэл ханган ажиллаж байна.<br>Хаврын тарилтаар 130.3 га талбайд жимс, жимсгэний тариалалт хийж, 151 тн ургац хураан авлаа. Намрын тарилтаар Бигэр, Халиун сумдын мод үржүүлгийн газарт 4 нэр төрлийн 23200 ширхэг жимсний суулгацыг 10.3 га талбайд тариалж, нийт жимс жимсгэний тариалалтыг 140.6 га талбайд хүргэлээ. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 162 | Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, нарийн ногооны тариалалтыг нэмэгдүүлнэ. | 2025 | ХХААГ | ОНХС-98.2, СОНХС-100.0 | 1340 0 | Шинээр тариалалт хийгдсэн талбайн хэмжээ, мкв-120 | Есөнбулаг сумын Естийн аманд орон нутгийн хөгжлийн сангийн 100.0 сая төгрөгийн санхүүүжилтээр 300 мкв зуны хүлэмж 2 ширхэг, уртасгасан хугацаатай 300 мкв бүхий давхар хүлэмж 1 ширхэг, нийт 900 мкв 3 ширхэг хүлэмж барьж ашиглалтад оруулж, 4 төрлийн нарийн ногоо тариалж 1 тн ургац хураан авлаа. Есөнбулаг сумын төвд сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр тус бүр 300 мкв бүхий 4 ширхэг зуны хүлэмж барьж ашиглалтад оруулж, 5 төрлийн нарийн ногоо тариалж 1.5 тн ургац хураан авлаа. Тайлант онд нийт 2100 мкв хүлэмжийн талбайд шинээр тариалалт хийлээ. | 100 |
| 68 | 2.2.2.2.Усалгаатай газар тариалангийн талбайг нэмэгдүүлэх, услалтын системийг шинээр байгуулан сэргээн засварлах ажлуудыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 163 | Зураг төсөл хийгдсэн шинээр болон шинэчлэх, сэргээн засварлах услалтын системийн хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэн, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлнэ. | 2025 | ХХААГ | ХХО-200.0 | 1335 | Усалгаатай газар тариланги йн талбайн хэмжээ /га/-1345 | “Атрын IV” тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд Дэлгэр сумын Гуулин тосгонд шинээр 50 га талбайд ногоон тэжээл тариалж, усалгаатай талбайн хэмжээг 1385 га-д хүргэлээ. | 100 |
| **2.3. Байгалийн нөөцийг зүй зохистой ашиглан, нөхөн сэргээж, хүрээлэн буй орчны доройтлыг бууруулна.** | | | | | | | | | | |
| **2.3.1.Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах, тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулна.** | | | | | | | | | | |
| 69 | 2.3.1.1. "Говийн гайхамшигт 6" ба нэн ховор, ховор, элбэг амьтдыг хамгаалах, амьдрах орчныг сайжруулах төлөвлөгөө боловсруулан, сэлгэн нутагшуулах, нөөцөд тулгуурласан зохистой агнуур | 164 | "Говийн гайхамшигт 6" амьтны амьдрах орчныг сайжруулах төлөвлөгөө боловсруулан, бүсийн хэмжээнд хэрэгжүүлж ажиллана. | 2025 | БОГ | | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-40 | Говийн гайхамшигт 6 амьтныг хамгаалах, амьдрах орчныг сайжруулах, олон нийтэд сурталчлах зорилгоор 2024-2029 онд хэрэгжүүлэх 6 зорилт, 27 арга хэмжээг дунд хугацааны төлөвлөгөө боловсруулан, Дорноговь, Өмнөговь, Баянхонгор, Увс, Ховд, Завхан аймгуудын байгаль орчны салбарын байгууллагууд, олон улсын төсөл хөтөлбөр, судалгаа шинжилгээ, ТББ-тай хамтран хэрэгжүүлж байна. 11 сарын 27-28-ны өдрүүдэд Алтай хотод хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулахаар төлөвлөж байна. Урьдчилсан байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 45.0 хувьтай байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулалт хийнэ. | 165 | Устаж үгүй болсон байршил нутгуудад тарвага сэргээн нутагшуулна. | 2025 | БОГ | ХХО-25.0 | 363 | Нутагшуул сан тарваганы тоо-50-аас доошгүй | Баян-Уул сумын Алтангадас багт 50, Есөнбулаг сумын Рашаант багт 50, нийт 100 толгой тарвагыг сэргээн болон сэлгэн нутагшуулах ажлыг "Хан-Алтай ресурс" ХХК-ийн дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд мэргэжлийн байгууллага болох "Аварлын эрилд" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүллээ. Энэ ажлын хүрээнд автомат камерын тандалтыг сард 2 удаа 7 хоногоор байршуулж, ажиглалт судалгаа хийхэд 18 толгой мөндөл нэмэгдэж, өсөлт сайн байна. | 100 |
| | | 166 | Агнуур зохион байгуулалтын менежментийг сайжруулж, байгалийн нөөцийн орлогын хэмжээг нэмэгдүүлнэ. | 2025 | БОГ | | 320.0 | ОНТ-т төвлөрүүл эх орлогын хэмжээ | Агнуур зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, судалгааг батлуулан ажилласнаар агнуурын 7 бүс нутгийг шинээр нэмж нийт 10 сумд 13 агнуурын бүстэй боллоо. Агнуурын бүс нутгуудад аймгийн хэмжээнд 2 толгой угалз, 20 толгой тэх агнуулж, орон нутгийн төсөвт 322,9 сая төгрөг төвлөрүүллээ. | 100 |
| 70 | 2.3.1.2.Экосистемийн чухал ач холбогдол бүхий газар нутгуудыг тусгай хамгаалалтад авах, өргөтгөх, хамгааллын загвар менежментийг хэрэгжүүлнэ. | 167 | Улсын тусгай хамгаалалттай "Сутай хайрхан" уулын байгалийн нөөц газрын менежментийн төлөвлөгөөг бүсийн хэмжээнд боловсруулан хэрэгжүүлж, төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын түншлэлийн зарчмаар хамгаална. | 2025 | БОГ | | - | Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-20 | "Сутай хайрхан" уулын байгалийн нөөц газрын менежментийн урт хугацааны төлөвлөгөөг TNC олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна. Дарив, Тонхил сумдын төрийн байгууллагууд, байгаль хамгаалах нөхөрлөлүүд, байгаль орчны салбарын байгууллагууд, олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран ажилласны үр дүнд төлөвлөгөөний хэрэгжилт 30 хувьтай байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 168 | Улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөнө. | 2025 | БОГ | | 58.9 | Тусгай хамгаалалттай газар нутгийн өсөлтийн хувь-59 | Аймгийн нийт газар нутгийн 8,186,884.73 га буюу 58.9 хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад аваад байна. Улсын тусгай хамгаалалтад шинээр болон өргөтгөж ангилал ахиулахаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурлын тогтоолоор 1,121,419,88 га талбайг улсын тусгай хамгаалалтад авснаар аймгийн нийт газар нутгийн 66,8 хувийг тусгай хамгаалалттай газар нутаг эзэлнэ. | 90 |
| **2.3.2.Гадаргын болон газар доорх усыг хуримтлуулан хамгаалах, худаг, уст цэгүүдийг шинээр гаргах замаар хүн ам, хөдөө аж ахуй, зэрлэг ан амьтдад хүртээмжтэй, зүй зохистой ашиглах боломжийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | |
| 71 | 2.3.2.1.Газрын доорх усны эрэл хайгуул судалгааны ажлыг хийж хүн амын усан хангамж хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулна. | 169 | Усны нөөцийн эрэл, хайгуул, зураглалын ажлыг хийж нөөц тогтоолгоно. | 2025 | БОГ | УТ-600.0 | 4 | Хайгуул хийгдсэн тоо-1 | Төгрөг сумын төвийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл хайгуулын судалгааны ажлыг “Таширын хүрээ” ХХК-аар гэрээ байгуулан гүйцэтгүүллээ. Тус ажлын хүрээнд 90-120 м гүнтэй газрын доорх усны хяналт шинжилгээний 4, ашиглалтын 2, нийт 6 цооног өрөмдөж нийлбэр дундаж 3 л/сек ундрагатай усны нөөц тогтоогдсон байна. | 100 |
| | | 170 | Төв суурин болон хөдөөгийн малчдын ундны усны хүртээмж, чанар аюулгүй байдалд судалгаа хийж, эх үүсвэрийг сайжруулна. | 2025 | БОГ | | 0 | Сайжруулсан усны эх үүсвэрийн тоо-1 | "Сэкер ресорсус Монголиа" ХХК-ийн санхүүжилтээр Чандмань сумын 10 уст цэгт ундны усны чанар хүртээмжийн судалгаа хийсэн. "Марко поло" ХХК, "Номин Эрдэнийн Өргөө" ХХК-ууд нийгмийн хариуцлагын хүрээнд Есөнбулаг, Бигэр сумдад унд ахуйн зориулалттай 4 худаг гаргаж малчдын ундны усны чанар хүртээмжийг сайжруулсан. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Харзат, Жаргалант багуудын 3 ундны усны худгийн нөөцийн савыг сольж, Түмэн, Баянхайрхан, Индэрт, Харзат багуудын 5 ундны усны худгийн гадна засвар үйлчилгээг хийж гүйцэтгэлээ. Баянхайрхан, Баяншанд, Харзат багт сумын орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар инженерийн шугам сүлжээнээс алслагдсан суурьшлын бүсүүдэд стандартын шаардлага хангасан "Ус түгээх байр"-ны тоог нэмэгдүүллээ. | 100 |
| **2.3.3.Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 72 | 2.3.3.1. Газрын доройтол цөлжилтөөс сэргийлж гадаргын усыг хуримтлуулах зураг төсвийг боловсруулан, хөв цөөрөм байгуулах, булаг шандны эхийг хашиж хамгаалах, элсний нүүлт гадны нөлөөлөлд өртөж буй нууруудад судалгаа хийж хамгаалах нөхөн сэргээх дэглэмийг мөрдүүлэх ажлыг зохион байгуулна. | 171 | Аймгийн хэмжээнд хөв цөөрөм байгуулах боломжтой газруудад мэргэжлийн байгууллагаар зураг төсөв хийлгүүлнэ. | 2025 | БОГ | | 5 | Зураг төсвийн тоо-4 | Есөнбулаг, Бигэр, Дэлгэр сумын 4 байршилд хөв цөөрөм байгуулах ус зүй, ус хуримтлагдах талбайг тооцоолж, зураг, төсөв боловсруулах ажлыг “Хан-Алтай ресурс” ХХК-ийн нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд “Гидродизайн инноваци” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. | 100 |
| | | 172 | Дэлгэр, Бигэр, Есөнбулаг, Төгрөг, Тонхил, Халиун, Шарга, Баян-Уул, Дарив, Хөхморьт сумдад хур тунадас, цас, мөсний усыг хуримтлуулах, гол, булаг шандны урсацын тохируулга хийх замаар хөв цөөрөм, усан сан байгуулна. | 2025 | БОГ | | 8 | Хөвийн тоо-4 | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас санаачилсан Нэг сум-Нэг нуур /333 нуур/ хөтөлбөрийн хүрээнд энэ онд улсын төсвийн хөрөнгөөр Хөхморьт, Тайшир, Бигэр, Чандмань, Эрдэнэ, Цогт, Цээл, Алтай, Бугат, Тонхил, Төгрөг, Шарга, Дарив, Баян-Уул, Халиун зэрэг сумдад шинээр 15 хөв цөөрөм байгуулах, хуучин хөв сэргээх, доройтолд орсон нуур сэргээх ажлыг хийхээр төлөвлөсөн. Тус ажлын сонгон шалгаруулалт зарлагдсан боловч гүйцэтгэгч аж ахуйн нэгж шалгараагүй байна. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 50.0 сая төгрөгөөр Төгрөг сумын Хүрэн гол багийн Үертийн амны адагт хур тунадас, цас, мөсний усыг хуримтлуулах 480м3 багтаамжтай хөв, улсын төсвийн хөрөнгөөр ГИДЦГ-ын А хэсгийн хамгаалалттай газар нутагт 400м3 багтаамжтай Чонын довон нэртэй хөв, Сэкер Ресорсус Монголиа ХХК өөрийн хөрөнгөөр Чандмань сумд Шорогийн булгийн хөлд 2м3 багтаамжтэй хөвийг тус тус байгууллаа. Хөхморьт сумын Хөлийн-Ус хөв байгуулах ажлыг “Оргил өнөр” ХХК тай гэрээ байгуулан ажлыг эхлүүллээ. | 90 |
| | | 173 | Аймгийн хэмжээнд гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор булаг шандны эхийг хашиж хамгаална. | 2025 | БОГ | БАНСАХ 3-75.0 | 20 | Хамгаалсан булгийн тоо-11 | Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар “Ханан сэрэх харуул хайрхан” ХХК-тай гэрээ байгуулан Жаргалан, Есөнбулаг, Бигэр, Цогт сумдад тус бүр 1, Дэлхийн байгаль хамгаалах сангийн зардлаар Халиун, Баян-Уул, Шарга, Тонхил сумдад тус бүр 3, Хөхморьт сумд 2, нийт 18 булгийн эхийг хашиж хамгаалж байгаагаас 13 булгийн эхийг хаших ажил бүрэн хийгдэж дуусан, 5 булгийг хаших ажил 85-с дээш хувьтай явагдаж байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 174 | Элсний нүүлт гадны нөлөөлөлд өртөж буй Хөхморьт сумын Сангийн далай, Гүн нуур, Жаргалан сумын Эрээн нуур, Ажиг нууруудад судалгааны ажил хийлгэж, хамгаалах нөхөн сэргээх ажлыг зохион байгуулна. | 2025 | БОГ | УТ-814.0 | 0 | Хамгаалж, нөхөн сэргээсэн нуурын тоо-2 | Жаргалан сумын Эрээн нуурыг сэргээх ажлыг улсын төсвийн 814.0 сая төгрөгөөр "Усны эрчим" ХХК гүйцэтгэлээ. Уг ажлын үр дүнд Эрээн нуур, Ажиг нуур бүрэн сэргэсэн байна. | 100 |
| 73 | 2.3.3.2. Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэн, элсний нүүлтийг тогтоон барих механик хамгаалалт, ойн зурвасыг байгуулна. | 175 | Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулах 2025-2030 он хүртэлх 5 жилийн төлөвлөгөөг бүсийн хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллах | 2025 | БОГ | | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-30 | Аймгийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох 5 жилийн төлөвлөгөөний төслийг холбогдох байгууллагуудаас санал авч боловсруулан 2025 оны 12 дугаар сард аймгийн ИТХ-аар хэлэлцүүлнэ. | 30 |
| | | 176 | Хөхморьт, Баян-Уул, Жаргалан, Шарга, Бигэр сумдад элсний нүүлтийг тогтоон барих механик хамгаалалтыг хийж хэрэгжүүлнэ. | 2025 | БОГ | ХХО-406.0 | 28 | Элсний механик хамгаалалт хийсэн талбайн хэмжээ /га/-10 | Элсний нүүлт эрчимтэй явагдаж буй Хөхморьт сумын хойд талд 45 га, Гүн нуурын баруун хойд хэсэгт 20 га, Сангийн далай нуурын баруун хойд талд 45 га, нийт 110 га талбайд элсний нүүлтийг тогтоон барих механик хамгаалалтын ажлыг хийхээр төлөвлөн сонгон шалгаруулалтыг зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй байна. | 30 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 74 | 2.3.3.3. 108 сая мод тарьж ургуулах арга хэмжээний хүрээнд ойжуулалт, ойн зурвас байгуулах, мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бий болгоно. | 177 | Төв суурин болон улс,орон нутгийн чанартай зам дагуу ойн зурвас байгуулна. | 2025 | БОГ | | 24 | Ойн зурвас байгуулсан талбайн хэмжээ /га/-10 | Улсын чанартай зам дагуу Естийн гүүрний баруун талд 5 га талбайг хашиж хамгаалан, "Аймгийн тээвэрчид"-ийн нэрэмжит төгөл болгон 3000 ширхэг мод тарьж, Авто тээврийн газар усалгаа арчилгааг гэрээ байгуулан хариуцан ажиллаж байна. Чандмань сумын төвийн араар "Секер ресурс" ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд 5 га талбайг шинээр хашиж хамгаалан, 2500 ширхэг модыг тарьж ургуулан арчилгааг хариуцан ажиллаж байна. | 100 |
| | | 178 | 108 сая мод тарьж ургуулах ажлыг 20 хувьд хүргэнэ. | 2025 | БОГ | ОНХС 30,0 Төсөл хөтөлбөр 50,0 | 4000 | Тарьсан загийн тоо-3.0 сая | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 30,0 сая төгрөгөөр "Нутгийн төгөл" ХХК 3000 ширхэг заг, 1000 ширхэг хармаг тарих, 2000 м услалтын систем угсрах ажлыг Цогт сумын Ээж уулын отоглох цэгийг түшиглэн хийж дуусгасан. Эрдэнэ сумд Ensure төслийн 50.0 сая төгрөгийн санхүүжилтээр "Баян Зармангийн бүрд" ТББ 2 га талбайг хашиж хамгаалан 5000 ширхэг заг тарилаа. Нийт 9000 ширхэг заг тарьж, амьдралтын хувь 85-аас дээш байна. | 50 |
| | | | | | | | 139198 | Навчит модны тоо-162000 | Хавар, намрын мод тарилтаар Есөнбулаг сумд 73700, бусад сумдад 131682, нийт 8 төрлийн 205382 ширхэг мод, бут тарих ажлыг зохион байгууллаа. Модны амьдралтын хувь 75-аас дээш байна. | |
| | | 179 | Завхан гол дагуу голын татмын ойжуулалтын ажлыг хийнэ. | 2025 | БОГ | | 10 | Ойжуулсан талбай /га/-10 | Тайшир сумын төвд "Цэн газар" ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд 5 га талбайг шинээр хашиж хамгаалан, 4000 ширхэг модыг тарьж ургуулж, арчилгааг хариуцан ажиллаж байна. | 50 |
| | | 180 | Заг, тоорой болон байгалийн унаган ургамлын сөргөн ургалтыг дэмжиж, хашаа хамгаалалт хийн, шилжүүлэн суулгана. | 2025 | БОГ | Төсөл хөтөлбөр-700.0 | 23 | Сэргэн ургалт хийсэн талбай /га/-5 | Япон-Хятад найрамдлын төв "Ойска Монгол" ТББ-ын санхүүжилтээр Цогт сумын Нүцгэний талд 10 га талбайг хашиж хамгаалан, усалгааны тоног төхөөрөмжийг цогцоор нь шийдвэрлэлээ. Тус талбайд 9000 заг, 900 тоорой модны суулгацыг тарьж ургуулах ажлыг "Заг агро" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүллээ. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 181 | Газрын доройтлыг бууруулах элсний нүүлтийг багасгах зорилгоор сумдад хамгаалалтын ойн зурвас байгуулна. | 2025 | БОГ | УТ-540.0 ХХО-10.0 | 43 | Ойн зурвас байгуулсан талбайн хэмжээ /га/-60 | Бигэр сумд агро ойн аж ахуй байгуулах ажлын хүрээнд 50 га талбайг хашиж хамгаалан, 33700 ширхэг мод тарих, гүн өрмийн худаг гаргах, дуслын услалтын систем угсрах ажлыг "Бага Монгол импекс" ХХК-аар гүйцэтгүүлж, орон нутагт нь хүлээлгэн өглөө. Хөхморьт сумын "Сулин дэнж" хоршоо газрын доройтлыг бууруулах, ургамлан бүрхэвчийг нэмэгдүүлэх зорилгоор 15 га талбайг хашиж хамгааллаа. Газрын доройтлыг бууруулах элсний нүүлтийг багасгах зорилгоор нийт 65 га талбайд ойн зурвас байгуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажил хийгдлээ. | 100 |
| 75 | 2.3.3.4. Уул уурхай, дэд бүтцийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд хяналтыг сайжруулан усны сан бүхий газарт давхцалтай талбайд хасалт хийлгэх, эвдрэлд орсон талбайг нөхөн сэргээлгэх замаар хуулийн хэрэгжилтийг хангуулна. | 182 | Уул уурхай, дэд бүтцийн үйл ажиллагаан дахь хяналтыг сайжруулж, нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэнэ. | 2025 | БОГ | | 30 | Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ /га/-7 | 2025 онд аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа ашиглалтын 6, геологийн эрэл хайгуулын 26, метан хийн хайгуулын 1, нийт 33 аж ахуй нэгжийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд 17 удаагийн хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулж холбогдох арга хэмжээг авч ажилласан. Мөн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 6 аж ахуй нэгжээр нийт 4.2 га талбайд нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэн хүлээн авсан. | 70 |
| | | 183 | Хууль бус ашигт малтмал олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон талбайд нөхөн сэргээлт хийлгэнэ. | 2025 | БОГ | | 27 | Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ /га/-10 | Ашигт малтмал хууль бусаар олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон талбайд “Хан-Алтай Ресурс” ХХК, “Цэнгазар” ХХК, “Сэкер ресорсус монголиа” ХХК-ууд дүйцүүлэн хамгаалал болон нийгмийн хариуцлагын хүрээнд 26.15 га, орон нутгийн төсвөөр 2.5 га, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хүрээнд 4.46 га, нийт 33.11 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэн хүлээн авсан. | 100 |
| | | 184 | Усны сан бүхий газарт давхцаж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбайд хасалт хийн, давхцалыг арилгана. | 2025 | БОГ | | 39 | Давхцалтай талбайн тоо-19 | Аймгийн хэмжээнд усны сан бүхий газарт давхцалтай 34 аж ахуйн нэгжийн 39 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл байна. Үүнээс 2025 онд "Нон феррос майнинг монголиа" ХХК-ийн 3 талбайн давхцалыг хасууллаа. "Ланд орь" ХХК-2, "Минтек минералс" ХХК-1, "Хүннү Говь-Алтай" ХХК-6, "Хүннү Алтай минералс" ХХК-3, "Рагнорак интестмент монголиа" ХХК-1, "БХДБ" ХХК-1 нийт 14 талбайн давхцалыг хасуулах хүсэлтийг ашигт малтмал газрын тосны газарт хүргүүллээ. | 70 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 77 | 2.3.3.6. Хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллыг нүхэн жорлонгүй болгох ажлыг үе шаттайгаар эхлүүлнэ. | 185 | Хөрсний бохирдлыг бууруулах замаар аж ахуйн нэгж, албан байгууллага, гэр хороололд стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлнэ. | 2025 | БОГ | | 104 | Сайжруулсан болон эко жорлонгийн тоо-300 | Аймгийн төвийн 68, хөдөөгийн сумдын 155, нийт 223 айл өрх, албан байгууллага, аж ахуй нэгжүүд өөрийн хөрөнгөөр стандартын шаардлага хангасан эко жорлонтой болсон. | 100 |
| 78 | 2.3.3.7.Сумдын төвлөрсөн хогийн цэгийг стандартын шаардлагад нийцүүлэх, хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах орчинг бүрдүүлнэ. | 186 | Сумдын төвлөрсөн хог хаягдлын цэгийн хэмжээг багасгаж, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн тохижуулна. | 2025 | БОГ | | 9 | Хогийн цэгийн тоо-2 | 2025 онд Тайшир, Хөхморьт, Цээл, Цогт сумд хогийн цэгээ хумьж, талбайн хэмжээг багасган, хайс хамгаалалт, загон татаж эрүүл ахуйн шаардлагад нийцүүллээ. | 100 |
| **2.4. Төвлөрсөн дулаан цэвэр бохир ус ариутгал татуурга бүхий нэгдсэн дэд бүтцэд холбогдсон сумын тоог нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | |
| **2.4.1.“Сумдын шинэчлэл-Хөдөөгийн хөгжил” хөтөлбөр, төсөл, арга хэмжээг үргэлжлүүлнэ.** | | | | | | | | | | |
| 79 | 2.4.1.1.Есөнбулаг сумын дахин төлөвлөлтийн дэд бүтцийг өргөжүүлэн, стандартад нийцсэн орчны тохижилтыг бүрэн шийдсэн нийтийн болон амины орон сууцны хорооллыг барих хөрөнгө оруулалтын | 187 | Амины орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээний хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, угсралтын ажлыг хийж гүйцэтгэнэ. | 2025 | ГХБХБГ | | 0 | Шугам сүлжээний угсралтын хувь-30 | Орон нутгийн хөгжлийн сангийн 50.0 сая төгрөгийн хөрөнгөөр Солонго хороололд баригдах амины болон таун хаусны болон гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийг “Нью товер” ХХК боловсруулж хүлээлгэн өгсөн. Солонго холоололд "Шижир өргөө" ХХК, "Мөрөн-Алтай" ХХК, "Жи Ти Кэй Эс" Босго толгой" ХХК-ийн хувийн хөрөнгө оруулалтаар гадна инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | таатай орчныг бүрдүүлнэ. | 188 | Орчин үеийн загварлаг амины орон сууцны хотхон бий болгоно. | 2025 | ГХБХБГ | | 0 | Ашиглалтад орсон амины орон сууц /айлаар/-5 | Орон нутгийн хөгжлийн сангийн 50.0 сая төгрөгийн хөрөнгөөр Солонго хороололд баригдах амины болон таун хаусны болон гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийг “Нью товер” ХХК боловсруулж хүлээлгэн өгч, барилгын хөрөнгө оруулалтыг эх үүсвэрийг судлан шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. | 30 |
| | | 189 | Нийтийн зориулалттай орон сууцны тоог нэмэгдүүлж, иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулна. | 2025 | ГХБХБГ | | 325 | Ашиглалтад орсон сууцны тоо /айлаар/-190 | Бигэр сумын 45 айл, UB-аппартментын 72 айл, иргэн Д.Төгсбаярын 20 айл, иргэн Ч.Нямцэрэнгийн 14 айл, иргэн Д.Пунсалмаагийн 30 айл, иргэн М.Бүрэнзаяагийн 20 айл, нийт 201 айлын орон сууц баригдаж, ашиглалтад орлоо. | 100 |
| 80 | 2.4.1.2 Хот, суурин газрын шинэ суурьшлын бүсийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй, сумдыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болгоно. | 190 | Жаргалан, Дарив, Цогт, Халиун, Хөхморьт, Чандмань, Эрдэнэ сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, батлуулна. | 2025 | ГХБХБГ | | 11 | Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болсон сумын тоо-2 | Жаргалан сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 35.0 сая төгрөгөөр “Ланд овнер” ХХК гүйцэтгэж байна.<br>Чандмань сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 198.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байна. | 50 |
| | | 191 | Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх 4 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулна. | 2025 | ГХБХБГ | | 0 | Сумын тоо-11 | Есөнбулаг, Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Дэлгэр, Тайшир, Тонхил, Төгрөг, Цээл, Шарга сумууд Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн дагуу арга хэмжээг төлөвлөн Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, ИТХ-р хэлэлцүүлэн батлуулж, иргэн, аж ахуй нэгж байгууллагад олгох газрын хэмжээ байршлыг Засгийн газрын 2025 оны 120, 06, 74 дүгээр "Улсын хэмжээнд 2025 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай" тогтоолоор тус тус батлуулаад байна. | 100 |
| | | 192 | Алтай хотын “Солонго” хорооллын 1788 айлын орон сууцны хорооллын хэсэгчилсэн | 2025 | ГХБХБГ | ОНХС-115.0 | - | Хэрэгжилтийн хувь-70 | Алтай хотын “Солонго” хорооллын 1788 айлын орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөөнд тодотгол хийх ажлыг "Циркул проект" ХХК орон нутгийн хөгжлийн сангийн 115,0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулагдаж ажлын явц 70 хувьтай байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөвлөгөөнд тодотгол хийнэ. | | | | | | | |
| | | 193 | Сумдад инженерийн шугам сүлжээнд холбогдсон орон сууцны барилгын тоог нэмэгдүүлнэ. | | ГХБХБГ | | 45 | Сумдад баригдсан орон сууцны тоо /айлаар/-45 | Бигэр сумын 120 айлын орон сууцны эхний ээлжийн 45 айлын орон сууцны барилгын угсралтын ажлыг хувийн хөрөнгөөр "Макс Өргөө" ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өглөө. | 90 |
| | | | | | | ОНХС-2,227.9 | 8 | Цэвэрлэх байгууламжтай болсон сумын тоо-4 | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 552.0 сая төгрөгийн хөрөнгөөр Эрдэнэ сумын цэвэрлэх байгууламжийн ажлыг “Шатат” ХХК, 582.1 сая төгрөгийн хөрөнгөөр Бугат сумын цэвэрлэх байгууламжийн ажлыг “Жи гоулд" ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн. АОНХС-ийн 552.4 сая төгрөгийн хөрөнгөөр Шарга сумын цэвэрлэх байгууламж, 541.4 сая төгрөгийн хөрөнгөөр Баян-Уул сумын цэвэрлэх байгууламжийн ажлыг “Жи гоулд” ХХК гүйцэтгэж байна. Баян-Уул, Шарга сумдын цэвэрлэх байгууламжийн ажлыг 2025 оны 12 дугаар сард ашиглалтад оруулахаар ажиллаж байна. | |
| | | | | | | ОНТ-6.9 ОНХС-50.0 | 2 | Цахилгаан эх үүсвэрт холбогдсон цэвэрлэх байгууламжийн тоо-3 | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 582.1 сая төгрөгийн хөрөнгөөр Бугат сумын цэвэрлэх байгууламжийн ажлыг “Жи гоулд" ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн бөгөөд тус ажлын магадлашгүй ажлын зардал болох 6.9 сая төгрөгөөр цэвэрлэх байгууламжийн цахилгааны эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэж, цахилгаан хангамжид холбосон. Халиун сумын цэвэрлэх байгууламжийн гадна цахилгааны ажлыг "Жаргалант рашаан" ХХК гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. | |
| | | 194 | Инженерийн төвлөрсөн системд холбогдсон сумдын тоог нэмэгдүүлнэ. | 2025 | АЗДТГ, БОНХОБТХ | | 17 | Дулаан хангамжид холбогдсон сум, суурингийн тоо-1 | "Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамжийн төсөл"-ийн хүрээнд улсын төсвийн 10,192.7 сая төгрөгийн хөрөнгөөр Алтай сумын инженерийн дэд бүтцийн ажлыг "Тунгалаг говь транс" ХХК, "Билгүүн од констракшн" ХХК гүйцэтгэж, 12 сард комисс ажиллана.<br>Бигэр сумын төвийн инженерийн шугам сүлжээний холболт, уурын зуухны барилгын ажлыг улсын төсвийн 2493,8 сая төгрөгийн хөрөнгөөр “Сити агро эх” ХХК гүйцэтгэж, 2025 оны 3 сард ашиглалтад хүлээлгэн өглөө. | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2025 | | | 3 | Ус хангамжид холбогдсон сум, суурингийн тоо-1 | "Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамжийн төсөл"-ийн хүрээнд улсын төсвийн 10,192.7 сая төгрөгийн хөрөнгөөр Алтай сумын инженерийн дэд бүтцийн ажлыг "Тунгалаг говь транс" ХХК, "Билгүүн од констракшн" ХХК гүйцэтгэж, 12 сард комисс ажиллана.<br>Бигэр сумын төвийн инженерийн шугам сүлжээний холболт, уурын зуухны барилгын ажлыг улсын төсвийн 2493,8 сая төгрөгийн хөрөнгөөр “Сити агро эх” ХХК гүйцэтгэж, 2025 оны 3 сард ашиглалтад хүлээлгэн өглөө. | |
| | | | | | | | 5 | Ариутгах татуургын төв шугам сүлжээнд холбогдсон сумын тоо-2 | "Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамжийн төсөл"-ийн хүрээнд улсын төсвийн 10,192.7 сая төгрөгийн хөрөнгөөр Алтай сумын инженерийн дэд бүтцийн ажлыг "Тунгалаг говь транс" ХХК, "Билгүүн од констракшн" ХХК, Жаргалан сумын ариутгах татуургын шугам сүлжээний ажлыг "Дулаан проект" ХХК гүйцэтгэж 12 дугаар сард ашиглалтад оруулахаар хүлээгдэж байнан. | |
| 81 | 2:4.1.3.Хот суурин газрын иргэдийг байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор үерийн далан барьж байгуулна. | 195 | Алтай хотыг үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор уулын сувгийн голдирлыг өөрчилж, хамгаалалтын далан барина. | 2025 | ГХБХБГ | ОНТ-14,9 | 5.30 | Үерийн далангийн урт /км/-3 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Эм Ти Эс гидро инженеринг” ХХК “ нь Есөнбулаг сумын төвийн үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ажил”-ын зураг төслийг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Гамшгийн сангийн зардлаар 10,8 км үерийн түр даланг байгуулж, үерийн эрсдлээс сэргийлэх арга хэмжээ авлаа. 2026 оны улсын төсөвт үерийн хамгаалалтын байгууламжийн 5.0 тэрбум төгрөгийг тусгууллаа. | 100 |
| | | 196 | Сумдад үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх хамгаалалтын далангийн зураг төсөл боловсруулж хэрэгжүүлнэ. | 2025 | ГХБХБГ | | - | Зураг төсөл боловсруулсан сумын тоо-1 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Эм Ти Эс гидро инженеринг” ХХК нь Есөнбулаг сумын төвийн үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ажил”-ын зураг төслийг хийж гүйцэтгэн хүлээлгэн өглөө. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 40,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Алтай сумд 2,8 км үерийн далан барьж гүйцэтгэсэн. | 100 |
| | | | | | | | 1 | Үерийн далан байгуулсан сумын тоо-1 | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 82 | 2.4.1.4 Нийтийн зам талбайг тохижуулж, цэцэрлэгт хүрээлэн байгуулан, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсрон өнгөрүүлэх боломжийг бүрдүүлнэ. | 197 | Алтай хотын Ардчиллын, Барилгачдын, Батсуурийн, Хантайширын, Хасагт Хайрханы, Хөгжил хорооллын, Лодойдамбын гудамжуудын тохижилт шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ. | 2025 | ГХБХБГ | ОНХС-368,4 | 1 | Тохижуулсан гудамжны тоо-1 | Есөнбулаг сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Батсуурийн гудамжны тохижилтын ажлыг “Гранд мөнх буурал” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд суурийн ажил болон хашлага, явган замын ажил хийгдэж, ажлын явц 90 хувьтай байна. | 90 |
| | | 198 | Соёл амралтын “Мазаалай” цэцэрлэгт хүрээлэнг иж бүрэн тохижуулж, ашиглалтад оруулан, хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх орчинг бүрдүүлнэ. | 2025 | ГХБХБГ | | - | Гүйцэтгэлийн хувь-30 | "Хан Алтай ресорсус" ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд соёл амралтын "Мазаалай" цэцэрлэгт хүрээлэнгийн зураг төсвийг "Нью товер" ХХК-аар гүйцэтгүүлж, магадлалаар баталгаажсан. 2026 оны улсын төсөвт 2,000.0 сая төгрөг тусгууллаа. | 100 |
| 83 | 2.4.1.5. Нийтийн зориулалттай орон сууцны ашиглалтын үйл ажиллагаа сайжруулах зорилгоор сууц өмчлөгчдийн холбоог байгуулж, "Алтай орон сууцны корпораци" ААТҮГ-ыг контор болгон өргөжүүлнэ. | 199 | Орон сууц ашиглалтын контортой болж, сууц өмчлөгчдийн холбоодыг байгуулна. | 2025 | АЗДТГ, БОНХОБТХ | | 0 | Байгуулагдсан СӨХ-ны тоо-4 | Аймгийн төвд "Юу Би апартмент" хорооллын 72 айл, "Роялал таун" 30 айл, Иргэн Ч.Нямцэрэнгийн 15 айл, Иргэн Д.Пунсалмаагийн 30 айл, Иргэн М.Бүрэнзаяагийн 20 айлын орон сууцны барилга шинээр ашиглалтад орсон бөгөөд барилга тус бүрт сууц өмчлөгчдийн холбоо байгуулагдаж, бүртгэл баталгаажуулах үйл ажиллагаа явагдаж байна. | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 84 | 2.4.1.6 Есөнбулаг сумын гэр хорооллыг иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөж,(төвлөрсөн, хэсэгчилсэн, бие даасан) эко суурин хөгжүүлнэ. | 200 | Алтай хотын “Солонго” хорооллын инженерийн салбар шугам сүлжээний зураг төсөв боловсруулж, барилга угсралтын ажлыг эхлүүлнэ. | 2025 | ГХБХБГ | | - | Ажлын гүйцэтгэлийн хувь-30 | Есөнбулаг сумын Баянхайрхан баг, Солонго хороололд хувийн хөрөнгө оруулалтаар 397 айлын 8 барилга, шугам сүлжээний хамт баригдаж, ашиглалтад орсон. Мөн 548 айлын 10 орон сууцны барилга баригдаж байгаа бөгөөд тус барилгуудын гадна инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн. | 100 |
| | | 201 | Инженерийн шугам сүлжээнд холбогдсон гэр хорооллын орон сууцны тоог нэмэгдүүлнэ. | 2025 | ГХБХБГ | - | 2 | Дахин төлөвлөлтөд орсон багийн тоо-2 | Гэр хорооллыг дахин төлөвлөлт хийх замаар инженерийн нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлын хүрээнд улсын төсвийн 7,286.6 сая төгрөгийн хөрөнгөөр Индэрт, Харзат багт дулаан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ хийгдэж дууссан. | 100 |
| 85 | 2.4.1.7 Есөнбулаг сумын цэвэрлэх байгууламжийг өргөтгөж, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг хэсэгчлэн шинэчилнэ. | 202 | Аймгийн төв цэвэрлэх байгууламжийг 3000 м3/хоног болгон өргөтгөж шинэчилнэ. | 2025 | ГХБХБГ | | | Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь-10 | Алтай хотын 3000 м3 цэвэрлэх байгууламжийн угсралтын ажлыг улсын төсвийн 17,732.385.644 төгрөгийн хөрөнгөөр “Сайн констракшн” ХХК, “Сан” ХХК-ийн түншлэл гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн ГАА-БАЭҮЗ-09/25 дугаартай барилгын ажлыг эхлүүлсэн. Захиргаа аж ахуйн барилга, харуулын байр, дэд өртөөний барилга, цэвэрлэх байгууламжийн хашаа, гадна дулаан, цахилгааны шугамын ажил хийгдэж байна. Ажлын явц 20 хувьтай. | 100 |
| | | 203 | Аймгийн төвийн цэвэр усны болон ариутгах татуургын шугам сүлжээг хэсэгчлэн үе шаттайгаар шинэчлэн солих ажлыг | 2025 | ГХБХБГ, Ундарга-Алтай ААТҮГ | СОНХС-50.0 | 1.5 | Цэвэр усны шинэчилсэн шугам сүлжээний зураг төсөв хийгдсэн байна. | Есөнбулаг сумын 50.0 сая төгрөгийн хөрөнгөөр аймгийн төвийн цэвэр усны шугамыг хэсэгчлэн солих ажлын зураг төслийг “Нью товер” ХХК гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зохион байгуулна. | | | ОНХС-20.0 | 0.58 | Ариутгах татуургын шинэчилсэн шугам сүлжээний зураг төсөв хийгдсэн байна. | Аймгийн төвийн ариутгах татуургын шугам сүлжээг хэсэгчлэн шинэчлэх ажлын зураг төсвийг “Алтан босгот өргөө” ХХК боловсруулж, 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 0596/2025 дугаар магадлалын дүгнэлтээр баталгаажуулж, хүлээлгэн өгсөн. | |
| 86 | 2.4.1.8 Сумын ард иргэдийн найдвартай эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангана. | 204 | Баян-Уул, Төгрөг, Хилийн цэргийн анги, боомтуудад усны эх үүсвэрийн хайгуулын судалгаа хийж, ундны усны уст цэгийн тоог нэмэгдүүлнэ. | 2025 | АЗДТГ, БОНХОБТХ | | 2 | Уст цэгийн тоо-1 | Төгрөг сумын төвийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл-хайгуулын судалгааны ажлыг “Тайширын хүрээ” ХХК-аар гэрээ байгуулан гүйцэтгүүлж, инженерийн хийцтэй худаг гарган иж бүрэн тоноглож хүлээлгэн өгсөн. 2 худгийн нийлбэр дундаж 5 л/сек ундрагатай гэж тогтоогдсон. | 100 |
| 87 | 2.4.1.9. Аймаг, сумдын авто зам, авто зогсоол, дугуйн зам, явган замын ажлыг шинэчлэх, сэргээн засварлах, арчлах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 205 | Аймаг сумдын авто зам, авто зогсоол, дугуйн зам, явган замын ажлыг шинэчлэх, сэргээн засварлах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2025 | ГХБХБГ | | 20 | Ашиглалтад орсон авто зам, авто зогсоол дугуйн зам, явган замын урт /км/-5 | Ентүм зочид буудлаас 3,4 дүгээр байрны хойд талын уулзвар хүртэлх авто зам, хийдийн 60 автомашины зогсоол, Жинст баг Хөгжил хорооллын доод талаас 3,4 дүгээр гудамжинд хатуу хучилттай авто зам 1км, явган хүний зам 2км, Батсуурийн гудамжинд 800м авто зам болон 2.2 км явган зам, 6 автомашины зогсоол, Алтай сумд 800м авто зам, 400м явган зам, Бигэр сумд 330м авто замын ажлууд тус тус хийгдсэн. Замын нийт урт 7.53км | 100 |
| **2.4.2.Барилгын материалын лабораторийг үйл ажиллагааг өргөтгөж, итгэмжлэлийн үнэлгээнд хамруулан, сорил шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 88 | 2.4.2.1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд, батлагдсан нөөцөд тулгуурлан барилгын материалын түүхий эдийн олборлолтын үйл ажиллагааг эхлүүлнэ. | 206 | Барилгын материалын түүхий эдийн олборлолтын үйл ажиллагааг эхлүүлнэ. | 2025 | АЗДТГ, БОНХО БТХ | | 11 | Барилгын материалын түүхий эдийн олборлолтын тоо-1 | Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг даргын 2025 оны 145 дугаар захирамжаар олгож, хайгуулын ажлын төлөвлөгөөг батлан, хайрга дайрга олборлох ажиллагааг эхлүүлсэн. | 100 |
| 89 | 2.4.2.2.Барилга байгууламжийг паспортжуулж, барилга байгууламж, инженерийн дэд мэдээллийг цахимжуулна. | 207 | Барилга байгууламж, дэд бүтцийн мэдээллийн цахим сантай болгоно. | 2025 | ГХБХБГ | | 1 | Барилга байгууламжийн дэд бүтцийн мэдээллийн цахим сантай болсон сумын тоо-4 | Аймгийн хэмжээнд 18 сум, 2 тосгоны хот байгуулалтын кадастрын Urban.gov.mn цахим системд 15,483 барилга байгууламж, дэд бүтцийн мэдээлэл бүртгэгдсэн байна. | 100 |
| | | 208 | Ашиглагдаж буй барилга байгууламжийг паспортжуулж, ашиглалтын гэрчилгээ олгоно. | 2025 | ГХБХБГ | | 0 | Паспортжуулалт хийгдсэн барилгын тоо-50 | Шинээр ашиглалтад орсон 48 барилга байгууламжид "Өмч, ашиглалтын гэрчилгээ" олгосон байна. “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-ын хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 118 дугаар тушаалаар “Барилга байгууламжийн ашиглалт (ногоон, улаан, шар)-ын гэрчилгээний загвар”-ыг баталсан. | 90 |
| **2.4.3.Газрын харилцааны үйл ажиллагааг цахим системээр дамжуулан төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэнэ.** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 90 | 2.4.3.1.Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан иргэн төвтэй төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна. | 209 | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө (2024-2040) урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллана. | 2025 | ГХБХБГ | | 0 | Тухайн оны хэрэгжилтийн хувь-100 | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд туссан 2025 онд хэрэгжүүлэх 6 бүлгийн 32 арга хэмжээний хэрэгжилт хүлээгдэж буй гүйцэтгэлээр 90 хувьтай байна. | 90 |
| | | 210 | Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, дунд хугацааны бодлогын баримт бичиг батлуулж, хэрэгжүүлнэ. | 2025 | ГХБХБГ | ОНТ-567.0 | 6 | Төлөвлөгөө батлуулсан сумын тоо-12 | Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Жаргалан, Есөнбулаг, Тайшир, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цээл, Шарга зэрэг 15 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг “Вектор мэп” ХХК нь орон нутгийн төсвийн 567,0 сая төгрөгөөр гүйцэтгэлээ. Дээрх сумдын төлөвлөгөөг сумын ИТХ-аар батлууллаа. | 100 |
| | | 211 | Иргэдэд газрын харилцааны үйлчилгээг цахимаар авах боломжийг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2025 | ГХБХБГ | | 1 | Суурилуулсан киоск машины тоо-1 | Цахим Алтай” хөтөлбөр болон Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамтай хамтран хэрэгжүүлж буй ажлын хүрээнд Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газарт 24/7 төрийн цахим үйлчилгээний “Хурдан цэг” байгуулан 20,0 сая төгрөгөөр тохижууллаа. “Хурдан цэг”-ийн төхөөрөмжөөс газрын харилцааны үйлчилгээ болон төрийн 60 байгууллагын 600 гаруй үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй, түргэн шуурхай цахим хэлбэрээр авах боломж бүрдсэн. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3125 | Үйлчлүүлсэн иргэдийн тоо-3000-аас доошгүй | Газрын кадастрын мэдээллийн системээс 2025 оны 11 сарын байдлаар 1235 цахим хүсэлтийг хүлээн авлаа. Үүнд: шинээр газар эзэмших 528, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах 215, газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх 135, газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаалах 223, зориулалт, талбайн хэмжээ, байршил өөрчлөх 14, газар эзэмших эрх хүчингүй болгох 1, улсын бүртгэлийн дугаар авах 22, нэгж талбар нэгтгэх хуваах 9, эрхийн төрөл өөрчлөх 1, нэгж талбар нөхөн бүртгэх 68, эзэмшил газраа өмчлөх 14, хамтран эзэмшил нэмэх, хасах 4, газар эзэмшилт, ашиглалт оноосон нэр өөрчлөх 1 өргөдлүүдийг хүлээн авч 91,6 хувьтай шийдвэрлэсэн байна. Үүнтэй уялдуулан www.egazar.gov.mn, Egazar апилкейшин, киоск машинаар дамжуулан 1400 гаруй иргэний гэрээ, гэрчилгээ, кадастрын зургийг хэвлэн өгч ажиллалаа. 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэн, аж ахуй нэгж байгууллагаас газрын удирдлагын цахим систем болон цаасаар санал авч, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 521 нэгж талбар газрыг эзэмшүүлж, өмчлүүлж, ашиглуулахаар газар зохион байгуулалтын төлөвлөгөөний системд зураглан оруулсан. | |
| | | 212 | Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх ажлыг зохион байгуулна. | 2025 | ГХБХБГ | ОНТ-188.1 | 82 | Чөлөөлсөн нэгж талбар, газрын тоо-97 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 15.6 км хатуу хучилттай авто замын трасс дагуух 76 нэгж талбараас 63 нэгж талбарыг бүрэн чөлөөлж, 4 нэгж талбарт газар чөлөөлөх гэрээ байгуулсан. Баянхайрхан, Индэрт багийн нутаг дэвсгэрт Үерийн далан, хамгаалалтын бүсэд зөвшөөрөлгүй хашаа хатгасан, эзэмшил газрын хэмжээг нэмэгдүүлэн ашигласан 11 нэгж талбар, зөвшөөрөлгүй дур мэдэн хашаа хатгасан 3 иргэн, гэр хорооллыг дахин төлөвлөлт хийх замаар инженерийн нэгдсэн шугам сүлжээнд холбох Харзат багийн шугам сүлжээний ажлын хүрээнд 2 нэгж талбар, Бигэр сум 1 нэгж талбар, нийт 84 нэгж талбар газарт газар чөлөөлөлтийн ажил хийгдсэн. | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 213 | Иргэдэд газар эзэмших, өмчлөх, ашиглуулах эрхийг ил тод, нээлттэй олгоно. | 2025 | ГХБХБГ | | 2177 0 | Нэгж талбарын тоо-500 | Газрын кадастрын мэдээллийн системээс 2025 оны 11 сарын 07-ны өдрийн байдлаар 1235 цахим хүсэлтийг хүлээн авлаа. Үүнд: шинээр газар эзэмших 528, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах 215, газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх 135, газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаалах 223, зориулалт, талбайн хэмжээ, байршил өөрчлөх 14, газар эзэмших эрх хүчингүй болгох 1, улсын бүртгэлийн дугаар авах 22, нэгж талбар нэгтгэх хуваах 9, эрхийн төрөл өөрчлөх 1, нэгж талбар нөхөн бүртгэх 68, эзэмшил газраа өмчлөх 14, хамтран эзэмшил нэмэх, хасах 4, газар эзэмшилт, ашиглалт оноосон нэр өөрчлөх 1 өргөдлүүдийг хүлээн авч 91,6 хувьтай шийдвэрлэсэн байна. | 100 |
| 91 | 2.4.3.2.Зайнаас тандан судлалын технологид суурилсан газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг хөгжүүлж, нэвтрүүлнэ. | 214 | Сум, суурин газрын төлөв байдалд чанарын хянан баталгаа, бэлчээрийн газрын фотомониторинг хийж, сумдын газрын даамлуудын тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчилнэ. | 2025 | ГХБХБГ | | 4 | Хянан баталгаа хийгдсэн сум суурингийн тоо-7 | Хот тосгон  бусад суурины газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг 2025 онд Баян-Уул 19.5 сая төгрөгөөр, "Эс эм стар геоид" ХХК-аар, Цогт сум 19.0 сая төгрөгөөр "Гранд-Амур" ХХК-аар,  Шарга сум 19.0 сая төгрөгөөр "Геоботаник" ХХК-аар, Төгрөг сум 20.0 сая төгрөгөөр "Вест гео ланд" ХХК-аар тус тус хийлгэн, хүлээн авсан. | 90 |
| | | | | 2025 | ГХБХБГ | | 286 | Газрын фотомониторинг хийгдсэн цэгийн тоо-330 | 18 сумын хэмжээнд 8149010 га бэлчээрийн талбайд 2-7 хоногийн хугацаанд 345 мониторингийн цэгүүдэд хээрийн судалгаа хийсэн. Мал бэлчээрлэх хоногийн тоо өвөл 120 хоног, намар 90 хоног, хавар 60 хоног, зун 90 хоног, боломжит даац нь аймгийн  дундаж  дүнгээр 152992  байгаа бөгөөд хонин толгойд шилжүүлснээр 238444  болж бэлчээрийн даац 85452 хонин толгойгоор хэтэрсэн үзүүлэлттэй байна. | |
| | | | | 2025 | ГХБХБГ | | 287 | Тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн сумын тоо-8 | 2025 оныг “Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил” болгон зарласантай холбогдуулан Алтай, Баян-Уул, Бугат, Бигэр, Дарив, Дэлгэр, Тайшир, Тонхил, Жаргалан, Цогт, Төгрөг зэрэг  нийт 11 сумын газрын даамлыг иж бүрэн компьютер, 3 үйлдэлт принтер, түргэн сканераар хангалаа. | |
| **ГУРАВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.1.Чадварлаг, ухаалаг төрийн албыг төлөвшүүлж, хүний эрхийг дээдэлсэн, авлигагүй төрийн бодлогыг хэрэгжүүлэн, төрийн үйлчилгээг цахимжуулж, үр ашиг, хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | |
| **3.1.1.Чадварлаг, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ.** | | | | | | | | | | |
| 92 | 3.1.1.1.Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулж, амьдралын баталгааг хангана. | 215 | Баян-Уул, Тайшир сумдад иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгыг ашиглалтад оруулна. | 2025 | АЗДТГ, ТЗУХ | УТ-4,853.4 | 0 | Ашиглалт ад орсон барилгын тоо-2 | Баян-Уул сумын иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгыг улсын төсвийн 2,423.0 сая төгрөгөөр "Хонгор буурал" ХХК, Тайшир сумын иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгыг улсын төсвийн 2,430.4 сая төгрөгөөр "Буман хаус" ХХК тус тус барьж ашиглалтад хүлээлгэн өглөө. | 100 |
| | | 216 | Орон сууцжуулах хөтөлбөрт төрийн албан хаагчдыг хамруулна. | 2025 | АЗДТГ, ТЗУХ | | 49 | Дэмжлэг үзүүлсэн албан хаагчийн тоо-50 | Төрийн албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх журмыг шинэчлэн боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар тогтоолоор батлуулсан. Төрийн байгууллагуудаас орон сууцны дэмжлэгт хамрагдах хүсэлтэй, шаардлага хангасан төрийн албан хаагчдын материалыг журмын дагуу хүлээн авч, 12 сард дэмжлэгийг олгохоор ажиллаж байна. | 100 |
| 93 | 3.1.1.2.Төрийн албан хаагчдыг байнга, тасралтгүй чадавхжуулж, харилцаа хандлагыг сайжруулна. | 217 | Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулж, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулна. | 2025 | АЗДТГ, ТЗУХ | | 1100 | Сургалтад хамрагдаг сдын тоо-1200 | Тайлант онд 8 төрийн албан хаагчтай холбоотой ёс зүйн зөрчлийг холбогдох байгууллагууд судлан шийдвэрлэсэн байна. Төрийн албан хаагчдын ёс зүйн мэдлэг, ойлголт, хандлагыг дээшлүүлэх зорилгоор танхимын сургалтыг тогтмол зохион байгуулж, давхардсан тоогоор 1280 төрийн албан хаагчийг хамрууллаа. Ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлд үнэлгээ хийж, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээлэл, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлснээр төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйн түвшинд тодорхой ахиц гарсан байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 218 | “Удирдлагын академи”-тай хамтран төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтыг зохион байгуулна | 2025 | АЗДТГ, ТЗУХ | | 30 | Сургалтад хамрагдагсдын тоо-30 | Удирдлагын академийн анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад 2, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 9, давтан сургалтад 9, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 8, нийт 28 төрийн албан хаагч суралцаж төгсөн, сертификатаа гардан авлаа. 2025 оны намрын элсэлтээр эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 3, нийт 9 албан хаагч суралцаж байна. | 100 |
| 94 | 3.1.1.3.Иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, сахилга хариуцлагыг чангатгана. | 219 | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулна. | 2025 | АЗДТГ, ТЗУХ | | 86 | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь-90 | 2025 оны 11 дүгээр сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 429 өргөдөл, гомдол хүлээн авч 90.2 хувьтай шийдвэрлэлээ. 42 өргөдөл, гомдол хуулийн хугацаандаа судлагдаж байна. Хугацаа хэтэрсэн болон хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн өргөдөл, гомдол байхгүй. Өргөдөл гомдлын тайлан мэдээг улирал бүр нэгтгэн, Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байна. | 100 |
| | | 220 | Төрийн архивын улсын урьдчилсан үзлэгийг зохион байгуулна | 2025 | Төрийн архивын хэлтэс | | 120 | Хамрагдсан байгууллагын тоо-150 | Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын урьдчилсан үзлэгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан шалгуур үзүүлэлт, аргачлалын дагуу 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 09 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд зохион байгууллаа. Үзлэгт аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, нийт 181 байгууллага хамрагдаж, 84.38 хувьтай үнэлэгдлээ. | 100 |
| | | 221 | “Цахим архив-Говь-Алтай” хөтөлбөр хэрэгжүүлж, архивын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлнэ. | 2025 | Төрийн архивын хэлтэс | | 20000 | Цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын тоо-25000 | Үйл ажиллагаа үргэлжилж байгаа 153 байгууллагын баримтад иж бүрэн нягтлан шалгалт хийж, шинэчилсэн данс бүртгэл, устгах баримтын жагсаалтыг боловсруулж, 139 байгууллагын хөмрөгийн жагсаалт, 1992 оноос хойш Монгол Улсын үе (9-р үе) данс бүртгэлийн 90000 хөмрөгийн дугаар шинэчилж, 8109 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, CAMS программд оруулаа. Ингэснээр цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын тоо 28109 боллоо. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 95 | 3.1.1.4.Иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй шуурхай хүргэх зорилтын хүрээнд төрийн байгууллагуудын машин техник, тоног төхөөрөмжийн хангалтыг үе шаттайгаар шийдвэрлэнэ. | 222 | Мал хулгайлах, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх ажилд шаардлагатай автомашинаар хангана. | 2025 | ЦГ | УТ-179,0 | 0 | туулах чадвар сайтай автомашин-1 | Цагдаагийн Ерөнхий газраас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар туулах чадвар сайтай Ланд 76 маркийн автомашиныг аймгийн Цагдаагийн газарт нийлүүлсэн. | 100 |
| **3.1.2.Төрт ёс, хуулиа дээдлэн авилгагүй засаглалыг бэхжүүлж, гэмт хэрэг, зөрчил, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж, хүний эрхийг дээдэлж, хүн нийгмийн аюулгүй байдлыг хангана.** | | | | | | | | | | |
| 96 | 3.1.2.1.Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, зөрчлийг бууруулах, бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлнэ. | 223 | Хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх сургалт зохион байгуулна. | 2025 | АЗДТГ, ХЭЗХ | | 5715 | Хамрагдсан хүний тоо -5800 | Алтай мэдээ агентлаг, Алтай мэдээ радиогоор 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байгаа 12 хуулиар мэдээлэл бэлтгэн 5,000 хүн, авлигын эсрэг 32 видео контент бүтээж Миний Алтай сошиал ТВ, АЗДТГ-ын цахим хуудас, Сүбээдэй.МН сайт, UBS телевизээр иргэдэд түгээн 8,000 иргэний хандалт авсан. 2025 онд дагаж мөрдөх шинээр батлагдсан хууль тогтоомжууд болон бусад хууль тогтоомжийн танхимын 18 удаагийн сургалт, ”Хуульчийн Про боно” өдөрлөг арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 7300 иргэнд эрх зүйн сургалт сурталчилгааны ажлыг зохион байгууллаа. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 97 | 3.1.2.2.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ. | 224 | Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг ханган, хариуцлагыг дээшлүүлнэ. | 2025 | АЗДТГ, ХЭЗХ | | 90 | Хэрэгжилтийн хувь-95 | Албан тушаалд нэр дэвшсэн 140 иргэний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим системд бүртгэн АТГ-т хүргүүлэн, хариу ирснээр албан тушаалд томилуулах ажлыг зохион байгуулан хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Үүнээс 128 иргэн холбогдох хууль, албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагуудыг хангаж ашиг сонирхлын зөрчил үүсээгүй, 12 иргэн тодорхой шалтгаануудаар ажлын байрны шаардлага хангаагүй нь Авлигатай тэмцэх газраас тогтоогдсон байна. Хууль тогтоомж зөрчиж томилгоо хийсэн 7 иргэнд Захиргааны өрөнхий хуульд заасны дагуу сонсох ажиллагаа зохион байгуулж нөхцөл байдлыг тогтоон сахилгын шийтгэл ногдууллаа. Хэрэгжилтийг 100 хувь хханган ажиллаж байна. | 100 |
| | | 225 | Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хханган, авлигын индексийн хувийг ахиулна. | 2025 | АЗДТГ, ХЭЗХ | | 73.3 | Авлигын индекс-76 | “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”,“Авлигын эсрэг хууль”, “Зөрчлийн тухай”, “Эрүүгийн тухай”, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Хуульчийн Про боно” өдөрлөг зэрэг арга хэмжээний хүрээнд 5 удаагийн танхимын сургалт, нөлөөллийн арга хэмжээнд давхардсан тоогоор 7,200 хүн хамрагдлаа.. Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр аймаг, сумын төрийн байгууллагын удирдлагууд ЭБАТ, Хууль, эрх зүйн хариуцсан мэргэжилтэн нийт 95 алба хаагчдад авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлийн видео контент хийх талаар сургалт зохион байгууллаа. Бодлогын шийдэл төрийн бус байгууллагатай хамтран төрийн байгууллагын шударга байдлын талаар судалгааг 165 хүнээс авч ажиллалаа.<br>2025 оны хагас жилийн байдлаар авлигын индекс 76.0 хувьтай байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 98 | 3.1.2.3. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлж, тодорхой төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулж, илрүүлэлтийг нэмэгдүүлнэ. | 226 | Гэмт хэргийн илрүүлэлтийн хувийг нэмэгдүүлж, тодорхой төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулна. | 2025 | ЦГ | | 60.4 | Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь-65 | Аймгийн хэмжээнд 343 гэмт хэрэг бүртгэгдэж, хэргийн илрүүлэлт 63.3 хувь байгаа нь урьд оны мөн үеэс 2.9 функтээр өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр "Уусан бол бүү жолоод", "Аюултай ачаа", "Улсын дугаар", "Гэрэлтүүлэг", "Сар шинэ-2025", "Хуулиа мөрдье", "Цахим архи", "Акц", "Хамгаалах малгай", "Сигнал", "Байгалиа хамгаалъя", "Залилах", "Хуулийн хэрэгжилт", "Хяналт шалгалт", "Мэдэгдэл", "Шөнийн эргүүл", "Дүрмээ мөрдье", "Зөрчил", "Орон нутгийн зам хөдөлгөөний соёл", "Илрүүлэлт", "Гэрэл", "Ачаа тээвэр", "Оюутан тээвэр", "Хичээл эхэллээ", "Тамхигүй ирээдүй", "Тор", "Шийдвэрлэлт", "Мал мах", "Дугуй" зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн 41 арга хэмжээг зохион байгууллаа. | 90 |
| | | | | | | | 20 | Мал хулгайлах гэмт хэргийн гаралтын хувь-19 | Мал хулгайлах гэмт хэрэг 5 бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 5 нэгжээр буюу 50,0 хувиар буурсан үзүүлэлттэй, мал хулгайлах гэмт хэргийн гаралтын хувь 4,2 байна. | |
| | | | | | | | 51 | Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн гаралтын хувь-45 | Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 120 бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 61 нэгжээр буюу 33.7%-аар буурсан үзүүлэлтэй, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн гаралтын хувь 34,9 байна. | |
| 99 | 3.1.2.4. Хуульт ёс, дэг журам аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрх эрх чөлөөг хамгаалах, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн теле хяналтын дэд төвийг байгуулж, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон нийт сумдыг бүрэн | 227 | Сумуудыг бүрэн камержуулж, теле хяналтын дэд төвтэй холбоно. | 2025 | АЗДТГ, ХЭЗХ | ОНТ-109,0 | 2 | Бүрэн камержсан сумын тоо-4 | Дэлгэр сумын 11 цэгт 11 камер, Баян-Уул сумын 7 цэгт 20 хяналтын камер суурилуулж, 9 хяналтын камерыг засварлаж, камерын системийг цахилгаан холбооны шилэн кабельтай холболоо. Дэлгэр, Баян-Уул, Цогт, Алтай сумын камержуулалтыг аймгийн "Теле камерын хяналтын дэд төв"-тэй холболоо. | 100 |
| | | 228 | Үйл ажиллагаа явуулж буй байгуулалга, аж ахуйн нэгжүүдийг теле камерын хяналтын дэд төвтэй холбоно. | 2025 | АЗДТГ, ХЭЗХ | ХХО 203,0 | 10 | Холбогдсон байгууллага, аж ахуйн нэгжийн тоо-15 | Нийт аж ахуйн нэгж, байгууллагын 34 камерыг "Теле камерын хяналтын дэд төв"-д холболоо. Аймгийн төвд шатахуун, тос тослох материалын үйл ажиллагаа эрхэлдэг 17 шатахуун түгээх станц байгаагаас 2-3 салбартай 5 аж ахуйн нэгж байна. Камержуулалтыг шинэчлэн аймгийн "Теле хяналтын дэд төв"-д холбох ажлыг зохион байгуулах чиглэлээр 5 шаардлагыг хүргүүлэн, биелүүлээгүй 1 аж ахуйн нэгжид 2,5 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авлаа. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | камержуулж, теле хяналтын дэд төвтэй холбоно. | 229 | Есөнбулаг сумын аймгийн төв рүү орох чиглэлийн пост, Дэлгэр сумын постыг түшиглэн дундаж хурдны хяналтын камер суурилуулна. | 2025 | ЦГ | УТ-395,0 | 0 | Суурилуулсан камерын тоо -1 | Улсын төсвийн хөрөнгөөр хэвтээ тэнхлэгийн улсын чанартай А-0303, А-0304 авто зам дагуу 3 цэгт дундаж хурдны 3 камер хяналтын камер суурилууллаа. | 100 |
| **3.1.3.Төрийн үйлчилгээг цахимжуулж, шинэ дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлж, төрийн албаны чанар, хүртээмж, бүтээмжийг сайжруулна.** | | | | | | | | | | |
| 100 | 3.1.3.1.Төрийн үйлчилгээг очиж биш, байгаа газраасаа авах, төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл явцад иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөл бүрдүүлж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлнэ. | 230 | Төрийн үйлчилгээний шат дамжлагыг багасган, иргэдийг цахимаар төрийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлнэ. | 2025 | ТЦҮХ | - | 12500 | Цахимаар үйлчилгээ авсан иргэдийн тоо-17500 | Аймгийн ИТХ-ын 2025.03.31-ны өдрийн 10 дугаар тогтоолоор Цахим-Алтай хөтөлбөрийг батлуулан үндсэн 4 зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд нийт 22 "Хурдан цэг"-ээр дамжуулан 43 байгууллагын 473 төрлийн 15399 лавлагаа, тодорхойлолтыг иргэн болон хуулийн этгээдэд гаргаж үйлчиллээ. Киоск машинаар 2025 оны 11 сарын байдлаар 9514 лавлагаа үйлчилгээ авлаа. Давхардсан тоогоор нийт 24913 иргэн үйлчлүүллээ. | 100 |
| | | 231 | Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлнэ. | 2025 | ТЦҮХ | - | 74 | Мэдээллийн ил тод байдлын үнэлгээ-80 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор shilen.gov.mn сайтад 200 байгууллага бүртгэл хийн баталгаажуулж эрх нээлээ. Ил тод байдлыг хангах, мэдээллийг бүрэн оруулах чиглэлээр shilen.gov.mn системийн сургалтыг төрийн 175 байгууллагын 358 албан хаагчдад 6 удаагийн давтамжтай зохион байгууллаа. 2025 оны 11 сарын 10-ны байдлаар 164 байгууллага мэдээллийн ил тод байдлын тайланг системд байршуулж, 187 төрийн байгууллага төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган, тайлангаа илгээн хянан баталгаажуулсан байна. Төсөв санхүүгийн ил тод байдлын хэрэгжилт 95.61 хувьтай байна. "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах, ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын дагуу мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт 85 хувьтайгаар Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт дүгнэгдлээ. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 101 | 3.1.3.2.Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны шинэ дэвшилтэт технологиуд, инновацыг нэвтрүүлж, "Цахим-Алтай" хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ. | 232 | Төрийн үйлчилгээнд шинэ дэвшилтэт технологи, инноваци нэвтрүүлнэ | 2025 | ТЦҮХ | - | 2 | Шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлсэн үйлчилгээний тоо-1 | Аймгийн хэмжээнд18 сумыг киоск машинаар хангаж, 60 байгууллагын 600 гаруй үйлчилгээг өдөр бүр 24 цагийн хугацаанд байршил, цаг хугацаанаас үл хамааран авах боломжийг бүрдүүллээ. | 100 |
| 102 | 3.1.3.3.Алслагдсан сум, суурин болон багуудад үүрэн холбооны сүлжээг нэмэгдүүлж, 3G, 4G сүлжээ нэвтрүүлнэ. | 233 | Багуудын үүрэн холбооны сүлжээг өргөтгөнө. | 2025 | ТЦҮХ | - | 0 | Хамрагдсан багийн тоо-7 | Шарга сумын Сондуулт, Улаантуг багт мобикомын сүлжээ орсон. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Шарга сумын Хамтын хүч багт үүрэн холбооны сүлжээ нэвтрүүлэх ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаа зарлагдсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Төгрөг сумын Хүрэнгол, Халиун сумын Чацран, Тонхил сумын Алтансоёмбо, Баян-Уул сумын Баянговь, Эрдэнэ сумын Цэцэгнуур, Цагаан-Уул, Есөнбулаг сумын Рашаант, Тонхил сумын Баян-өндөр багийн 8 байршилд үүрэн холбооны сүлжээг өргөтгөхөөр тусгагдсан боловч төсвийн тодотголоор төсөв татагдсан тул хэрэгжүүлэх боломжгүй болсон. | 90 |
| **3.1.4.Төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, үр өгөөж, ил тод байдал, хяналтыг сайжруулна.** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 103 | 3.1.4.1.Орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх, төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, үр өгөөж, хяналтыг сайжруулна | 234 | Өмч хувьчлал болон түрээсийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлнэ. | 2025 | ОНӨГ | - | 100 | Тухайн онд төвлөрүүлэх эх орлогын хувь-100 | Аймгийн ИТХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор 5 барилга байгууламж, 24 тээврийн хэрэгсэл худалдан борлуулахаар шийдвэрлэж, хөрөнгийн балансын үнийг зах зээлийн бодит үнэлгээнд нийцүүлэн мэргэжлийн үнэлгээний байгууллагаар шинэчлэн тогтоолгож, 50.0 сая төгрөгийн орлого төлөвлөснөөс нээлттэй дуудлагын худалдаагаар 53.0 сая төгрөгийг орон нутгийн өмч хувьчлалын орлогын дансанд төвлөрүүллээ. Орон нутгийн өмчит 9 байгууллагын илүүдэлтэй байр талбайг 33 иргэн, аж ахуй нэгжид түрээслүүлж, 6.8 сая төгрөгийн орлого төлөвлөснөөс 12.0 сая төгрөгийг төвлөрүүллээ. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар 3,0 сая төгрөгийн заалны түрээсийн орлогыг нөхөн төвлөрүүллээ. | 100 |
| **3.1.5.Иргэний нийгэм, хувийн хэвшил, төрийн байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагааг сайжруулна.** | | | | | | | | | | |
| 104 | 3.1.5.1.Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин, хамтран ажиллана. | 235 | Иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжиж, төрийн зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлнэ. | 2025 | АЗДТГ, НБХ | ОНТ-211.2 | 4 | Хамтарч ажилласан төрийн бус байгууллагын тоо-5 | “Төр, төрийн бус байгууллагын түншлэл” сургалт, уулзалтыг 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж, төр, төрийн бус байгууллагын төлөөлөл 60 гаруй хүн оролцлоо. Ахмадын хороонд 150.1 сая, “Хууль дээдлэх ёс” ТББ-д 19.8 сая, “Алтайн ирвэсүүд” клубт 3,0 сая, аймгийн хөлбөмбөгийн холбоонд 14,0 сая, аймгийн үндэсний сурын холбоонд 13,0 сая, Хантайшир бөхийн дэвжээнд 1,8 сая, Оюун ухааны академийн Говь-Алтай салбарт 6,1 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аймгийн салбар зөвлөлд 3.4 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Естийн аманд хүлэмжийн аж ахуй байгуулах ажлыг “Фермер эмэгтэйчүүдийн холбоо” ТББ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүллээ. | 100 |
| **3.2.Орон нутгийн сөрөн тэсвэрлэх чадавхыг хамгаална.** | | | | | | | | | | |
| **3.2.1.Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 106 | 3.2.1.2.НҮБ, олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулж, орон нутагт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. | 236 | Орон нутагт хэрэгжих олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран ажиллана. | 2025 | АЗДТГ, ТЗУХ | - | 1 | Нэмэгдсэн төсөл хөтөлбөрийн тоо-1 | Гадаадын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр байгаль орчны чиглэлээр байнгын 2 төсөл, бүтээн байгуулалтын чиглэлээр 2, гэр бүл, хүүхэд хамгааллын чиглэлээр 4, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх чиглэлээр 4, хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр 2, нийт 14 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Тайлант онд "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөн, Туркийн хамтын ажиллагааны зохицуулах агентлаг "ТИКА" төслийн санхүүжилтээр эрүүл, шим тэжээлтэй, стандартад нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр иргэдийг хангах зорилгоор мах хадгалах, хөргүүртэй тус бүр 40тн-ын багтаамжтай 2 ширхэг контейнерыг хүлээн авлаа. Мөн “Оиска Монгол” нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг байгуулан орон нутгийн хөгжил хамтын ажиллагаа, байгаль орчинг хамгаалах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хөдөө аж ахуй, ойн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх мөн тухайн салбарын мэргэжилтэн солилцоо, туршлага судлуулах чиглэлээр хамтран ажиллахаар боллоо. | 100 |
| **3.2.2.Гамшгийн үеийн бэлэн байдлын хамгаалалтын тогтолцоог нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | |
| 107 | 3.2.2.1.Гамшгийн бэлэн байдлыг хангаж, эрэн хайх, аврах нэгжийг байгуулан, тусгай зориулалтын автомашин, техник хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлнэ. | 237 | Сумдад гамшгаас хамгаалах иж бүрэн, команд штабын дадлага, сургууль, бэлэн байдлын үзлэг зохион байгуулна. | 2025 | ОБГ | ОНТ-13.5 | 8 | Зохион байгуулсан дадлага, сургууль, үзлэгийн тоо -4 | “Иж бүрэн болон команд штабын сургууль зохион байгуулах хуваарь, төлөвлөгөө”-ний дагуу Алтай, Шарга сумдад гамшгаас хамгаалах “Иж бүрэн”, Тайшир, Есөнбулаг сумдад гамшгаас хамгаалах “Команд штаб”-ын дадлага, сургуулийг зохион байгуулж, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн томилгоот 1100 албан хаагч, 72 техник хэрэгслийг бүрэн хамруулсан. Нийт 13.5 сая төгрөгийг зарцуулсан. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 238 | Уур амьсгалын өөрчлөлт, байгаль цаг агаарын нөлөөлөл болон бусад эрсдэлийг даван туулах хариу арга хэмжээг шуурхай авах зорилготой эрсдэлийн удирдлагын цогц бодлого төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | 2025 | ОБГ | - | 55 | Гамшгийн эрсдэлийн дуудлага, мэдээллийн тоо-50 | Обьектын гал түймрийн 18 удаагийн дуудлага бүртгэгдэж, 44.61 тонн гал унтраах бодис, 526.2 литр шатахуун зарцуулан, 610,500,000 төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгааллаа. Галын улмаас иргэн, аж ахуйн нэгжид 256,882,865 төгрөгийн хохирол учирсан байна.<br>Эрэн хайх, аврах ажиллагааны 8 удаагийн дуудлагаар 19 иргэний амь насыг авран хамгаалсан.<br>Урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг 2983, ухуулга сурталчилгааг 3142, санамж, зөвлөмжийг 2983 иргэнд хүргэлээ.<br>Болзошгүй аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээ, мэдээлэл 11 удаагийн багц мессежийг давхардсан тоогоор 87552 иргэнд хүргэлээ. | 100 |
| 108 | 3.2.2.2.Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын чанар, хүртээмжийг сайжруулах, цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлыг тогтмолжуулна. | 239 | Аймгийн хэмжээнд дулааны улиралд орох хур тунадасны хэмжээг нэмэгдүүлнэ. | 2025 | УЦУОШТ | | 13 | Цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээний тоо-17 | 2025 онд ЦАЗН экспедиц 12 удаагийн ажиллагаанд 24ш пуужин харваж 72гр урвалж зарцууллаа. 2025 оны 8 дугаар сарын 20-ны байдлаар нийт нутгийн 78.9 хувьд буюу Есөнбулаг, Алтай, Тоорой тосгон, Хөхморьт, Баян-Уул, Бигэр, Гуулин, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Халиун, Цээл, Чандмань, Шарга, Эрдэнэ сумдын нийт нутаг, Бугат сумын зарим нутагт хэвийн буюу сайн, 21.1 хувьд буюу Тонхил, Дарив, Цогт сумдын нийт нутгаар, Бугат сумын зарим нутагт дунд зэрэг үнэлгээтэй, муу үнэлгээтэй газар байхгүй тул цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээг явуулах шаардлага үүсээгүй болно. | 100 |
| | | 240 | Цаг агаарын бодит мэдээний чанарыг сайжруулж, автомат станц суурилуулна. | 2025 | УЦУОШТ | | 1 | Суурилуулсан автомат станцын тоо-2 | "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II,III төсөл"-ийн санхүүжилтээр Баян-Уул, Бигэр сумдад Финлянд улсын Vaisala үйлдвэрийн AWS-310B цаг уурын хэмжлийн бүрэн автомат станцыг угсарч суурилуулах ажлыг 2025 оны 05 дугаар сард УЦУОШТ-ийн инженер техникчид хийж гүйцэтгэн улсын сүлжээнд нэвтрүүлсэн. | 100 |
| **3.2.3.Батлан хамгаалах бодлого үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлж, ард иргэдэд сурталчлах, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бэлэн байдлыг хангаж, орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний анги, салбарыг оролцуулна.** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 109 | 3.2.3.1.Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бэлэн байдлыг хангаж, дайчилгааны төлөвлөлтийг боловсронгуй болгож, иргэдийн эх орноо хамгаалах бэлтгэлжилтийг дээшлүүлнэ. | 241 | Сумдын дайчилгааны төлөвлөгөөг батлуулна. | 2025 | АЗДТГ, ЦШ | | 0 | Дайчилгааны төлөвлөгөө батлуулсан сумын тоо-18 | Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарын цэргийн бэлтгэл сургалтыг 01 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтын хүрээнд орон нутгийн хамгаалалтын тухай хууль, орон нутгийн хамгаалалтын талаар мэдээлэл хийж, хуулийн хэрэгжилтийг хангаан ажиллах, сумдууд өөрсдөө нөөц бүрдүүлэх талаар чиглэл өгсөн. Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, сумдын орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний хээрийн дадлага сургалт, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгж, болон удирдах бүрэлдэхүүний сургалтыг ЗХЖШ-ын сургалтын хөдөлгөөнт бүлэгтэй хамтран 2025 оны 10 сарын 27-29-ний өдрүүдэд зохион байгууллаа. Завхан аймагт зохион байгуулагдсан баруун бүсийн сумдын ЗДТГ-ын дарга нарын цэргийн бэлтгэл сургалтад 18 сумын ЗДТГ-ын дарга нар хамрагдаж, тус сургалтаар сумдын дайчилгааны төлөвлөгөө боловсруулах арга, аргачлалыг зааж, сумын дайчилгааны төлөвлөгөөг боловсруулан батлуулахад бэлэн болсон. | 100 |
| 110 | 3.2.3.2.Батлан хамгаалах үйл хэргийг иргэдэд сурталчилж, хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх, оюутан цэргийн тоог нэмэгдүүлнэ. | 242 | Батлан хамгаалах чиглэлээр иргэдэд үзүүлэх ажил үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | 2025 | АЗДТГ, ЦШ | | 6 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо-7 | Мөрдөстэй бүсгүйчүүд чуулга уулзалт, “Цол бүхэн сайхан” нэрэмжит тэмцээн, марш-тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг, бүлэг шалгаруулах тэмцээн, иргэдийн дунд “Засагт хан” буудлагын холбоотой хамтран буудлагын 3 төрөлт тэмцээн, ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд автоматын задаргаа, угсаргаа, магазин сумалгааны тэмцээн, "Эх оронч Монгол-Өвлөн наадъя", "Хугацаат цэргийн алба хаагчийн нэг өдөр" арга хэмжээ, “Эх орон” хүндэтгэлийн тоглолтыг тус тус зохион байгууллаа. Аймгийн аварга шалгаруулах аймгийн Засаг даргын нэрэмжит цэрэг -спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг 2 үе шаттай зохион байгууллаа. “Эх оронч Монгол” нээлттэй хичээл, "Эх оронч үзэл-Үндэсний бахархал" сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг ахлах ангийн сурагчдын дунд зохион байгууллаа | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 8 | Оюутан цэргийн тоо-10 | Засгийн газрын 2025 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтын журам”, Батлан хамгаалахын сайдын 2025 оны “Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалт зохион байгуулах тухай А/43 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2025 оны А/130 дугаар захирамжийн дагуу АШУҮИС-ийн салбар сургуулийн 1-3-р курсын оюутнуудаас E-mongolia цахим системээр бүртгүүлсэн оюутнуудыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, биеийн тамирын шалгалтад хамруулан, тэнцсэн 11 оюутанг элсүүлж, цэргийн ерөнхий бэлтгэл шатны хичээл сургалтыг зохион байгуулж, Зэвсэгт хүчний 123 дугаар ангид мэргэжлийн бэлтгэл шатны хичээл, сургалтад хамрууллаа. | |
| 111 | 3.2.3.3.Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийг хугацаат цэргийн алба хаагчидтай болох орчинг бүрдүүлж, орон нутгийн бүтээн байгуулалтад ажиллах боломжийг бий болгоно. | 243 | Цэргийн алба хаагчдын орон нутгийн бүтээн байгуулалтад оролцох оролцоог нэмэгдүүлнэ. | 2025 | АЗДТГ, ЦШ | | 3 | Оролцсон бүтээн байгуулалтын ажлын тоо-3 | Тус ангийн хугацаат цэргийн алба хаагчийн байрын барилгыг ашиглалтад оруулсан. Ангийн алба хаагчдын орон сууцны барилгын ажил 80 хувьтай явагдаж байна. Мазаалайн хөшөөний уулзвараас урагш 350м автозамын давхар хучилтын ажлыг гүйцэтгэлээ. Алтай сум дахь Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 304 дүгээр салбарын албан хаагчдын 8 айлын орон сууцны барилгыг барьж ашиглалтад оруулаа. 2025 оны хоёрдугаар ээлжийн хугацаат албаны цэрэг татлагаар тус ангид хугацаат цэргийн алба хаагчдыг орон нутгаасаа авлаа. | 100 |
| ДӨРӨВ.БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | | | |
| **4.1. Орон нутагт чөлөөт бүс, тусгай бүс, аж үйлдвэрийн парк байгуулж боомт, хөрш орны хотуудтай холбох, Засгийн газрын хөтөлбөр, зорилготой нийцүүлэн татварын хөнгөлттэй бүс байгуулан ажиллахыг зорино.** | | | | | | | | | | |
| **4.1.1. "Эрчим хүчний төрөлжсөн бөгөөд байгалийн аялал жуулчлалын дэд бүс" болох зорилтыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 112 | 4.1.1.1.Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Говь-Алтай аймаг дахь салбар сургуулийн үйл ажиллагааг дэмжиж, баруун бүсийн эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ. | 244 | Говь-Алтай аймаг дахь АШУҮИС-ийн эмнэлгийн барилгыг ашиглалтад оруулна. | 2025 | АЗДТГ, БОНХО БТХ | | | - | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь - 20 | Говь-Алтай аймаг дахь АШУҮИС-ийн эмнэлгийн барилгын 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн АТД-82-0020/25 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгаврыг боловсруулсан. Хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй байна. | 70 |
| 115 | 4.1.1.4.Босоо тэнхлэгийн тээвэр ложистикийн баруун бүсийн төв болох ажлыг эхлүүлнэ. | 245 | Босоо тэнхлэгийн тээвэр ложистикийн баруун бүсийн төв болох ажлыг эхлүүлнэ. | 2025 | АЗДТГ, БОНХО БТХ | | | - | Ажлын гүйцэтгэлийн хувь-10 | Улсын төсвийн 3244.7 сая төгрөгийн хөрөнгөөр аймгийн төвд Зорчигч тээврийн төвийн барилгыг “Мөрөн-Алтай” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 50 хувьтай. Төмөр зам, агаарын тээврийн нэвтрүүлэх ажлын судалгаа, ТЭЗҮ боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. | 100 |

__o0o__